

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 11
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12 - 149
1.	<i>Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	13 – 29
2.	<i>“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	29 – 56
3.	<i>Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсох</i>	56 – 67
4.	<i>Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох</i>	67 – 125
5.	<i>Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад, дотоод өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох</i>	126 – 149

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Б.Жаргалан, Б.Мөнхсоёл, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Э.Батшугар, Ж.Ганбаатар.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын референт Ж.Даваахүү, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47² дугаар зүйл. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр

47².1.Энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай төлбөрийг энэ хуулийн 47².2-т заасан хувь, хэмжээгээр тооцож төлнө.

47².2.Энэ хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, А.Мандуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, “Мон-Атом” ХХК-ийн ахлах геологич А.Алтанхундага, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Дотоодын хуулийн зөвлөх Г.Мөнхболд, Б.Батмандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын референт Ж.Даваахүү, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлтүүд болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Д.Соронзонболд, М.Бадамсүрэн, Г.Уянгахишиг, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Усны газрын дарга З.Батбаяр, “Мон-Атом” ХХК-ийн ахлах геологич А.Алтанхундага, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр нар хариулж, тайлбар хийв.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дэх заалтын “MV-018915 дугаартай “Дулаан-Уул” гэснийг “MV-018916 дугаартай “Дулаан-Уул” гэж, “MV-018916 дугаартай “Зөөвч-Овоо”

гэснийг “MV-018915 дугаартай “Зөөвч-Овоо”” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дахь заалтыг “Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1/төрийн эзэмшлийн 10 хувийн давуу эрхийн хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

2/нийт гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцаанд эзлэх төрийн эзэмшлийн хувь хэмжээг 10 хувиас бууруулахгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1/төрийн эзэмшлийн 10 хувийн давуу эрхийн хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

2/нийт гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцаанд эзлэх төрийн эзэмшлийн хувь хэмжээг 10 хувиас бууруулахгүй байх.” гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “төрийн эзэмшлийн 34 хувийн” гэсний дараа “энгийн” гэж нэмж, мөн заалтын “10 хувийн” гэдгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 11
Бүгд: 16
31.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Пүрэвдорж нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 11
Бүгд: 16
31.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан, Төслийн хавсралтын “40-өөс 50 хүртэл 0.5%” гэснийг “40-өөс дээш 5%” гэж өөрчилж, “50-иас дээш 5%” гэсэн мөрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга З.Лхагвадорж, Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын референт Ж.Даваахүү, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Мандхай, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Баярхүү, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга Л.Балчинлуvsан, мөн газрын Төслийн нэгдсэн удирдлага, мониторингийн хэлтсийн дарга Л.Бат-Эрдэнэ, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн О.Энхмөнх, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал Г.Дэнзэн, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч С.Дэмбэрэл, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн захирал М.Амгаланбаатар, Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын референт Ж.Даваахүү, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Батсүмбэрэл, Л.Соронзонболд, М.Бадамсүрэн, Г.Лувсанжамц, М.Мандхай, О.Батнайрамдал, П.Батчимэг, М.Энхцэцэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад, дотоод өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын референт Ж.Даваахүү, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад, дотоод өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Сангийн сайдын мэдээллийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, М.Бадамсүрэн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Сангийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 20 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 51 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 20 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 52 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Та бүхэндээ шинэ оны мэнд хүргэе.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, П.Сайнзориг, Л.Соронзонболд, А.Ундраа, Б.Найдалаа, Д.Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Албан ёсоор Х.Баттулга гишүүн, Б.Батшугар гишүүн, Б.Жаргалан гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн нар чөлөөтэй.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирц 52 хувьтай байна.

Гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хоёр. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 2024 оны 12 сарын 25-нд Засгийн газраас яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

Гурав. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсох.

Дөрөв. Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох.

Тав. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад, дотоодын өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Сангийн яамны мэдээллийг сонсох гэсэн ийм 5 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Нэгдүгээр асуудал.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл гишүүн байна уу? Б.Жаргалан гишүүн, Н.Батсүмбэрэл гишүүн хоёр байхгүй байна.

Ийм учраас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэндээ уншиж танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт

малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбат асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаагүй бөгөөд төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд Төсвийн байнгын хороо 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа уг хуулийн төслүүдийг хэлэлцлээ.

Байнгын хороо хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төрийн эзэмшлийн 34 хувийн ашиг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж байгаа 24 хувь нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу хуваарилдаг тусгай болон өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүнгийн зөрүүний талаар асуулт асууж хариулт авсан.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй бөгөөд хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Р.Батболд гишүүнд баярлалаа.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 338 дугаар захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг

байгуулж ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Г.Тэмүүлэн, А.Ариунзаяа, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Ж.Баярмаа, Ж.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Б.Уянга, Г.Уянгахишиг, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, Б.Энхбаяр, С.Эрдэнэбат болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажиллалаа.

Ажлын хэсэг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг хэлэлцэж, зарчмын зөрүүтэй санал гаргаагүй бөгөөд төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулгыг нийцүүлж өөрчлөх найруулгын саналыг хэлэлцэн дэмжиж Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, төслийн 3 дугаар зүйлийг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын Хуримтлалын сан энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас дараах зарчмаар хуваарилсан эх үүсвэрээс бүрдэнэ гэснийг хуримтлалын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж өөрчилсүгэй гэж хуулийн техникт нийцүүлэн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхэд найруулгын засварыг төсөлдөө тусгахаар тогтсон болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Б.Пүрэвдорж гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Чойгонсүрэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Цэдэнбалжирын Төгсбуян “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Лувсаншаравын Наранчимэг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.
М.Бадамсүрэн гишүүнээр тасаллаа.

М.Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Энэ өргөн мэдүүлж байгаа хуулийн төслийг дэмжиж байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль бол их чухал ийм хуулийг өнгөрсөн Засгийн газар өргөн мэдүүлж, өнгөрсөн хугацаанд ажилласан парламент баталсан нь манай өмнөх Их Хурал, Засгийн газрын шийдсэн нэг маш том үйл явдал гэдгийг зориуд хэлье гэж бодож байна.

Төрийн ажил залгамж чанартай байх ёстой.

Энэ үүднээсээ “Баялагтаа эзэн Монгол” гээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн хөтөлбөр, Ерөнхий сайдын дэвшүүлсэн баялгаас ард иргэдэд хуваарилах энэ хуваарилалтыг шударга байлгах. Энэ их том алхам хийгдэж байгаа нэг зүйл гэдгийг зориуд хэлэх нь зүйтэй.

Энэ хүрээндээ Үндэсний баялгийн сангийн тухай хууль 3 сантай.

▷ Нэгдүгээрт нь, *ирээдүйдээ хадгална.*

▷ Хоёрт нь, *одоогийн иргэдэд хуваарилна.*

▷ Гурав дахь нь, *тодорхой томоохон дэд бүтэц, хөрөнгө оруулалтуудыг хийхэд зориулсан* ийм “Хөгжлийн сан” байгаа.

Тэгэхээр энэ хөгжлийн санд төвлөрүүлсэн нэлээд хэдэн 100 тэрбум төгрөг байгаа юм билээ.

Энэ зүйлээсээ нэгдүгээрт эрчим хүчний чиглэлээр хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж эхлүүлэх ийм төлөвлөсөн зүйл Засгийн газарт байгаа юу?

Тухайлбал, манай Дорнодын Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 мегаваттаар өргөтгөхөд үүний дөрөвний гурвыг нь гаднын банкны зээлээр, дөрөвний нэгийг нь Монгол Улсын төрөөс хариуцаад эргээд дөрөвний гурвынхаа зээлийг тухайн станц өөрийнхөө орлогоос төлөхөөр 10 жилийн хугацаатай гэрээ байгуулж хийгдсэн нэг ийм загвар төсөл хэрэгжсэн л дээ.

Яг үүнтэй адилхан энэ эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэхийн тулд цаашдаа эндээс ийм хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсөн зүйл байгаа юу? Нэг.

Хоёрдугаарт нь, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд цаашид нөхөн сэргээгддэггүй буюу газрын хэвлий доорх баялгийг ашиглаж байгаа. Эндээс олсон орлогыг хуримтлуулж байгаа. Эндээс олсон орлогыг ирээдүйдээ хадгалж байгаа.

Тэгэхээр нөхөн сэргээгддэггүй салбараас олж байгаа энэ орлогоос нөхөн сэргээгддэг салбар буюу хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбартаа зориулдаг ийм тодорхой сантай болох, ийм эх үүсвэртэй болох ийм бодлого Засгийн газарт байгаа юу? Цаашдын төлөвлөлтөд.

Тэгээд ийм 2 зүйл дээр хариулт авъя гэж бодож байна.

Р.Сэддорж: Хариулт 4 номер. Н.Учрал сайд

Н.Учрал: М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь Үндэсний баялгийн сангийн хууль өнгөрсөн парламент батлагдсанаар Үндсэн хуулийн 6.2 хэрэгжих бололцоо бүрдсэн.

Энэ ч утгаараа Засгийн газар дээр Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нэгд нөгөө стратегийн орд эзэмшигч компаниудтай хэлэлцээр хийх ажил үргэлжилж байна. 7 компани хүсэлтээ тавьсан. Засгийн газартай хэлэлцээр хийе.

Үүнд Та бүхний энэ хэлэлцэж байгаа Үндэсний баялгийн сангийн хуулийн тусгай АМНАТ-ийн босгыг байхгүй болгоод, төрийн эзэмшлийн 34 хувийг “тусгай АМНАТ”-аар бүтээгдэхүүн хуваахаар орлуулах бололцоог бий болгож байгаа Үндэсний баялгийн сангийн хууль маш том нэмэр болно.

Нэг ёсондоо төрийн эзэмшлийн 34 хүртэлх хувийг “Хуримтлалын сан” руу авдаг байсныг “тусгай АМНАТ”-аар орлуулсан байсан ч түүнийг нь “Баялгийн сан” руу хийдэг. Тэр дундаа өнөөдрийн иргэдэд хуримтлалын данс руу нь хийдэг энэ бололцоог хуулиар бий болгож байгаа нь цаашдаа Засгийн газар хэлэлцээр хийхэд маш том эрх зүйн орчныг нээж өгч байгаагаараа давуу талтай.

Ингээд энэ Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсаны дараа бид хэлэлцээрт ороод тэр томоохон төслүүдийг яг энэ олон улсын хамтын хөрөнгө оруулалтын гэрээнүүдтэй адилхан дотооддоо ч гэсэн заавал менежмент нь оролцохгүйгээр ийм төслүүдийг урагшлуулна.

Таны хэлж байгаа тэр томоохон төслүүд дээр хэрвээ төр эзэмшлийнхээ хувь, хэмжээг тодорхой хэмжээнд тогтооё гэвэл үүн дээр хуримтлагдсан үр өгөөж нь өөрөө тэр “Хөгжлийн сан” руу ордог, “Ирээдүйн өв сан” руу ордог ийм тогтолцоо нэгэнт бүрдсэн.

Тийм учраас цаашдаа гадаадын хөрөнгө оруулалтуудыг татаж оролцуулахад бид хэлэлцээр хийгээд, түүнийгээ хуримтлалын сан руу, эсвэл “Ирээдүйн өв сан” руу, “Хөгжлийн сан” руу хийх ийм бололцоог бүрдүүлнэ.

Тэгээд цаашдаа Засгийн газраас Их Хуралд танилцуулж байгаа энэ олон хөрөнгө оруулалтын гэрээнүүд, энэ мега төслүүдийн хуримтлал “Баялгийн сан” руу л очих ийм л нөхцөл бүрдсэнээрээ иргэн болгонд өнөөдөр хэдийгээр 138 мянган төгрөг харагдаж байгаа хэдий ч төсөл урагшлах болгонд энэ тоо нэмэгдэх энэ бололцоо бүрдэнэ гэж ойлгож болно.

Тийм учраас хэдийгээр таны яг ярьж байгаа тэр эрчим хүчний төслүүд дээр яг бид тодорхой дэвшил гаргачихсан, яг яригдсан, хэлэлцсэн зүйл байхгүй байгаа ч гэсэн үүн дээр гадаадын хөрөнгө оруулагч нартаа нээлттэй хэлэлцээ хийгээд, цаашдаа төр хувь хоёр хамтраад асуудлаа шийдвэрлээд явах бололцоо бүрэн дүүрэн байгаа.

Өнөөдрийн батлах энэ Үндэсний баялгийн сангийн хуулийн нэмэлт, өөрчлөлт ч гэсэн энэ рүү чиглэж байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: А.Учрал сайд аа, би хоёр асуулт асуусан юм.

Нэгдүгээрт нь, “Хөгжлийн сан”-д хуримтлагдсан байгаа 250 орчим тэрбум төгрөг байгаа юм байна гэж ойлгож байгаа.

Энэ хөрөнгөөс дэд бүтцийн, тэр дундаа эрчим хүчний реформыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг эхлүүлэх Засгийн газрын бодлого байгаа юу? Нэг.

Хоёрдугаарт нь, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд орж байгаа мөнгө маань нөхөн сэргээгдэхгүй салбараас орж байгаа хөрөнгө, хуримтлал учраас эндээс иргэндээ зарцуулахаас гадна, ирээдүйдээ хуримтлуулахаас гадна нөхөн сэргээгддэг хөдөө аж ахуйн салбартаа зарцуулах уу гэдэг зүйлийг асууж байгаа юм. Тухайлбал, нэг хэсэг уул уурхайн компаниудыг та нар хөдөө аж ахуйн салбарт заавал хөрөнгө оруул гэдэг ийм зарчим, чиглэлийг тухайн үед төр засгаас өгдөг байсан.

Тийм ч учраас энэ нь өөрөө сэргээгддэг, сэргээгддэггүй гэдэг ийм хоёр юм байгаа шүү дээ. Одоо манай эх орны тухай дуу хүртэл байгаа шүү дээ. “Хөдөө тал минь малаар дүүрэн, хөрсөн доороо эрдэнээр арвин” гээд.

Тэгэхээр энэ концепцыг яаж цаашид уялдуулах юм бэ гэдэг зүйлийг л асуугаад байгаа юм л даа. Ийм хоёр тодорхой асуулт.

Р.Сэддорж: Н.Учрал сайд. 4 номер нэмж хариулъя.

Н.Учрал: “Ирээдүйн өв сан” бол ирээдүйд хуримтлуулах буюу ирээдүй, хойч үедээ өвлүүлэх ийм сан. Нөгөө АМНАТ-ийн 65 хувь, үлдсэн хэсэг нь “Тогтворжуулалтын сан”, “Орон нутгийн сан”-д хуримтлагдаж байгаа.

“Хөгжлийн сан” дээр буюу Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт батлагдсан нийгэм, эдийн засгийн төслийг хэрэгжүүлэхэд энэ Хөгжлийн санг зарцуулна.

Тэгэхээр тэр Хөгжлийн сан дээр үүссэн, хуримтлагдсан орлогыг яг таны хэлж байгаа тэр тухайн төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулж болно.

Тэгэхээр бид яаж хуримтлалыг өсгөх вэ л гэдэг бодлого руу явах ёстой.

Тийм учраас Хөгжлийн сан дээр үүсэж байгаа эх үүсвэр буюу нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд тухайн жилийн орлогын 50 хувь ийшээ орж байгаа.

Тэгэхээр цаашдаа хэрвээ нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай гараад, тэр 50 хувь нь тийшээ шилжвэл ер нь одоо ингээд тооцоолсноор 2030 он гэхэд 508. Тэр 257 бол 508 руу хүрэх юм билээ.

Тэгэхээр үүнийг яг таны ярьж байгаа тэр төслүүд рүү санхүүжүүлэх бололцоо бүрэн бий болж байна л гэсэн үг. “Хөгжлийн сан” зориулалт нь л энэ шүү дээ.

“Ирээдүйн өв сан” мэдээж ирээдүй хойчдоо. Өнөөдрийн 34 бол одоо бидний хэлэлцэж байгаа яг өнөөдрийн иргэдэд “орон сууц”, “боловсрол”, “эрүүл мэнд” рүү зарцуулна. Үүнийг бид та юундаа зарцуулах вэ, эсвэл хадгаламж хэлбэрээр авч үлдэх үү, эсвэл зарцуулах уу гэдгийг нь шууд нээж өгч байгаа юм. Нээх бололцоог нь бүрдүүлнэ гэсэн үг.

Тэгэхээр хөгжлийн сан дээр хуримтлагдсан энэ дүнг саяын таны ярьж байгаа төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулах бүрэн бололцоо бий болж байна гэж ойлгож болно. Тийм.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн нэг гишүүн байна. Г.Уянгахишиг гишүүн.

Ашигт малтмалын тухай хуулийн заалтын найруулгын хувьд зөв болгох.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47² дугаар зүйл. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны.

Энэ дээр дараагийн асуудал дээр оруулах санал.

Ингээд 1 дүгээр асуудал дээр байхгүй байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? 3 дугаар зүйл дээр алга байна. /алх цохив/

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Асуулт алга байна. /алх цохив/

Сая Б.Уянга гишүүний санал энэ 1 дүгээр зүйлтэй холбоотой санал байна.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47² дугаар зүйл. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр

47².1.Энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай төлбөрийг энэ хуулийн 47².2-т заасан хувь, хэмжээгээр тооцож төлнө.

47².2.Энэ хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг.

Г.Уянгахишиг гишүүн тайлбарлах уу? Г.Уянгахишиг гишүүний микрофоныг нээе.

Г.Уянгахишиг: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр гаргаж байгаа санал маань ерөнхийдөө найруулгын шинжтэй санал байгаа юм.

Юу гэхээр одоо яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн 47² 1 дүгээр заалт, 2 дугаар заалт, 3 дугаар заалтыг ерөнхийдөө нэгтгээд яг өргөн барьсан төслийн хувьд энэ 3 заалтыг хооронд нь бас найруулчхаад байгаа байхгүй юу. Гуравдугаархаа хүчингүй болгоод, хоёрдугаархаа өөрчлөөд. Тэгэнгүүт 1 дээр бас өөрчлөлт оруулчихсан байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ дагуулаад найруулгын хувьд юуг янзалмаар байгаа вэ гэхээр одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар 47².1 дээр “эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг гэрээний нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг шилжүүлэн авч байгаа тал буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ингэж ингэж төсөвт төлнө” гэдэг ийм агуулгаар буюу энэ нь өөрөө хуулийн заалт гэхээсээ илүү гэрээний заалт шиг орчихсон.

Өөрөөр хэлбэл хууль дээр жишээлбэл “эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр гэрээний талууд харилцан тохиролцсоноор” гэдэг ийм заалтууд орох нь зохимжгүй байгаа юм.

Тийм учраас ерөөсөө хууль дээр бид юу хийх гээд байгаа юм гэхээр энэ Ашигт малтмалын тухай хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасны дагуу нөгөө төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын тусгай төлбөрөөр орлуулах тохиолдолд тэр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Улсын Их Хурлаас тогтоосон хувь, хэмжээгээр төлнө л гэдэг санааг оруулах гээд байгаа юм.

Тэгэхээр үүнийг найруулгын хувьд хуулийн заалт талаасаа хуулийн техникийн хувьд зөв болгож засах нөгөө дэд ажлын хэсэгтэйгээ хамтарч сууж байгаад яг энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулаад байгаа гэсэн үг.

Тэгэхээр одоо энэ миний гаргасан санал дээр ингэж байгаа юм. 47².1 дээр энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай төлбөрийг энэ хуулийн 47².2-т заасан хувь, хэмжээгээр тооцож төлнө гээд нэгдүгээрхийг гуравдугаархтайгаа нийлүүлээд 1 дүгээр заалтыг томьёолчхож байгаа юм.

Энэ дээрээс зарчмын хувьд гэдэг юм уу, агуулгын хувьд алдагдаж байгаа санаа байхгүй.

Нөгөө талаасаа саяын төслийн дагуу хуучин хуулиар бол Засгийн газар батална гэж байсныг шинээр оруулж байгаа төслөөр Улсын Их Хурал тогтоохоор зааж байгаа юм. Тэр хувь, хэмжээг.

Тэр нь 2 дугаар зүйл дээр яаж найруулагдаж орж байгаа вэ гэхээр энэ хуулийн 47².1-д заасан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж найруулж оруулж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ нь найруулгын хувьд зөв болгоод, буцаагаад нэгэнт хөндөгдсөн заалт байгаа учраас одоогийн байгаа 47².1 заалтыг зөв болгож найруулъя гэдэг ийм зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа гэсэн үг.

Одоо тэгээд бас нэг анхаарах юм нь одоо жишээлбэл энэ хууль дээр ингэж байгаа байхгүй юу. Хувь, хэмжээг талууд тохиролцсоноор. Одоо нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдол гэж байгаа байхгүй юу. Гэтэл энэ чинь талууд тохиролцсоны дараа биш. Бид Улсын Их Хурал эхлээд тэр орлуулах шийдвэрийг гаргаж байгаа байхгүй юу. Орлуулж болно гэдэг шийдвэрийг Их Хурал гаргаж байгаа.

Тэгэхээр тэр орлуулж болно гэдэг шийдвэрийг бид одоо үүний дараагийн хэлэлцэх асуудал буюу нөгөө стратегийн ордын эзэмшлийн хувь, хэмжээг тусгай төлбөрөөр орлуулах Их Хурлын тогтоолыг бид одоо бас хэлэлцэх гэж байгаа шүү дээ. Тэгтэл тэр тогтоолыг хэлэлцэхээс өмнө хоёр тал тохиролцчихсон байх ёстой юм шиг заалт яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол өөрөө яг Монгол Улсын Засгийн газар, Их Хурал талаасаа тэр тохиролцохоос өмнө орлуулж болно гэдэг шийдвэрийг Их Хурлаас гаргах ёстой.

Тийм учраас энэ 47².1 бол яаж ч байсан өөрчлөгдөж, найруулгын хувьд засагдах ёстой юм л гэж хараад байгаа гэсэн үг. Ойлгомжтой тайлбарлаж чадсан болов уу. Асуулт байвал би хариулж болно. Тийм ээ.

Р.Сэддорж: Асуулт байхгүй.

Засгийн газраас энэ 1 дүгээр зүйлтэй холбоотой саналаа хэлчих үү?

1 дүгээр зүйл дээр ер нь ямар юутай байгаа юм. Засгийн газрын байр суурь ямархуу байгаа юм? Хэдэн номер вэ? 1 үү, 3 уу? 3 номер. Д.Цолмон дарга.

Д.Цолмон: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар. Д.Цолмон.

Г.Уянгахишиг гишүүн өчигдөр ажлын хэсгийн хуралдаан дээр гаргасан саналыг ажлын хэсэг хэлэлцээд найруулгын хувьд Засгийн газрын зүгээс 47² гэдэг бүхэлд нь зүйлийг хөндөж өөрчлөөгүй.

Тодорхой хувь, хэмжээн дээр нь өөрчлөлт оруулж ирсэн ийм хуулийн төслийг санаачилж оруулж ирсэн.

Үүнийг Г.Уянгахишиг гишүүн бүхэлд нь найруулгын хувьд өөрчилж, агуулгыг өөрчлөлтгүйгээр найруулгын өөрчлөлттэйгөөр оруулъя гэдэг саналыг нь ажлын хэсэг хийгээд дэмжээд бид өчигдөр томьёолол дээр сууж ажилласан.

Р.Сэддорж: Өөр Засгийн газраас нэмж хэлэх юм хүн байгаа юу? Байр суурийг. Асуулт, хариулт бол байхгүй.

Г.Уянгахишиг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар. Сая гаргасан томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

А.Ундраа гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Төхөөрөмж ажиллаагүй учраас.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

М.Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. М.Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Энэ Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт ороод, тэгээд цацраг идэвхт ашигт малтмалаас орж байгаа орлого. Үүний төрийн эзэмшлийн хувь, хэмжээг АМНАТ-аар орлуулаад, тэгээд төрийн эзэмшлийн хувь, хэмжээнийхээ энэ орлогыг АМНАТ-ынх гэдэг утгаараа биш, төрийн эзэмшлийн 34 хүртэлх хувь гэдэг утгаараа “Хуримтлалын сан”-д. Одоо байгаа иргэдэд зориулж оруулахаар ингэж өөрчлөлт оруулж байна шүү дээ.

Тэгэхээр цаашдаа ямар зүйл гарах вэ гэхээр цацраг идэвхт ашигт малтмал бол хэмжээнээсээ үл хамаараад ордынхоо стратегийн ач холбогдлын ашигт малтмалд орчхож байгаа юм.

Тэгэхээр АМНАТ-ын төлбөр бол түрүүн Н.Учрал сайдын танилцуулснаар Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр АМНАТ-ын төлбөр бол Хөгжлийн нэгдсэн сан, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад, үлдэх хэсгийн 65 хувийг ирээдүйдээ хуримтлуулж байгаа.

Тэгэхээр стратегийн ач холбогдолтой ашигт малтмалуудыг цаашид ухаандаа энэ танилцуулга дээр байна шүү дээ. Хуулийн төслийн танилцуулга дээр. Цаашдаа ер нь төр ингэж хувь эзэмшээд эндээ хөрөнгө оруулаад явах нь менежмент, зардлаа хянахад төвөгтэй байна.

Тийм учраас үүнийг ер нь цаашдаа АМНАТ-аар орлуулаад явъя. Тусгай АМНАТ. Тийм үү. Бусад зүйлээр.

Ингэхээр ирээдүйдээ хадгалж байгаа мөнгө чинь цаашдаа хэрвээ яг энэ зарчим ингээд бүх төрлийн ашигт малтмал дээр стратегийн ач холбогдол дээр ороод явбал энэ зарчим чинь ирээдүйдээ хадгалж байгаа мөнгө чинь эрс багасаад одоогийн иргэддээ хуримтлалын сандаа зарцуулж байгаа руу илүү шилжих ийм зүйл гарах вий.

Тийм учраас үүнийг хооронд нь бусад бүх стратегийн ач холбогдолтой ордуудаа жилдээ орж байгаа орлогын хэмжээг нь харьцуулж үзээд нэг ийм дүгнэлт хийхгүй бол. Энэ яах вэ, зөвхөн ураны хувьд л ингэж байна гэж ойлгож байгаа.

Тэгээд бусад зүйл дээр яах юм бэ гэдэг энэ зүйлийг тайлбарлаж өгөөч. Би жоохон ойлгомжгүй асуучихсан уу, үгүй юу?

Р.Сэддорж: Н.Учрал сайд. 4 номер хариулъя.

Н.Учрал: Ер нь Цөмийн энергийн хуулийг Их Хурлаас баталсан.

Тэгээд Цөмийн энергийн хуулиар цацраг идэвхт стратегийн бүтээгдэхүүн бол өөрөө нөгөө стратегийн бүтээгдэхүүндээ хамаарч байгаа учраас бид одоо яг Үндэсний баялгийн сангийн хуулийнхаа дагуу Ирээдүйн өв санд “суурь АМНАТ” бол угаасаа Ирээдүйн өв сан руу орж байгаа.

Дээрээс нь одоо нөгөө “өсөн нэмэгдэх АМНАТ” гэсэн ойлголт энд орж ирж байгаа учраас тэр “өсөн нэмэгдэх АМНАТ” Цөмийн энергийн хуулиар нөгөө хувьчлал нь байгаа шүү дээ. Тэдээс тэдэн хувь дээр тэдэн доллар байвал тэд байна гээд листийг нь бид баталчихсан.

Энэ бол өөрөө мөн “Ирээдүйн өв сан” руу орж байгаа.

Одоо Баялгийн сангийн хуулиар “тусгай АМНАТ” “Хуримтлалын сан” руу шилжиж байгаа.

Яагаад гэхээр нөгөө төрийн эзэмшлийн 34 хувь нөгөө “тусгай АМНАТ”-аар орлуулж байгаа учраас тэр орлуулж байгаа хэсэг нь “Хуримтлалын сан” руу орохгүй бол нөгөө 34 хувь нь иргэдийн хуримтлалын сан руу орох асуудал яригдаж байгаа учраас бид “тусгай АМНАТ”-аар нэгэнт орлуулж байгаа учраас өнөөдрийн иргэдийн “эрүүл мэнд”, “боловсрол”, “орон сууц”-д зарцуулж байгаа хувь, хэмжээ нь “Хуримтлалын сан” руугаа ордгийг нь хэвээр нь үлдээхгүй бол цаашдаа Засгийн газар нөгөө хувийн хэвшилтэй, одоо ийм янз бүрийн олон улсын гаднаас орж ирж байгаа хөрөнгө оруулалтын гэрээн дээр гэрээ боловсруулаад Их Хуралд ороод нөгөө АМНАТ-аар орлуулах эсэхийг нь хөндөөд явахаар. Хэрвээ түүнийг нь “Ирээдүйн өв сан” руу авчихвал өнөөдрийн иргэдийн хүртэх нөгөө эрүүл мэнд, боловсрол, эрүүл мэнддээ зарцуулах “Хуримтлалын сан”-гийн хуримтлал өсөхгүй байх ийм хандлага гарах учраас “тусгай АМНАТ”-аар орлуулж байгаа хэсгийг нь “Хуримтлалын сан” руу авъя гэдэг ийм л зохицуулалтыг оруулж өгч байгаа юм.

Түүнээс биш ирээдүй хойчдоо үлдээх, нөгөө валютаар хуримтлагдах Ирээдүйн өв сангийн хуримтлал бол “өсөн нэмэгдэх АМНАТ, болоод “суурь АМНАТ” бол “Ирээдүйн өв сан” руугаа хуримтлагддаг нь хэвээрээ байна.

Зөвхөн “тусгай АМНАТ”-ын орлуулж байгаа хэсэг нь “Хуримтлалын сан” руу орно гэхээр зөвхөн энэ хүрээнд ч биш, цаашдаа бид нэгэнт Үндэсний баялгийн сангийн хуулиар “тусгай АМНАТ”-ын босгыг нь аваад “тусгай АМНАТ”-аар орлуулсан хэсэг нь “Хуримтлалын сан” руу орчхож байгаа учраас цаашдаа стратегийн орд эзэмшиж байгаа олон компаниуд байгаа. Тэр компаниуд Засгийн газартай хэлэлцээр хийгээд явчихвал “орлуулсан тусгай АМНАТ” нь “Хуримтлалын сан” руу явна.

“Суурь АМНАТ” бол “Ирээдүйн өв сан” руугаа. Зөвхөн Цөмийн энергийн хуулиар яригдаж байгаа тэр нөгөө жагсаалт баталчихсан байгаа хэсэг бол “Ирээдүйн өв сан” руугаа ороод явна л гэсэн үг.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Тийм. Би сайн ойлгуулж асууж чадаагүй юм шиг байна.

Одоо ингээд стратегийн орд эзэмшигчтэй цаашдаа үе шаттай гэрээ хийнэ гэж байгаа. Тийм ээ. Хэлэлцээр хийнэ ээ гэж байгаа юм.

Тэгэхээр “үндсэн АМНАТ” 5 хувь, одоо 7.5, 10 байдаг юм уу, энэ хувийг цаашдаа ер нь хөдөлгөхгүй байх, өөрөөр хэлбэл энэ нь нөгөө “Ирээдүй өв сан”-даа орж байгаа энэ зүйл нь энэ хэвээрээ хадгалагдах зарчмыг ер нь баримталж ажиллаач ээ л гэдэг л ийм л санааг хэлээд байгаа юм.

“Тусгай АМНАТ”-аар, зөвхөн “тусгай АМНАТ”-ыг л төрийн эзэмшлийн 34 хүртэл хувь, хэмжээнд тооцно. “үндсэн АМНАТ”-ыг тооцохгүй ээ гэдэг энэ зарчим цаашдаа үйлчлээд явна гэж ойлгож байгаа. Энэ нь зөв үү? Тэгээд энэ зарчмаа ер нь алдахгүй биз дээ?

Өөрөөр хэлбэл төрийн эзэмшлийн 34 хувьд “тусгай АМНАТ”-ыг орлуулж тооцож байгаатай холбогдуулаад, энэ үзэл санаа ингэж нэвтэрч эхэлж байгаатай холбогдуулаад “үндсэн АМНАТ”-ын хувь, хэмжээг битгий бууруулаач ээ. Ингэвэл “Ирээдүй өв сан”-д орох мөнгө чинь багасна шүү л гэдэг ийм л саналыг хэлээд байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: 4 номер. Н.Учрал сайд.

Н.Учрал: Тийм. М.Бадамсүрэн гишүүн их чухал асуудлыг хөндөөд байгаа юм.

Энэ дээр яг нөгөө хуулийн төслийг оруулахад “суурь АМНАТ”-ыг шууд “Хуримтлалын сан” руу авах уу, үгүй юу гэдэг асуудал бас яригдаж байсан.

Ингээд “суурь АМНАТ”-ыг үлдээгээд үүнийг “Ирээдүй өв сан” руу нь хуримтлуулъя. Яагаад гэхээр таны энэ асуудал дээр нөгөө 65.0 хувийн АМНАТ нь “Ирээдүйн өв сан”-д ороод, үлдсэн хэсэг нь “Орон нутгийн хөгжлийн сан”-д хуваарилагдах учраас түүнийг хөндөж болохгүй юм билээ. Яагаад гэвэл орон нутгийн санд тодорхой хэсэг нь очих ёстой. Тэгээд Тогтворжуулалтын санд тодорхой хэсэг нь очих ёстой.

Тэгээд 65.0 хувийн АМНАТ нь Ирээдүйн өв санд очих ёстой.

Зөвхөн “тусгай АМНАТ”-аар орлуулж байгаа хэсэг нь Хуримтлалын сан руу очихгүй нөгөө төрийн эзэмшлийн 34 хувь чинь бүтнээрээ Хуримтлалын сан руу очих гээд байдаг. Гэтэл АМНАТ-аар орлуулчхаад байгаа хэсэг маань Иргэний хуримтлалын сан руу очихгүй болохоор энд яг нөгөө бид нарын нөгөө И-Монгол дээр харагдаад байгаа нөгөө Хуримтлалын сангийн орлого чинь нэмэгдэхгүй юм шиг харагдах ийм эрсдэлтэй учраас аль аль талыг харж үзээд “суурь АМНАТ”-аа, “өсөн нэмэгдэх АМНАТ”-аа яг тэр “Ирээдүй өв сан” руу явуулдгаар нь явуулаад зөвхөн “тусгай АМНАТ”-аар орлуулсан хэсгээ л “Хуримтлалын сан” руу нь явуулж байгаа.

Тэгэхээр Орон нутгийн хөгжлийн санд очих тэр орлого багасгана өөрчлөгдөнө гэдэг ойлголт байхгүй. Хуучнаараа л явна гэсэн үг.

Р.Сэддорж: Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Би ерөнхийд нь асуух гээд байгаа юм.

Ер нь ашигт малтмалын ордоос олж байгаа орлогоос хэдэн хувь нь тухайн орон нутагт нь үлдэхийг л ард түмэн сонирхоод байгаа юм. Ард иргэд.

Сумд нь хэд орчим вэ? Хуучин бол нийлээд бүх татвар хураамжууд нийлээд 30 орчим хувь гэж яригддаг байсан. Одоо яг хэдэн хувь нь энэ өөрчлөлтөөс үлдэж болох вэ? Энэ нэг тодорхой тоо хэлж болох уу? Тэгвэл бас аймаг болгон нэг баримжаатай, бүсүүд баримжаатай, сумдууд бас баримжаатай ярих юм болов уу гэсэн ийм асуулт байна.

1 номер. Өөрийгөө танилцуулаад.

Б.Тэлмүүн: Сангийн яам. Б.Тэлмүүн.

Монголын талын ногдох өгөөж тооцогдож байгаа энэ дүнгийн ойролцоогоор яг энэ дефолт үндсэн 80 доллар гэдэг тооцоолол дээр 22.3. Нийт өгөөж орон нутаг руу орохоор байгаа.

Дээрээс нь бид өгөөж тооцогдохгүй энэ компанийн төлөх хэд хэдэн татвар байгаа. Энэ дээр хувь хүний орлогын албан татвар тухайн сумын орлогод ордог. Энэ нэмэгдээд явна.

Р.Сэддорж: Яг тодорхой тийм хувь байгаа юу?

Б.Тэлмүүн: Жилд дунджаар 29 орчим сая доллар гэж. Төслийн хугацаанд дунджаар ийм тооцоо гарч байгаа. Орон нутагт.

Энэ дээр ус болон газрын төлбөр, орон нутгийн дэмжлэгийг нэмэх юм бол 44 сая доллар болж байгаа.

Р.Сэддорж: Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн

хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэх асуудал хоёр.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл уншиж танилцуулна.

Н.Батсүмбэрэл гишүүний микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбат асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бөгөөд төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй

байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Н.Батсүмбэрэл гишүүнд баярлалаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир уншиж танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе.

Т.Аубакир: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд Төсвийн байнгын хороо 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа уг тогтоолын төслийг хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Монгол Улс, Франц Улсын хамтарсан ураны төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг судалж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах талаар Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгажээ.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Ц.Даваасүрэн нар төслийн техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан эсэх, мөн төслийн нийт өгөөжийг хэрхэн тодорхойлсон талаар болон хөрөнгө оруулагч талаас төслийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх замаар Монголын Засгийн газарт ногдох өгөөжийг бууруулах эрсдэлтэй эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Т.Аубакир гишүүнд баярлалаа.

Тогтоолын төслийн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 338 дугаар захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, О.Батнайрамдал, Г.Тэмүүлэн, А.Ариунзаяа, Б.Батбаатар, Ж.Баярмаа, Ж.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Найдалаа, У.Отгонбаяр, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Б.Уянга, Г.Уянгахишиг, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, Б.Энхбаяр, С.Эрдэнэбат болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажиллалаа.

Ажлын хэсгийн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслийг хэлэлцэж, зарчмын зөрүүтэй саналын томьёолол 2, төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулгыг нийцүүлж өөрчлүүлэх найруулгын

саналыг хэлэлцэн дэмжиж Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, төслийн 1 дэх заалтын “MV-018915 дугаартай “Дулаан-Уул” гэснийг “MV-018916 дугаартай “Дулаан-Уул” гэж, “MV-018916 дугаартай “Зөөвч-Овоо” гэснийг “MV-018915 дугаартай “Зөөвч-Овоо” гэж тус тус өөрчлөх.

Тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгах зэрэг болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дээрх тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёололыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Б.Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсэг Усны газрын дарга ирсэн байна. З.Батбаяр дарга ирсэн байна. Цөмийн энергийн комиссынхон ирсэн байна. Ингээд ажлын хэсэг хэвээрээ.

Ажлын хэсгийн танилцуулга болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Г.Уянгахишиг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл асуулт асууна. Н.Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Юуны түрүүн энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд амжилт хүсье.

Монгол Улсад хэрэгтэй байгаа гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтыг татаж байгаа том хэмжээний төсөл хэрэгжүүлж байгаа ажил болж байгаа.

Энэ ажлыг амжилттай зохион байгуулж байгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд улам сайн ажиллахыг хүсье.

Тэгээд хоёр асуулт байна. Нэгдүгээрт, байгалийн нөхөн сэргээлт, хортой хаягдлаа хэрхэн шийдвэрлэхээр тогтсон бэ? Хог хаягдлын асуудал ер нь хэлэлцүүлгийн явцад нэлээн анхаарал татаад, мөн тодорхойгүй яваад байсан шүү дээ.

Тэгэхээр энэ хог хаягдлын асуудал дээр яг ямар байдалтай явж байна гэдэг нэг асуулт.

Хоёр дахь нь, миний ойлгосноор энэ “Бадрах Энержи” буюу “Орано” групп маань Монголд 3 орчим талбай байх шиг байгаа. Яг одоо энэ гэрээн дээр аль талбайгаа ашиглана гэж зааж байгаа вэ?

Зөөвч-Овоо, нэг нь юу билээ. Дулаан-Уул билүү? Яг аль аль талбайг ашиглана гэж байгаа вэ? Үлдсэн талбайгаа яана гэж ярьж байгаа. Хэлэлцээр дээрээ үүнийг хэрхэн хөндөж байгаа гэдэг дээр хоёр асуултад хариулт авъя.

Р.Сэддорж: Гишүүний асуултад хариулъя. 6 номер. Өөрийгөө танилцуулъя.

Ц.Уранчимэг: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг байна.

Гишүүний асуултад хариулъя.

Гэрээн дээр байгаль орчны асуудал маш тодорхой орсон байгаа. Ялангуяа аюултай хог хаягдал, энгийн хог хаягдал, цацрагийн хог хаягдал гэдэг байдлаар ангилж оруулсан.

Тэгэхээр яг энэ төслийн бүх хугацаанд хог хаягдалтай холбоотой менежментийн төлөвлөгөөг техник, эдийн засгийн үндэслэлд тусгасны дагуу, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгаж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх байдлаар явна.

Үүнтэй холбоотой бүх зардлыг төсөл хэрэгжүүлэгч нэгж бүрэн хариуцна гэсэн заалтыг гэрээний төсөлд тусгаж өгсөн байгаа.

Нийт техник, эдийн засгийн үндэслэлд “аюултай хог хаягдал”, “энгийн хог хаягдал”, “бага цацрагт хог хаягдал” гэдэг ангилалыг яг тухайн төсөл хэрэгжих бүх хугацаанд 5, 5 жилээр төлөвлөлтийг нь яг техник, эдийн засгийн үндэслэлд маш нарийн төлөвлөлт оруулж нарийн тусгаж өгсөн. Одоо байгаа яг үйл ажиллагаа эрхлэх аюултай хог хаягдал Хог хаягдлын тухай хуулиараа яг ангилан ялгадалт явуулах, менежментийг бий болгох, тэр тусмаа аюултай хог хаягдлын ангиллын яг тодорхой журамд заасны дагуу ангилан ялгах төлөвлөгөөг техник, эдийн засгий үндэслэлд нарийн тусгасан.

Тэгэхээр аюултай хог хаягдлын зэрэглэлээрээ маш бага аюултай хог хаягдал гаргаж байгаа.

Гэхдээ Монгол Улсын хэмжээнд өнөөдөр 27 аюултай хог хаягдлын зөв зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байдаг. Түүнд аюултай хог хаягдлаа ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлээд бусад боловсруулах, ангилан ялгах боломжгүй хог хаягдлыг тухайн төсөл хэрэгжүүлэгч компани өөрөө үйлдвэрлэл бий болгож энэ хог хаягдлаа устгах менежментийг оруулж өгсөн байгаа.

Мөн нэг юмыг аягүй нөгөө сайн зөрүүг нь ойлгох ёстой. Хог хаягдлын тухай хуулиараа энгийн хог хаягдал нь дахин боловсруулах, ангилан ялгах, яг энэ эдийн засгийн зэргэлтэд оруулах гэдэг байдлаар нэлээн сайн менежментийн төлөвлөгөөнд жил болгон тусгаж баталж өгнө.

Аюултай хог хаягдлыг энгийн хаягдлаасаа ялгаад аюултай хог хаягдлын 3 зэрэглэлээрээ ялгах хэрэгтэй байгаа.

Өмнө нь техник, эдийн засгийн төсөл дээр 750 тонн аюултай хог хаягдал гарна гэдэг тоогоо нэгдсэн тийм багц тоогоор явж байсан боловч үүнийг яг Хог хаягдлын тухай хуулиар аюултай хог хаягдлыг ангилан ялгах журмын дагуу ингээд ялгуулахад яг аюултай хог хаягдал нь 150-иас 200 тонн жилд гарах тийм тоо техник эдийн засгийн үнэлэлтээр нэмэлт, өөрчлөлт оруулаад тусгаж явж байгаа.

Ингээд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээрээ энэ хог хаягдлын менежментээрээ яг ангилал нь нэлээн нарийн тусгагдаад жил болгон үүнийгээ тайлагнаад явах ийм үүргийг хүлээж байгаа.

Р.Сэддорж: Н.Учрал сайд. 4 номер. Нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм. Баялагтаа эзэн болох концепц Баялгийн сангийн хуулиар амилсан.

Тэгээд ер нь бид цаашдаа байгалийнхаа баялагт хэрхэн эзэн болох вэ? Аль болгон “баялаг дээр суусан гуйлгачин” шиг амьдрах вэ гэдгийг эргэж харахгүй болохгүй нь.

Тийм учраас бид гэрээг хийхдээ бид англи, монгол хэл дээр гэрээний төслийг боловсруулахдаа Засгийн газрын үр өгөөжид ус бохирдуулж байгаа төлбөр, агаар бохирдуулж байгаа төлбөрийг оруулаагүй. Энэ авах л ёстой.

Дээрээс нь С.Одонтуяа сайдаар ахлуулсан ажлын хэсэг би сайн ажилласан гэж бодож байгаа. Байгаль орчинтой холбоотой татваруудыг тогтворжуулаагүй.

Тийм учраас энэ гэрээ цаашдаа байгаль орчинтой холбоотой асуудлууд дээр ямар нэгэн тогтворжилт хийгээгүй учраас төлбөр мөнгөө аваад, тэр нь өөрөө Засгийн газрын авч байгаа өгөөж биш. Ус бохирдуулсан түүнийгээ нөхөн сэргээхдөө зарцуулах ёстой. Энэ бол үүрэг нь. Хөрөнгө оруулагч талын гэж ойлгож байгаа.

Тэгээд төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд 3 тусгай зөвшөөрөл хамаарна. Тэр Зөвч-Овоо, Дулаан-Уул, Өмнөдийн 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд л үйл ажиллагаа явуулна.

Цаашдаа төсөл хэрэгжүүлэгч компанийн ирээдүйд авч болох тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулалтын гэрээнд огт хамааруулаагүй.

Одоо Оюу Толгойн гэрээ дээр ямар асуудал үүсэж байгаа вэ гэхээр тэр “Онтри”-той /Entree gold LLC/ холбоотой Оюу Толгойн бүлэг ордод хамаарах уу, хамаарахгүй юу гээд л маргаан дагуулсаар л байна шүү дээ.

Хэрвээ энэ 3 тусгай зөвшөөрлөөс гадна ирээдүйд авч болох тусгай зөвшөөрлийн асуудал яригдвал тэр үед хөрөнгө оруулалтын гэрээг дахиж тухайлан ярихаас биш энэ гэрээнд огт хамааруулахгүй.

Энэ бол 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд л хамаарч яригдах энэ талбайд хамаарах хөрөнгө оруулалтын гэрээ. Энэ 3 тусгай зөвшөөрлийг.

Тийм учраас Их Хурлын тогтоол дээр хатуу зааж бичсэн.

Тэгэхээр нэмэлт ирээдүйд олох тусгай зөвшөөрөл үүнд хамаарахгүй.

Р.Сэддорж: Н.Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Хог хаягдалтай залгуулаад Усны газар, З.Батбаяр дарга энэ усан дээр. Сая Н.Учрал сайд ч төлбөртэй холбоотой асуудал ярьж байна.

Усны бохирдуулалт, энэ устай холбоотой асуудал дээр Усны газар ямар байр суурьтай байгаа юм бэ? Үүнийгээ хурлын тэмдэглэлд оруулаад тодорхой байр сууриа хэлчихмээр байна.

Түрүүн тэр хаягдлын талаар танилцуулсан хүнээс дахиад тодруулаадахъя.

Өөрсдөө хэлэхгүй болохоор мэдэхгүй байгаад байна л даа. Яг энэ аюултай хог хаягдлынхаа хяналтыг хэн хийх юм бэ? Гаднаас хийх юм уу, манайд дотоодод байгаа юу?

Р.Сэддорж: Нэр цохож асуусан. Тийм ээ. З.Батбаяр даргаас. Дараа нь тэр Байгаль орчны яамнаас. 5-аас эхлээд явчихъя. 5 номер.

З.Батбаяр: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Энэ уран олборлох процесс бол гарч байгаа хаягдал байгалийн цацрагийн хаягдал гарах юм.

Тийм учраас цөмийн хаягдалтай ялгаж ойлгож болохгүй. Тэр аюултай хог хаягдал гэхээр хүмүүс тэр цөмийн хаягдал гэж яг мэргэжлийн бус хүмүүс ойлгоод байх шиг байна лээ. Энэ бол тусдаа хаягдал. Энэ бол нөгөө цацраг идэвхт хаягдал биш гэдэг талаасаа ойлгох хэрэгтэй.

Яг байгаль дээр байгаа байгалийн ураны хаягдал учраас энд тийм үүний менежмент хийхэд техник, технологи талаасаа тийм хүндрэлтэй зүйл ердөө

байхгүй. Үүний хяналтыг одоо энэ цөмийн болон цацрын хяналтын мэргэжлийн байцаагчид тогтмол хянана.

Тэгээд 3-аас 4 жилд олон улсын атомын энергийн агентлагаас ирж энэ цацрагийн хяналтыг хэр хийж байгааг тогтоох олон улсын шинжээчдийн баг ирнэ. Ирсэн баг гаргасан зөвлөмжийг Монгол Улс төсөл хэрэгжүүлэгч компани Засгийн газрын өмнө хариуцаж хийх үүрэгтэй.

Ер нь цөмийн болон цацрагийн хяналтыг хийдэг цөмийн болон цацрын аюулгүй норм, цацрын хяналтын стандартууд, цацраг идэвхт ашигт малтмалуудыг эрэх, хайх, олборлох, тээвэрлэх бие даасан журмууд байгаа. Энэ бол олон улсын атомын агентлагаас гаргасан журамтай яг нийцэж байгаа. Яг энэ дагуу бүгд хийгээд явах учраас энд цацрагтай холбоотой ямар нэгэн эрсдэл гаргахгүй гэдгийг л хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: 6 номер хариульъя.

Ц.Уранчимэг: Гишүүн сая нэмэлтээр аюултай хог хаягдал, ер нь хог хаягдлын менежментийг хэн хянаж явах юм гэхээр байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчил сан үнэлгээг 5 жил тутам хийгдэнэ.

Энэ дагуу менежментийн төлөвлөгөөг нь. Гэрээнд мөн хог хаягдлын менежмент, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, цацрагийн хаягдлын менежментийн төлөвлөгөөг заавал хэрэгжүүлнэ. Олон улсын стандарт, норм дүрмийг хангасан байна гэсэн заалтыг оруулсан байгаа.

Тэр дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсний дагуу улсын байцаагч нар тухайн чиглэлээр нь хяналт тавиад явдаг.

Яг энэ хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн дагуу хяналт тавигдана.

Манай байгаль орчны салбарын улсын байцаагч нар. Тийм. Мэргэжлийн хяналт манай яам нь яг чиглэлээрээ салбар салбартаа байгаа. Байгаль орчны яам хянана гэсэн үг.

Р.Сэддорж: 3.Батбаяр дарга. 6 номер.

3.Батбаяр: Гишүүнд баярлалаа. Усны тал дээр энэ гэрээн дээр байж байгаа хамгийн том ололттой тал нь байгаль орчны болоод тэр дундаа усны асуудлуудыг тогтворжуулахгүй гэдэг ийм үг бид хэрэглээд байгаа.

Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр төслийн бүхий л хугацаанд тухайн цаг үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, стандартын дагуу устай холбоотой асуудлуудыг шийднэ гэдэг маань энд хамгийн том ололт нь байж байгаа.

Яг ураны олборлолт явуулах газар дээр тогтоогдсон усны нөөц маань 33 литр секунд байж байгаа.

Тэгээд энд усны дахин ашиглалтын хувь нь яг одоогоор хэд байх нь тодорхойлогдоно. Нэлээн өндөр хувьтай байх учраас усны нөөцийн хувьд асуудал гарахааргүй байгаа.

Гол асуудал бол түрүүн сайдын дурдсанаар ус бохирдуулсны төлбөрийг тогтоохын тулд одоо байж байгаа байгалийн нөхцөл байдлыг нь суурь үзүүлэлт гэж авч үзээд 30 жилийн дараа, 40 жилийн дараа олборлолт дуусаад хаалт хийх үед энэ суурь нөхцөлтэйгөө харьцуулсан байдлаар тэр суурь нөхцөлд эргүүлэн хүргэж байж, газрын доор усны нөөцийг эргүүлэн хүргэж байж нөхөн сэргээлт хийгдсэн гэж үзнэ.

Мөн бас нэг онцлог зүйл нь бусад уул уурхайн газрууд дээр бид мониторингийн цооног ажиллуулж, газрын доорх усны түвшний хэлбэлзлийг шалгадаг бол энд хэлбэлзлийг хянахаас гадна хяналтыг давхар хийх юм.

Тэгэхээр газрын доорх усны хяналт нь чанарын хяналттайгаа зэрэгцээд явчих учраас ийм гурав, дөрвөн давуу тал байна гэж ингэж үзэж байгаа. Энэ нь зүгээр давуу тал гэж хэлэхээс илүү цаашдаадаа Монгол Улсад уул уурхайн салбарын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд дээр жишиг болоод явах юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Нэмж хариулах юм уу? 5 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Н.Тэгшбаяр: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Физикийн ухааны доктор Норовын Тэгшбаяр байна.

Энэ ус бохирдуулсны төлбөр гэхээр хүмүүс ундны ус руу аваачаад уран шахаж байгаа юм шиг, эсвэл хүхэр шахаж байгаа юм шиг ойлголт төрөөд байна.

Зүй нь олборлохуйц хэмжээний урантай тэр орчны ус бол өөрөө энгийнээр бол бохир, мэргэжлийн хэллэгээр хэлэх юм бол техникийн орчин. Өөрөөр хэлбэл цацрагийн ч хувьд хоруу чанартай, химийн хувьд хоруу чанартай ийм ус байгаа.

Тэгэхээр усны чанарын өөрчлөлтийн тухай асуудал байгаа. Нөхөн сэргээлтийн тухайд ямар пи аштай орчин байсан тэр рН-тай /рН-хүчиллэг болон шүлтлэгийг хэмжих хэмжүүр/ орчин байсан тэр рН-тай орчин руу аваачих тухай асуудал болохоос биш нөхөн сэргээгээд ариун цагаан ус болчихгүй.

Ер нь тэр урантай орчны тэр усыг уран ашиглахаас өөр юунд ч ашиглах боломжгүй. Үүнийг ард нийтэд сайн ойлгуулахгүй бол энэ цэвэр ундны усыг бохирдуулж байгаа юм шиг ийм ойлголт төрөөд байна л гэж хэлэхийг хүссэн.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд асуулт асууна. Л.Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр нэг ийм асуулт байгаа юм. Энэ ашигт малтмалын 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх АМНАТ маань одоо яг гэрээн дээр тусаж байгаа юу? Тодорхой хуулийн заалт болж тусаж байгаа юу? Үүнийг тодруулж асуумаар байгаа юм. Суурь болон өсөн нэмэгдэж байгаа АМНАТ-ыгаа бид хаана тусгаж байгаа вэ?

Хоёрдугаарт нь, ураны дэлхийн зах зээлийн үнэ 40-өөс 50 амдоллар байх юм бид АМНАТ-аа 0.5 хувиар авна гээд, 50 доллароос дээш гарахаар 5 хувь болж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр энэ хоёрын зөрүү 4.5 хувь. Хэтэрхий эрс өөрчлөлт байгаад байна л даа.

Тэгэхээр яагаад ингэж 0.5, 5 гэж тооцож байгаа вэ? Үүний цаад учир шалтгаанаа тайлбарлаач ээ.

Р.Сэддорж: 1 номер. Хариулт.

Б.Тэлмүүн: Сангийн яам Б.Тэлмүүн.

Л.Соронзонболд гишүүний асуултад хариулья.

АМНАТ дотроо 3 хэлбэрээр ногдоно. Үндсэн АМНАТ, үнийн өсөлтөөс хамаарч ногдуулж байгаа нэмэлт АМНАТ бол Цөмийн энергийн хуулийн 20¹ гэсэн заалтын дагуу ногдоно. Энэ гэрээгээр зохицуулагдахгүй.

Цөмийн энергийн хуулийн 20⁶ дээр энэ тусгаар роялтиг төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулахтай холбоотой Улсын Их Хурал тогтоолоор энэ төсөлд зориулж тогтоож байгаа. Энэ бол өнөөдөр ингээд хэлэлцэх гэж байгаа асуудлын хувьд яригдаж байна.

Эдгээр нь мөн гэрээн дээр татварын хувь хэмжээ тогтвортой байх гэдэг агуулгаараа мөн тусгагдана.

Хоёр дахь асуултын хувьд тусгаар роялтигийн тэр 50-иас доош, 40-өөс доош 0.5 гэдэг хэлэлцээрийн явцад гарсан. Үндсэн шалтгаан нь Ашигт малтмалын хуулиар тусгаар роялтиг дээд тал нь 5 хувь байхаар заасан.

Бид хэлэлцээрийн явцад баримталсан тактик бол үндсэн роялти 5 хувь, дээрээс нь тусгаар роялтиг хуульд заасан дээд хэмжээндээ тулгачхаад өсөн нэмэгдэхээ байж болох хамгийн өндөр түвшинд байхаар хэлэлцээр хийсэн.

Хэлэлцээрийн явцад энэ төслийн хугарлын цэг нь өөрөө 48 орчим доллар дээр үнэ байхад энэ төсөл цаашаа үйл ажиллагаа явуулах боломжгүй болно гээд. Тэгээд хэлэлцээрийн явцад бид өсөн нэмэгдэхээ өндөр байлгахын тулд энэ хугарлын цэгээс доош байгаа үнийн нөхцөл дээр тусгаар роялтиг нь бууруулан тохирсон байгаа.

Тэгэхээр хаашдаа 48-аас доош тохиолдолд энэ төсөл борлуулалт, ачилт хийхгүй. Бид АМНАТ авахгүй нөхцөл үүснэ.

Тэгэхээр ийм агуулгаар бид энэ нөхцөлийг тохирсон. Мөн хууль дээр ордын онцлогоос хамаарч энэ тусгаар роялтиг ялгаатай тогтоох боломжийг олгосон байгаа.

Тэгэхээр энэ ордын онцлог нь энэ төслийн ашигт ажиллагааны хугарлын цэгтэй холбоотой энэ тоо гарсан байгаа.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр хэрвээ одоо нөгөө олборлосон уранаа 50 доллароос дээш зах зээлийн үнэтэй байхад борлуулахгүйгээр хадгалаад байх тохиолдол үүсэх үү?

Өөрөөр хэлбэл одоо нөгөө хөрөнгө оруулагч зөвхөн 40-өөс 50 долларын үнийн ханш дээр л зардаг. 50 доллароос дээш болохоор зарахгүй байх тийм тохиолдол гарах уу? Тэр тохиолдолд бид 5 хувь биш 0.5 хувийн л АМНАТ авах нь байна шүү дээ гээд байхгүй юу. Тийм тохиолдол гэрээн дээр байгаа юу?

Р.Сэддорж: Энэ их тодорхой асуулаа. Тийм ээ. Хэр их зөрүүтэй байгаа юм? 100 дахин зөрүүтэй байгаа юм байна шүү дээ. Энэ хоёр хэлбэлзлийн чинь хооронд. Тийм ээ. Татварын хувь хэмжээ. Энд хэн хариулах вэ? 1 номер.

Б.Тэлмүүн: Үүнтэй холбоотой хоёр асуудал яригдана.

Нэгдүгээрт, уулын ажлын төлөвлөгөө, түүнд хийх хяналттай холбоотой асуудал яригдана. Цэвэр татварын зорилгоор ачилт хийхгүй байх ийм асуудал гарах юм бол нэгдүгээрт манайх давуу эрхийн хувьцаа эзэмшиж байгаа.

Энэ дээр хяналт тавиад хориг тавих хүртэлх ийм эрхүүд байгаа.

Хоёрдугаарт, энэ дээр татварын хуулийн дагуу татвараас зайлсхийх, зугтаах зорилготой үйлдлүүд дээр тусдаа хариуцлагын асуудал яригдана.

Р.Сэддорж: Гэрээн дээрээ тусаж байгаа юм уу? 1 номер нэмж хариулах уу.

Б.Тэлмүүн: Гэрээн дээр манайх энэ давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эрхтэй холбоотой асуудлууд байгаа. Хориг тавих, ТУЗ-д оролцох, ямар ямар мэдээллээр хангагдах гээд.

Энэ эрхийн хүрээнд бид засаглалынхаа хувьд тэргүүн ээлжийнхээ хяналтыг тавиад явна.

Яг татвараас зайлсхийсэн ийм үйлдэл гарсан тохиолдолд тусдаа хариуцлагын асуудал давхар яригдана.

Р.Сэддорж: 100 биш 10 дахин зөрүүтэй байгаа юм байна шүү дээ. Тийм ээ. Энэ хоёр үнийн хэлбэлзэл дээр.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Би түрүүн Байнгын хорооны дарга Р.Сэддорж даргын асуулттай ерөнхийдөө ойролцоо асуулт.

Миний энэ асууж байгаа асуулт болоод санал уул уурхайтай орон нутгийн иргэдийн нийтлэг асуулт гээд ойлгоход болно.

Тэгээд би Н.Учрал сайдыг Хэрэг эрхлэх газрын даргын хувьд орон нутгийн харилцааг хариуцдагийн хувьд үүн дээр онцгой анхаарч, цаашид ийм бодлогын томоохон шинэчлэлийг эхлүүлж хийж өгөөч ээ гэдгийг чин сэтгэлээсээ хүсэж байна.

Яагаад гэвэл Үндэсний баялгийн сангийн тухай хууль том хууль батлагдсан. Үүнийгээ амилуулна гэж сая сайд хэллээ.

Тэгэхээр үүнийг амилуулахад нэг дутагдаж байгаа зүйл бол орон нутагт хуваарилагдах байгалийн нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ байхгүй байгаа. Өөрөөр хэлбэл уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа Өмнөговь, Дорноговь, Дорнод гэдэг юм уу энэ аймгуудын ард иргэд уул уурхайгүй ногоон аймаг гэж ярьдаг Хөвсгөл, Булган аймгуудын ард иргэддээ яг адилхан хувь хэмжээ нь ногдож байгаа. Шударга бус гэж хэлж болох ийм л харилцаа одоо үйлчилж байгаа.

Тийм учраас Та бүхэн харж байгаа. Ихэнх аймгууд “ногоон аймаг” гээд бүхэлд нь иргэдийн хурлын тогтоол гаргачихсан байгаа шүү дээ.

Тэгэхээр миний хувьд аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа энэ зүйл дээр шүүхэд хүртэл хандсан, сангийн сайдыг захиргааны хэргийн шүүхэд одоо үүнийг хуваарилахгүй байна гэдэг асуудлаар хүртэл хандаж байсан ийм л хүн.

Энэ бол нэг зарга зальхай хийж байгаадаа биш. Ер нь энэ шударга бус зүйлтэй эвлэрэхгүй байгаа л зүйл байгаа.

Тэгэхээр нэгдүгээрт олон улсын гэрээ, олон улсын жишгийг авч байна гээд энэ дээр ярьж байна л даа. Жишээлбэл, газар доор уусган баяжуулах технологи гэдэг асуудал олон улсад дийлэнх нь ингэж олборлож байгаа гэдэг зүйлийг танилцуулсан. Ажлын хэсэг.

Хоёрдугаарт нь, АМНАТ-ыг Казахстанд ингэж авч байна. Казакстан уранаараа бараг цэнгэлийн манлайд хүрлээ л гэсэн юм явж байгаа.

Олон улсын энэ жишгүүдийг авч байгаа олон улсын жишигт нэг тодорхой зүйл байгаа нь олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутаг, орон нутагт АМНАТ-ийн төлбөр буюу роялтийн төлбөрийн 30-аас доошгүй хувь нь хуваарилагддаг ийм зарчим жишигтэй. Монгол Улс үүнийг нь авахгүй байгаа юм.

Тэгээд бүх юм нэг тийм Засгийн газар, Улсын Их Хурлаас хараат орон нутгууд чинь ийм байдалтай байгаа шүү дээ. Өмнөговь гэхэд 1.7 их наяд төгрөг улсын төсөвт төвлөрүүлдэг юм билээ.

Тэгээд нийслэлд одоо тэг юм билээ. Нийслэлд тулгамдсан асуудал ихтэй учраас ийм бодлогын шийдэл гаргаад нийслэлээс мөнгө улсын төсөвт төвлөрүүлдэггүй. Саяхан хэдэн 100 тэрбумыг төвлөрүүлдэг байсан.

Тэгвэл Өмнөговь аймагт бусад энэ уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймгуудад яагаад орлогыг нь тэнцвэржүүлээд шууд зөрүүг нь татаж аваад яваад байгаа юм бэ? Энэ төсвийн орлоготой холбоотой харилцаа.

Тэгвэл нөгөө талд нь Үндэсний баялгийн сангийн тухай хуультайгаа уялдаад энэ суурь АМНАТ-ийн чинь орж байгаа орлогын 30-аас доошгүй хувь буюу 5 хувиар хэдэн төгрөг ордог юм. 10 тэрбум төгрөг орлоо гэхэд үүний 3 тэрбум төгрөгт сөрөг нөлөөлөлд өртөж байгаа сум, аймагт л.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут нэмж өгье. М.Бадамсүрэн гишүүнд.

М.Бадамсүрэн: Энэ очдог байх ёстой. Болохгүй болохоор өнөөдөр ингээд нэг сургуулийн хаалга, цонхноос өгсүүлээд бүх юмаа улсын төсвөөс хараад байна шүү дээ.

Тийм учраас үүнийг өөрчлөхийн тулд орон нутагтаа эрх мэдлийг нь, хөрөнгө санхүүг нь бодитой өгөхгүй бол яг нүдэн дээр нь олон зуун машин, вагоноор машинаар баялаг гараад байдаг. Тэр сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутгийн иргэд чинь энд орлогогүй, хөгжихгүй байгаад байхаар тэр хүмүүс чинь дургүйцээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр би хэлж байгаа зүйл нь энэ зөвлөж байгаа нь шүүмжлэл биш. Энэ бол цаашдаа энэ уран, стратегийн ач ач холбогдолтой ашигт малтмалын ордыг эргэлтэд оруулъя гэж байгаа бол орон нутагт нь хөрөнгө хуваарилахгүй бол энэ зүйл эсэргүүцэлтэй тулгарсаар л байх болно. Адилхан хөгжих ёстой шүү дээ. Орон

нутагт амьдарч байгаа хэд. Эцэг, өвгөдөөрөө малчин өвөг дээдэс нь энэ газар нутгийг чинь хамгаалж үлдчихсэн учраас өнөөдөр тэнд баялаг байгаа.

Тийм учраас энэ зүйл дээр ингэж онцгой өөрчлөлт хийж өгөөч ээ гэдгийг л би хүсээд байгаа юм.

Хоёрт нь, энэ Компанийн тухай хууль дээр давуу эрхийн 10 хувийн хувьцаа гэж байна. Тэгээд төлөөлөн удирдах зөвлөлд нь хэдэн хувь байх юм? Манайх.

Р.Сэддорж: 4 номер. Хариулт. Н.Учрал сайд.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээн дээр 11 дүгээр зүйл орон нутгийн хөгжил гээд тусгайлан зохицуулсан. Ер нь өмнөх хөрөнгө оруулалтын гэрээнээс гол ялгагдаж байгаа давуу тал.

Тийм учраас М.Бадамсүрэн гишүүний хөндлөнтөд байгаа асуудал маш зөв байгаа юм.

Үнэхээр орон нутгийг бодитоор дэмжих ёстой. Энэ ч утгаараа бид сая төрийн эзэмшлийн 34-ийг орлуулж байгаа “тусгай АМНАТ”-ыг л “Хуримтлалын сан”-д шилжүүлж байгаа нь бас мэдээж иргэдэд, өнөөдрийн иргэдэд эрүүл мэнд, боловсрол, орон сууцдаа зарцуулна.

Мэдээж “суурь АМНАТ”, дахиад энэ Цөмийн энергийн хуулийн хүрээнд бид шийдсэн нөгөө өсөн нэмэгдэх тэр рояалти бол 0-ээс 9 хувь гээд аваад үзэхээр яг өнөөдрийн ханшаар 5, 6 хувь гээд бодохоор энэ бол цаашдаа үнэ өсөхөөр 9 хувь хүрнэ. Энэ нь өөрөө “Ирээдүйн өв сан”-д тэр 65 хувь нь очоод, үлдсэн нь “Орон нутгийн сан”, “Тогтворжуулалтын сан” хоёрт хуваагаад орно.

Тэгэхээр түрүүн гишүүдийн асуулт дээр гараад байсан одоо яг орон нутагт яг хэд орох юм бэ гэдэг дээр орон нутгийн төслийн нийт хугацаанд татвар хураамжаас 957.0 сая доллар, жилд 29 сая доллар. Дээрээс нь ус болон газрын төлбөр 33 сая, орон нутагт дэмжлэг хэлбэрээр түрүүн хэлсэн нөгөө 1 сая доллар төсөл хэрэгжиж эхлэх үеэс аваад эхлэхээр 44 сая доллар. Нийт 1 тэрбум ам.долларын мөнгөн урсгал орохоор санхүүгийн загвар дээр тооцоологдсон. Тэгэхээр энэ бол бодитоор орно.

Дээрээс нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь аймаг руу шууд шилжиж байгаа. Аймаг руу шилжиж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг тэр сумаа хэрхэн дэмжих юм бэ гэдгийг аймаг, орон нутаг өөрөө шийдвэрлээд явна.

Тэгэхээр бодитой дэмжлэг бол энэ хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд шийдвэрлэгдэж байгаа. Анх жил болгон 1 сая долларыг тэр нийгмийн шинж чанартай төслүүдийг хэрэгжүүлэхэд тухайн сумд 1 сая долларыг олгоно гэж байсан дээр зөвхөн аймаг шийдэж байх хэлбэр байсныг бид аймгийн Засаг дарга,

сумын Засаг дарга тэр зөвлөлөө хуралдуулаад зөвлөлдөө тухайн 1 сая доллароор юу хийх вэ гэдгээ шийдвэрлээд явах бололцоо бүрдэнэ.

Бид хамтдаа төрийн эзэмшлийн 34-ийг АМНАТ-аар орлуулснаараа эрсдэлээс ангижирч байгаа юм. Эрсдэлгүй орлого буюу шууд борлуулалтаас нь авах учраас тухайн компани ашигтай, ашиггүй ажиллахаас үл хамаараад нөгөө “өсөн нэмэгдэх АМНАТ”, “суурь АМНАТ” “Ирээдүйн өв сан”-д шилжээд, үлдсэн нь “Орон нутгийн сан”-д орно гэхээр энэ тооцоолж болж байгаа санхүүгийн загвар.

Тэгэхээр бид өөрсдийнхөө санхүүгийн загвар дээр тооцоологдсоноороо энэ 1 тэрбум ам.долларын мөнгөн урсгал орно гэж тооцоолсон.

Ингээд аймаг, сумын зөвлөл хуралдаад аль асуудлаа шийдвэрлэх вэ гэдгээ тэр сая доллароороо шийднэ.

Мөн төсөл хэрэгжиж дууссаны дараа ашиглагдах дэд бүтцийг орон нутагт үнэ төлбөргүйгээр шилжүүлнэ гэдгийг хүртэл энэ гэрээн дээрээ тусгасан. Орон нутагт хийх хөрөнгө оруулалтыг 11.2 дээр 3 үе шаттайгаар хийнэ гэдгийг.../минут дуусав/

Р.Сэддорж: Баярлалаа. Г.Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Г.Уянгахишиг: Энэ дээр нэг тодруулах юм байгаа юм. Одоо энэ дээр бид Их Хурлаас тогтоол гаргах гэж байна шүү дээ.

Тэгээд энэ Их Хурлаас гарсан тогтоолыг ерөнхийдөө үндэслээд хэлэлцээр дээр гол тохиролцоонууд буюу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх тэр нөхцөлүүдтэй холбоотой гэрээний гол нөхцөлүүдийн үндэслэл суурь болж явах ёстой.

Тэгэхээр энэ дээр одоо яг найруулгын хувьд жишээлбэл эхний 1 дүгээр зүйл дээр “10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа” гээд оруулаад ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь өөрөө давуу эрхийн хувьцаа, гаргасан давуу эрхийн хувьцааг төр 100 хувь эзэмших гээд байгаа. Өөрөөр хэлэх юм бол дахиж давуу эрхийн хувьцаа гарахгүй гэж ойлгож байгаа. Нэгдүгээрт, тэр зөв үү? Миний ойлголт зөв үү?

Хэрвээ зөвхөн төр давуу эрхийн хувьцаа эзэмшинэ. Өөр давуу эрхийн хувьцаа эзэмшигч байхгүй гэвэл бид 10 хувийн давуу эрхийн хувьцааны тухай биш давуу эрхийн хувьцаа нь өөрөө хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх гэдэг энэ агуулгаар орж тусгагдаж явах ёстой.

Энэ нь одоо нөгөө нэг гэрээний заалт дээр ч гэсэн байгаа байхгүй юу. Гэрээний 7 дугаар зүйл дээр 7.1 дээр байгаа юм. “А”, “Б” хоёр дээр. Энэ дээр

гаргасан “давуу эрхийн хувьцааны 10 хувь” гэдэг ойлголт ерөөсөө байхгүй. Ерөөсөө компанийн хувь нийлүүлсэн, equity-гийн буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний давуу эрхийн хувьцааг төр эзэмшинэ гэдэг зохицуулалт байгаа.

Тийм учраас найруулгын хувьд өөрөө гаргасан давуу эрхийн хувьцааны 10 хувь гэж ойлгогдоод байгаа учраас эхний асуултын хариулт буюу гаргасан бүх давуу эрхийн хувьцааг төр эзэмшинэ гэдэг зөв үү гэдэг дээр нэг хариулт авмаар байна.

Тэгээд энэ хариултаас шалтгаалаад энэ дээр буцаагаад бид давуу эрхийн хувьцаанд хөрвүүлнэ. Гэхдээ давуу эрхийн хувьцаанд тавигдах шаардлагыг нь бид 2 дугаар зүйл болгож нэмж оруулах. Ингэснээрээ энэ давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхдээ энэ давуу эрхийн хувьцаа чинь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байна шүү. Энэ нь өөрөө буурч болохгүй шүү гэдэг заалтуудыг оруулж орж ирж байж орлуулах тухай тогтоолын маань үндсэн агуулга зөв болж орж ирэх гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр саяын тэр давуу эрхтэй холбоотой асуултад хариулт авчихъя гэж бодоод.

Р.Сэддорж: 4 номер Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тэр давуу эрхийн хувьцааг бид компанийн хуулиар өөрчлөлт оруулаад Цөмийн энергийн хуулийг дагаад шийдсэн.

Давуу эрхийн хувьцааны энэ удаагийн гол онцлог нь юу юм бэ гэхээр тэр “veto”^[хориг тавих] эрхтэй л гэсэн үг л дээ. Засгийн газар хориг тавих эрхтэй.

Тэгэхээр ТУЗ-д нэг л төлөөлөл сууна гэсэн үг. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн хувиар. Гэхдээ нэг онцлогтой. Тэр бол хориг тавих эрхтэй. Хориг тавих эрхтэй давуу эрхийн хувьцаа гэдэг бол одоо маш том боломж байхгүй юу.

Одоо Жишээ нь, Оюу Толгой дээр 3 хүн ТУЗ-д сууж байгаа. Тэгэхдээ хориг тавих эрхгүй шүү дээ. Хориг тавих эрхгүй. Нэг ёсондоо ТУЗ олонхоороо асуудлыг шийдээд явдаг.

Бид энэ удаа хэдийгээр нэг төлөөлөлтэй ч гэсэн энэ нөгөө “veto” эрхтэй гэдэг утгаараа хориг тавих эрх нь үүсэж байгаа юм.

Дээрээс нь хөрөнгө оруулагч талтай бид ямар асуудал дээр тохиролцсон бэ гэхээр манайд давуу эрхийн 10 хувийн хувьцаа гаргаж байгаа бол дахиж ямар нэгэн байдлаар давуу эрхийн хувьцаа гаргахгүй гэдэг дээрээ хатуу тохирсон.

Ингээд хөрөнгө оруулалтын гэрээ Их Хуралтай зөвшилцөөд бид Засгийн газар байгуулна. Үүний дараа компани хооронд нөгөө “Хувь нийлүүлэгчийн гэрээ”, “Орд ашиглах гэрээ” дахиж байгуулагдана.

Тэгэхээр 3 байгууллага дээр зөвлөх үйлчилгээ аваад ажилласан. Дотоодын санхүүгийн үйлчилгээ авсан. Ингээд энэ багууд үргэлжлүүлээд бид яг энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй параллель “Орд ашиглах гэрээ”, “Хувь нийлүүлэгчийн гэрээ”-г боловсруулж байгаа.

Тэгэхээр “Хувь нийлүүлэгчийн гэрээ”, “Орд ашиглах гэрээ”-н дээр нарийвчилсан зохицуулалтуудыг тусгана. Тэгэхдээ зарчмын хувьд дахиж ямар нэгэн байдлаар давуу эрхийн хувьцааг хэн нэг нь олгохгүй байх үүргийг хөрөнгө оруулагч тал хүлээж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ бусад өмнөх хөрөнгө оруулалтын гэрээтэй харьцуулахад хориг тавих эрхтэй давуу эрхийн хувьцаа учраас энэ маш том боломжийг манай талд өгч байгаа.

Тэгэхээр төлөөлж байгаа нэг хүн тэр ТУЗ-д суух төлөөлөл бол хориг тавиад ингээд үйл ажиллагаанд оролцоод явна. Мэдээж давуу эрхийн хувьцаа нөгөө санхүүгийн хариуцлага хүлээхгүй гэдэг утгаараа бид ямар нэгэн хөрөнгө оруулах, зээл авлаа гэхэд түүнд нь хариуцлага хүлээх ийм ямар ч ойлголт огт байхгүй.

Тэгэхээр өмнөх хөрөнгө оруулалтын гэрээг бодох юм бол эрсдэл багатай гэж ойлгож болно.

Үүн дээр нэмэлтээр Д.Баярхүү зөвлөх тодорхой мэдээлэл өгнө.

Р.Сэддорж: 6 номер нэмж хариулъя.

Д.Баярхүү: Түрүүний М.Бадамсүрэн гишүүний санаа нь зовоод.

Тэр орон нутгийн хөгжил гэсэн асуудал дээр би нэг мэдээлэл өгье гэсэн юм. Тэгээд манай ахлагч намайг мэдээлэл өгч болно гэлээ.

Сая яг тэр уул уурхай түшсэн орон нутгийн хөгжил гэдгийг Унгарт туршлагыг нь судалж яваад ирлээ л дээ би.

Тэгэхээр Унгарт ямар туршлага байна вэ гэхээр түрүүн манай сайдын яриад байгаа дотор нөгөө 1 сая доллар чинь байж л байна. Тэр орон нутгийн зөвлөл байж байна. Бүгд байна.

Тэгээд Унгарын “Paks-1” гэж атомын цахилгаан станц байдаг хөдөөгийн тэр нутагт очсон. тэнд “Paks-1” гэж цахилгаан станцыг нь үзсэн.

Хоёрдугаарт, “Paks-2” атомын цахилгаан станцын суурь тавьж байгаа тэр процесстой танилцсан.

Тэгээд биднийг РосАтом урьж, РусАтомын урилгаар очсон юм.

Тэгэхээр тэр “Paks-1”-ийн дэргэд байгаа Унгарын 16 хот, тосгон нийлээд нутгийн нэг том зөвлөл болчихсон. Тэгээд тэнд ямар давуу эрх эдэлж байна вэ гэхээр яг л түрүүн манай энэ хуульд байгаа шиг 1 сая долларыг тэр үйлдвэр тэр 16 хот, тосгоны зөвлөлд жил болгон хуваарилдаг.

Тэгээд тэр 1 сая долларыг хүлээж аваад тэр 16 хот, тосгоны зөвлөлийн дарга нар суугаад юунд зарцуулах вэ гэдгээ ярилцаж байсан тэр хуралдаа биднийг оруулсан.

Тэгээд тэр яах вэ, унгараараа ярьж байсан. Тэгээд л гараа өргөөд л, алх цохиод л их л эрчимтэй хэлэлцэж байна. Тэгээд голцуу дандаа нийгмийн асуудалд, нийгмийн ажилд зориулдаг гэж.

Тэгээд “Paks-1”-ийг түшсэн тэр хөдөөгийн 16 хот, тосгон Унгартаа хамгийн өндөр амьдралын стандарттай, хамгийн өндөр цалинтай, хүмүүс нь тэр нутагт сууж байгаадаа аз жаргалтай байдаг. Бас энд тэндээс олон хүн шилжүүлэн суурьшуулдаггүй ийм нутаг гэж.

Тэгэхээр тэр атомын цахилгаан станц бол хамгийн түрүүнд тайлангаа орон нутагт тавьдаг юм байна. Тэр 16 хот, тосгонд тавьдаг юм байна. Үйл ажиллагааныхаа тайланг.

Тэгэхээр бидний энэ боловсруулаад байгаа хууль чинь 2028 оноос яг энэ чинь ингээд л хэрэгжээд л явах. Тэр 1 сая доллар, тэр орон нутаг. Тийм ээ. /минут дуусав/

Р.Сэддорж: Г.Уянгахишиг гишүүн нэмж тодруулж асууя гэж байна. Тодруулга.

Дараа нь микрофон дээр та үргэлжлүүлээд ярьчих.

Г.Уянгахишиг: Мик нь байхгүй болчихоод.

Сая яг миний асуусан асуултын хариулт ирэхгүй байна. Асуусан асуулт болохоороо яг одоо энэ би нөгөө давуу эрхийн хувьцааг ойлгож байгаа. Тийм ээ. Яг ямар эрхүүд дагалдаж байгаа, бүгдийг нь ойлгож байгаа. Гол нь компанийн давуу эрхийн хувьцаа гаргана шүү дээ.

Тэгэхээр тэр гаргаж байгаа давуу эрхийн хувьцааг бүхэлд нь төр эзэмшинэ биз дээ байхгүй юу. Өөрөөр хэлбэл юу гэдэг юм 100 ширхэг давуу эрхийн хувьцаа

гаргаснаа тэрнээс 10-ыг нь төр эзэмшинэ, 90-ийг нь өөр хэн нэгэн эзэмшинэ гэсэн агуулга байхгүй биз дээ гэсэн асуулт байхгүй юу.

Р.Сэддорж: Хариулт. 4 Номер. Н.Учрал сайд.

Н.Учрал: Энэ бол яг хэлэлцээрийн түвшинд яригдсан.

Ялангуяа Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр бас протокол зурагдаж байх үед Сангийн сайд тухайн үеийн Хэрэг эрхлэхийн сайд Д.Амарбаясгалан дарга гээд энэ хэлэлцээрийн протокол дээр ч тусгагдсан юм билээ.

Тэр нь юу гэхээр 10 хувийн давуу эрхийн хувьцааг бүхэлд нь эзэмшинэ. Үүнээс илүү давуу эрх хувьцаа гаргах ойлголт огт байхгүй.

Тэгэхээр бид хувь нийлүүлэгчдийн гэрээ, орд ашиглах гэрээнүүд хийгдэнэ. Тэр үеэр детальчлаад үүнийг тусгаад явна. Тэгээд хэлэлцээр хийж байсан протоколын үеэр энэ яригдаад энэ зарчмын саналд аль аль тал зөв зөвшөөрсөн.

Тэгэхээр 10 хувиас илүү давуу эрхийн хувьцаа гэдэг ойлголт байхгүй. 10 хувиа төр эзэмшинэ.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна уу? Тэгвэл Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Тэгэхээр би сая хэлээд байгаа нь тэр байхгүй юу. Тогтоол дээр 10 хувийн давуу эрхийн хувьцаа гэхихсэн байгаа шүү дээ.

Тэгэхээр 10 хувийн давуу эрхийн хувьцаа гэдэг маань гээд хэлчихээр давуу эрхийн хувьцааны 10 хувь гэж ойлгогдоод байгаа байхгүй юу.

Тийм учраас хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний давуу эрхийн хувьцаа бүхэлдээ төрийн эзэмшил байна гэсэн үг. Тийм ээ. Тийм.

Р.Сэддорж: Одоо энэ дэд бүтцийн асуудлууд ер нь яригдсан юм байна.

Тэгэхээр авто замын километр чиглэлийг сонирхож болох уу? Төмөр замын километр, чиглэлийг сонирхож болох уу? Тухайн энэ уурхай хэдэн га талбайг? Тухайн сумын хэдэн хувь нь, газар нутгийн хэдэн хувийг нь үйл ажиллагаа явуулах юм бэ? Жишээ нь, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын газар нутгийн хэдэн хувьд нь үйл ажиллагаа явуулах вэ гэсэн ийм асуулт байна.

2 номер.

А.Алтанхундага: “Мон-Атом” компанийн уулын ашиглалтын инженер А.Алтанхундага байна. Таны асуултад хариулъя.

Нийтдээ авто замын хувьд Зүүнбаянгаас уурхай хүртэл 50 километр авто замыг тавина.

Төмөр замыг Зүүнбаян дээр өргөтгөл хийж төмөр замыг зохион байгуулахаар техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан.

Мөн Улаанбадрах сум руу сайжруулсан сайжруулсан замыг тавихаар төлөвлөсөн байгаа. Таны асуусан хамгийн сүүлийн асуулт нь хэдэн хувь гэсэн үү. Энэ нэлээн бага хувь байгаа. Нийт ашиглалтын талбай 10-ыг харьцах нь 6 километр өргөнтэй.

Тэгэхээр нэлээн бага хувь байх ёстой. Би таны асуултад үүнийг тухайлаад хариулъя. Тэгэх үү. Болох уу. Яг хувиар нь мэдэхгүй байна. Нэлээн тэг зууны хэдэн хувь.

Р.Сэддорж: Та тэгвэл бичгээр өгчих. Тийм ээ.

А.Алтанхундага: Тэгье.

Р.Сэддорж: 10-ыг үржих нь 6 километрын талбайг ашиглана гэж ойлголоо шүү дээ. Тийм ээ.

А.Алтанхундага: 48 мянган га талбайд үйл ажиллагаа явуулна.

Р.Сэддорж: Сумын төв рүүгээ засмал зам тавихгүй юм уу?

А.Алтанхундага: Яг Зүүнбаян руу 50 километр засмал зам тавьж байгаа. Нөгөө Улаанбадрах руу бол сайжруулсан зам тавихаар төлөвлөсөн байгаа.

Р.Сэддорж: Засмал зам тавих хэрэгтэй дээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа анхаараарай.

Ингээд эхлээд ажлын хэсгээс гаргасан хоёр санал дээр санал хураалт явуулна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн саналын томъёолол.

1.Төслийн 1 дэх заалтын “MV-018915 дугаартай “Дулаан-Уул”” гэснийг “MV-018916 дугаартай Дулаан-Уул” гэж, “MV-018916 дугаартай Зөөвч-Овоо”” гэснийг “MV-018915 дугаартай Зөөвч-Овоо”” гэж тус тус өөрчлөх.

Гэрчилгээний дугаарыг бичихдээ дугаараа өөрчлөөд ороод ирсэн юм байна. Солиод биччихсэн юм байна.

Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

68.8 хувийн саналаар ажлын хэсгийн 1 дүгээр санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дахь заалтыг “Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсэг саналаа тайлбарлах уу?

Ажлын хэсгийн гаргасан хоёр дахь саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналууд гарсан байна.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг дараах агуулга бүхий заалтыг нэмэх.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1/төрийн эзэмшлийн 10 хувийн давуу эрхийн хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

2/нийт гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцаанд эзлэх төрийн эзэмшлийн хувь хэмжээг 10 хувиас бууруулахгүй байх.

Санал гаргасан санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг.

Санал тайлбарлах уу? Г.Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлая.

Г.Уянгахишиг: Тийм. Ерөнхийдөө түрүүний тайлбарласанчлан ерөнхий нөхцөлүүдээ бас эндээ оруулж авахгүй болохгүй юм байна гэдгээр хоёр нэмэлт нөхцөлийг нь баримтал, энэ зарчмыг баримтална шүү гэдгээр л оруулж ирж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Санал хураалт. Саяын гаргасан томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор.

Санал дэмжигдсэнгүй. М.Мандхай гишүүн санал гаргая.

М.Мандхай: Сая кноп ажиллаагүй учраас дэмжсэнээр бүртгүүлье. Тэгвэл дахиад санал гаргах уу? Тэгвэл дахиад санал хураалт явуулж өгнө үү?

Р.Сэддорж: М.Мандхай гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

56.3 хувийн хувийн саналаар санал дэмжигдэж, санал хүчингүй боллоо. Санал хураалт хүчингүй боллоо.

Саяын Г.Уянгахишиг гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя. /алх цохив/

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Тогтоолын төслийн дугаарлалтыг нийцүүлэн өөрчлөх гэсэн томъёоллоор санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг.

Г.Уянгахишиг гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саналын томъёолол. 1 дүгээр зүйлд “төрийн эзэмшлийн 34 хувийн” гэсний дараа “энгийн” гэж нэмэх.

1 дүгээр зүйлийн тусгай төлбөр болон “10 хувийн” гэдгийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг.

Г.Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлаарай.

Г.Уянгахишиг: Энэ дээр ингэж байгаа юм.

1 дүгээр заалт дээр төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нэгэнт давуу эрхийн хувьцааны тухай яригдаж байгаа тохиолдолд 34 хувиа энгийн хувьцаа гэж тодотгохгүй бол зөвхөн шууд хувьцаа гэдгээрээ орчхоод байгаа учраас 34 хувийн энгийн хувьцааг давуу эрхийн

хувьцаанд хөрвүүлэх гэдгээр нөгөө энгийн гэдэг үгийг нэмж байгаа юм. Энэ өөрөө редакц маягаар орж байгаа гэсэн санаа байхгүй юу.

Дараагийнх нь болохоор түрүүн тайлбарласанчлан 2 дугаар заалт нэмчхэж байгаа учраас тэр 34 хувийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх гэдгээр оруулаад. Яг нөгөө 10 хувийн давуу эрхийн хувьцаанд гэхээр болохгүй болчхоод байгаа учраас 10 хувийн гэдгийг нь хасъя л гэдэг санал оруулж ирж байгаа юм.

Хэрвээ 10 хувиа авч үлдэнэ гэх юм бол тусгай төлбөр болон компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж орлуулах гээд. Эсвэл бүр тодорхойлж нэмж оруулна гэсэн үг.

Одоогийн гаргаж байгаа санал нь 10 хувь гэдгээ хасаад 2 дахь заалт дээрээ нөгөө 10 хувийнхаа зохицуулалтуудыг оруулдгаараа оруулаад явчихвал ингээд нэг ийм нэгдмэл болох гээд байгаа л гэсэн санаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн зүгээр байр суурийг сонсьё. Б.Пүрэвдорж гишүүн.

Г.Уянгахишиг гишүүний гаргасан саяын саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

31.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Шинээр 3 дахь заалт нэмэх.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

М.Бадамсүрэн гишүүн саналаа тайлбарлая.

М.Бадамсүрэн: Энэ үндсэн АМНАТ 5 хувь гээд байгаа шүү дээ. Үндсэн АМНАТ 5 хувь орж байгаа төлбөрийнх нь орлого нь бүхэлдээ улсын төсөв, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд орж байгаа.

Тэгээд энэ орлогынх нь 30 хувь буюу гуравны нэгийг нь тухайн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт нь хуваарилдаг ийм эрх зүйн үндсийг тогтоох талаар цаашид Засгийн газар анхаараач ээ л гэдэг ийм л санал. Түүнээс энд бид шууд шийдвэр гаргаж байгаа юм энэ тогтоолын төсөл дээр ороогүй. Миний дэвшүүлж байгаа зарчмын зөрүүтэй саналд.

Ер нь цаашид энэ зүйлийг ингэж оруулж ирээч.

Яагаад гэвэл нэг дэх сорилт нь Их Хурлын босгыг давах энэ хөрөнгө оруулалтын гэрээ.

Хоёр дахь нь, орон нутгийн эсэргүүцлийг давах асуудал байгаа шүү.

Энд юу гэдэг юм орон нутгаас сонгогдсон гишүүн болохоор ингээд байна гэж бодохоос илүүтэй би бол энэ төрийн ажлаа бодож байна. Улс орны эдийн засаг өсөөсэй гэж бодож байна. Орон нутаг дагаад хөгжөөсэй гэж бодож байна. Бие даалгах хэрэгтэй байна. Орон нутгийг.

Тийм учраас энэ шинэчлэлтийг хийвэл яасан юм бэ. Яагаад гэвэл Ашигт малтмалын малтмалын тухай хуулийн шинэчилсэн хуулийн төсөл дээр Уул уурхайн яамны өргөн мэдүүлж байгаа энэ төсөл дээр 20 хувь гэж байгаа. Яг энэ АМНАТ-ийн чинь төлбөрийн 20 хувь.

Миний хувьд 30 хувь байвал яасан юм бэ гэдэг саналыг л дэвшүүлж байгаа юм. Энэ хуулийн төсөл дээр явж байгаа юм байна лээ.

Тэгэхдээ үүнийг жоохон дээшлүүлээд гуравны нэг болгочхооч ээ. Тэгээд үүнийг цаашид анхаарч өгөөч ээ гэдэг ийм л саналтай. Үүнийг Байнгын хорооны гишүүдээсээ дэмжиж өгөөсэй л гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Ажлын хэсэг энэ дээр хэлэх санал байна уу?

Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг энэ тухайлан “Бадрах энерги”-гийн гэрээтэй холбоотойгоор тогтоолын төсөл гарч байгаа.

Тэгэхээр М.Бадамсүрэн гишүүний гаргаж байгаа энэ санал зөв санал. Яагаад гэвэл орон нутгийнхаа иргэдийн тодорхой асуудлыг шийдэж байж тухайн бүс нутагт, тэр нутгийг авч үлдсэн ард иргэдийн асуудлыг шийдвэрлэнэ гэдэг зөв.

Тэгэхдээ Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн ажлын хэсэг тун идэвхтэй ажиллаж байгаа.

Өнгөрсөн долоо хоногт лав хоёр ч удаа хуралдсан байх. Дахиад хуралдана. Тэгэхээр энэ Ашигт малтмалын тухай хуульд бүр тусгайлан заалт болгож, тогтоолын төсөлд оруулж байхын оронд хуулийн төсөлд Та заалт болгож оруулбал илүү их үр дүнтэй, хүчтэй заалт болно гэж би үзэж байна.

Тийм учраас таны энэ заалтыг дэмжиж байгаа. Тэгэхдээ Эдийн засгийн байнгын хорооны гишүүд энэ асуудлыг кнопороо дарж шийдвэрлэнэ.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүний гаргасан саяын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

31.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Хавсралтын “40-өөс 50 хүртэл 0.5 хувь” гэснийг “40-өөс дээш 5 хувь” гэж өөрчилж, “50-иас дээш 5 хувь” гэсэн мөрийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд.

Л.Соронзонболд гишүүн саналаа тайлбарлая.

Л.Соронзонболд, Яах вэ, АМНАТ ер нь хамгийн багадаа 5 хувь байх ёстой гэдэг утгаар нь 5-аар нь явах нь зөв байх гэж ойлгож байна.

Ажлын хэсэг яах вэ гэрээний нөхцөлд зөвшилцөлд хүрэхийн тулд 0.5 гэсэн гээд байгаа байхгүй юу. Тэгэхдээ 5 хувиараа байх нь зөв өө л гэж бодож байна. 40-өөс дээш 5 хувь гээд л.

Тэгэхээр мэдээж энэ компани 40-өөс аль ч тохиолдолд тэгээд л 5 хувийг нь АМНАТ-аа л төлөх ёстой байхгүй юу.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

43.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

П.Батчимэг гишүүний санал байна. Бид энэ Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэж байгаа.

Гишүүнээс Монгол Улсын Засгийн газар ба Франц Улсын “Орано Майнинг” компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний тухай Улсын Их Хурлын гэрээний тухай саналууд ирсэн байна.

Ингээд яг өнөөдрийн тогтоолтой холбоотой гишүүний ирүүлсэн саналуудаас санал хураалгана.

П.Батчимэг гишүүн. 1, 2-оо тайлбарлах уу? П.Батчимэг гишүүний микрофоныг нээе.

П.Батчимэг: Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе.

Өнөөдөр Монгол Улсын Засгийн газар ба Франц Улсын “Орано Майнинг” компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж байгаа.

Тэгэхдээ миний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй 3 санал бол хөрөнгө оруулалтын гэрээн дээр оруулах өөрчлөлтийн тийм санал орж ирсэн.

Гэхдээ өнөөдөр ингээд Их Хурлын тогтоолын төсөлд нэгэнт энэ гэрээний тухай заалтууд ороод ирчихсэн учраас би энэ зарчмын 3 зөрүүтэй саналаа тайлбарлая гэж бодож байна.

Саналын нэгдүгээр асуудал бол бас л энэ гэрээний төслийн 7 дугаар зүйлийн “д” дээр бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болзлын дагуу худалдан авч болно гээд сая бидний ярьсан асуудал.

Энэ зарчмын саналыг оруулж байгаа үндэслэл нь 2009 онд Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын баримт бичигт Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болно гэсэн.

Мөн цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүч ашиглах нь Монгол Улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангах өртөг багатай цахилгаан, дулаан үйлдвэрлэх гэсэн энэ заалтуудыг оруулсан байдаг юм.

Тэгээд хөрөнгө оруулалтын гэрээний энэ заалтад Монгол Улс өөрийн газар нутгаас олборлож байгаа түүхий эд, ашигт малтмал, бүтээгдэхүүнийг худалдан авах эрхийг хязгаарласан ийм заалт болжээ гэж би хувьдаа үзэж байгаа юм.

Тэгээд цөмийн энергийн салбарт нөлөө бүхий тоглогч болох энэ стратегийн зорилгод тодорхой хэмжээний саад агуулсан байна гэж үзээд үүнийг өмнө дурдсан хувь хэмжээг нэмэгдүүлэх нь манай улсын стратегийн зорилгод нийцнэ гэж үзсэн.

Хоёрдугаарт, Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн 7 дугаар зүйлийн төрийн эзэмшлийн хувьцаа 7.1-ийн “д” дээр Засгийн газар нь төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 10 гишүүнээс 1 гишүүг л Засгийн газраас томилно. Тийм ээ. Энэ томилсон гишүүн нь аудитын хорооны гишүүн байна гэсэн байгаа юм.

Тэгэхээр энэ компанийн тухай хуульд 75.4 дээр төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан.

Гэтэл энэ хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд төсөл хэрэгжүүлэгч компани нь ТУЗ-ийн нийт 10 гишүүнтэй байхаар тэдгээрийн нэг нь л Засгийн газрын төлөөлөл байгаа нь дэндүү ядмаг тоо байгаа санагдаж байгаа юм.

Тэгээд төсөл хэрэгжүүлэгч компанийн удирдлагыг хэрэгжүүлэх компанийн талаар мэдээлэлтэй байх гэх мэт ийм учир дутагдлууд гарч ирж байна. Иймд компанийн хуульд нийцүүлж төсөл хэрэгжүүлэгч компанийн ТУЗ-д Засгийн газрын төлөөлөл 3 гишүүн байх нь зүйтэй гэж би үзэж байгаа юм.

Ингээд компанийн ТУЗ-ийн нийт гишүүдийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар ийм өөрчлөлтийг оруулъя гэсэн саналыг оруулж ирж байна.

Гуравдугаарт, Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн 8 дугаар зүйл байгаль орчинд учирсан хохирлыг арилгах 8.3-ын “б” дээр. Энэ төсөл хэрэгжих бүх үе шатад байгаль орчинд бий болохуйц хорт нөлөөллийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас, мал, эд хөрөнгөд учирсан хохирол байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг төсөл хэрэгжүүлэгч компани бүрэн хариуцна гэсэн.

Энэ “Орано Майнинг” компани өөрөө ямар нэгэн даатгалын олон улсын даатгалд орсон компани мөн эсэхийг судалж үүнийг үзсэн байдаг юм уу?

Тэгээд ер нь энэ их олон том эрсдэлүүдийг тооцож үзэхээр бид заавал энэ эрсдэлийг даатгуулахыг шаардах нь зүйтэй юм гэсэн ийм 3 санал дээр санал хураалгая гэж бодож байгаа.

Саналын нэг дээр Засгийн газрын бүтээгдэхүүн худалдах, худалдан авах онцгой эрхийн хувь хэмжээг нэмэгдүүлж, 50-аас багагүй болгох.

Хоёрдугаарт, Засгийн газар нь төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 10 гишүүнээс 3 гишүүнийг томилох эрхтэй.../минут дуусав/

Р.Сэддорж: Би тайлбарлачихъя.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг өнөөдөр хэлэлцэж байгаа.

Яг хөрөнгө оруулалтын гэрээг хэлэлцэх хурал өнөөдөр биш. Одоо удахгүй Байнгын хороогоор орох юм байна.

Тэгэхээр та энэ 3 саналаа, маш ач холбогдолтой 3 санал. Яг хэлэлцэх Байнгын хороон дээр ирүүлэх юм байна. Түүгээр санал хураачихъя. Тийм. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр. Тийм. Энэ долоо хоногийн хуваарь дээр байхгүй байгаа. Ингээд гишүүн тэр Байнгын хороон дээр саналаа гаргах нь байна.

П.Батчимэг гишүүний 3 санал хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой. Засгийн газрын бүтээгдэхүүн худалдан авах онцгой эрхийн хэмжээг нэмэгдүүлж, 50 хувиас багагүй болгох.

Хоёрт нь, Засгийн газар нь төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 10 гишүүнээс 3 гишүүнийг нь томилох эрхтэй байх. Төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байх.

Гуравт нь, байгаль орчинтой холбоотой цацраг идэвхт бодис олборлох, ашиглах, боловсруулах, борлуулах, хадгалах үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учруулж буй болзошгүй эрсдэлийг олон улсын жишгийн дагуу даатгалд хамруулах гээд даатгалын ийм саналуудыг оруулж ирсэн байна.

Ингээд хэлэлцэх Байнгын хорооны хурал дээр таныг саналаа гаргахыг хүсье.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа орлоо.

**Гурав.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар
захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн
мэдээллийг сонсох**

Гурав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.1 дэх хэсгийг баримтлан Улсын Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн мэдээллийг сонсож эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнийг ажлын хэсгийн мэдээллээ танилцуулахыг урьж байна.

Гишүүний микрофоныг нээе. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Б.Бат-Эрдэнэ: Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа.

Бид хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд нэлээн олон асуултуудыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандаас асуусан юм.

Өнөөдөр бид энэ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, биелэлтийг хянан шалгах болон хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар асуултынхаа хариуг өнөөдөр Эдийн засгийн байнгын хороогоор авч байна.

Тодорхой холбогдох албан тушаалтнууд орж ирэхээр асуух асуултуудаа асуугаад явъя гэж бодож байгаа.

Ер нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт яг өнөөдөр ямар түвшинд явж байгаа вэ. Хэрэглэгчийн эрх зөрчигдсөөр байх уу. Хүний эрхийн нэг хэсэг болох энэ хэрэглэгчийн эрх дээр төрийн байгууллага болон төрийн бус байгууллагууд хэр түвшинд ажиллаж байгаа вэ. Энэ дээр ямар дүгнэлтүүдийг бид хийх ёстой вэ гэдгийг анхаарч үзэх ёстой гэж харж байгаа.

Энэ утга агуулгынхаа хүрээнд холбогдох төрийн байгууллагуудаас, мөн одоо хариуцсан сайдаас нь бид Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн холбоо бүхий асуудлуудыг Улсын Их Хурлын гишүүний асуултаар асуусан юм. Тэгээд энд тодорхой хэмжээний хариултууд ирсэн байна.

Гэхдээ маш хангалтгүй хариултууд ирсэн байна. Тэгээд одоо ажлын хэсэг орж ирж байгаа учраас энэ ажлын хэсгээс дэлгэрүүлээд асуугаад явчихъя гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Б.Бат-Эрдэнэ гишүүний ахалсан ажлын хэсгийн мэдээлэл байгаа.

Их Хурлын даргын 2024 оны 86 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээлэл. О.Номинчимэг гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Т.Доржханд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, З.Лхагвадорж Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Б.Билгүүн Монополын эсрэг газрын дарга.

Ингээд П.Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Сайн байцгаана уу?

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчны асуудал гээд яриад байгаа юм.

Тэгээд Улсын Их Хурал дээр 54 ажлын хэсэг гараад ажлын хэсгүүдийн уялдаа холбоо зарим зүйлүүдийг анхаарахаас өөр аргагүй байдалд байна. Яг үнэндээ хэлэхэд арилжаа, бизнесийн хууль тогтоомжийг сайжруулах гээд гарчхаад байгаа боловч иргэний хуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх гээд.

Яг энэ уялдаатай асуудлуудыг маш ийм салангид байдлаар баахан ажлын хэсэг гарчихсан явж байна.

Жоохон онолын сонсогдож магадгүй. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг сүүлдээ захиргааны эрх зүй болгож Монгол Улсад хувиргаад хэрэглэгч өөрөө эрх ашгаа хамгаалах бүрэн бололцоогүй болгож байна.

Уг нь энэ хувийн эрх зүйн асуудал байдаг. Тэгээд маш олон хуулиудаар зохицуулагдаж байгаа юм л даа. Үндсэндээ би “B2C” /**business-to-consumer** (B2C)/ гэдэг харилцаа.

Тэгээд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал яригдахаар нэг байгууллагыг томруулах асуудал яригдаад байгаа юм. Энэ ерөөсөө байгууллагыг томруулах гэхээсээ илүүтэйгээр ерөнхийдөө иргэний хууль тогтоомж дахь болон бусад хууль тогтоомжоор байгаа гэрээний харилцаа, ялангуяа гэрээний тэгш байдлыг хангахад зарим зүйлээрээ хэлэлцээрт орох боломжгүй буюу стандарт гэрээнүүд дээр зурдаг ийм харилцаанууд дээр энэ гэрээний нөхцөлүүдийг тэр хууль дээр нь тодорхой болгож өгөх л асуудал юм.

Жишээ нь, орон сууц худалдаж авах, банкнаас үйлчилгээ худалдаж авах ч гэдэг юм уу. Өнөөдөр дэлгүүрээс хүнсний зүйл авч байгаа ч гэсэн хэрэглэгчийн эрх ашиг байхгүй юу.

Тэгээд энэ асуудлуудыг ерөөсөө ойлгодог байгууллага байхгүй.

Тэгээд энэ байгууллагыг зөвхөн нэгдүгээрт чиг үүргийн хувьд аваачаад Шударга өрсөлдөөний газартаа нэгтгээд хаячихсан. Энэ чинь тэр байгууллагын асуудал биш юм. Уг нь тусдаа.

Тэгээд энэ өөрөө эргээд компаниуд хэт зүй ёсны монопол, зүй бус монопол, эсвэл тодорхой хэмжээний зах зээлийн төвлөрөл явагдаж байгаа, эсвэл картель үүсгэж байгаа асуудлыг шийддэг байгууллагын дэргэд хэрэглэгчийн эрх ашгийг буюу өдөр тутмын ийм юмнуудыг авна гэдэг бол асар буруу болчихоод байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө Монгол Улсад энэ асуудлыг хаясан. Мэргэжлийн хяналтын байгууллагад явж байсан.

Өнөөдөр орон сууц авахад метр квадрат байтугай захиалга дээр байгаа орон сууцын тэр захиалж байсан цонх ч гэдэг юм уу, шал нь хүртэл өөрөөр солигдоод ирэхээр яаж ч чадахгүй байгаа шүү дээ. Сантехникийн материал нь хүртэл асар доголдолтой ороод ирэхээр яаж ч чадахгүй.

Тэгэхээр уг нь асуудал нь энэ захиргааны журмаа шийдэх биш, эрхийн доголдлын асуудал, биет бус доголдлын асуудал гээд Иргэний хуулийн том концепцын асуудал юм.

Тэгээд үүнийг ингэж салангид байдлаар ерөөсөө өм цөм санал, дүгнэлт гаргана гээд яваад байгаадаа бас харамсаад байгаа юм.

Яах вэ зарим орнуудад бол ингээд.../минут дуусав/

Р.Сэддорж: П.Сайнзориг гишүүнд нэмж 1 минут.

П.Сайнзориг: Зарим оронд хэрэглэгчийн эрх ашиг хамгаалахад хэрэглэгч таатай бус гэрээ санал болгодог байгууллагуудын жагсаалтыг хэрэглэгчийн эрх хамгаалдаг байгууллагаасаа зарладаг юм. Одоо гахай гэдэг ч юм уу, эсвэл таатай бус гэрээт гэрээний нөхцөл санал болгодог байгууллага гээд эндээсээ илүү их одоо энэ бизнесийн нэр хүндээ бодоод байгууллагууд бас хэрэглэгчийн эрх ашгаа хамгаалдаг.

Ер нь эрхийн доголдол болон биет бус доголдолтой холбоотойгоор гомдол хүлээж авах механизмыг бизнесийн байгууллагууд тогтвортой байлгах, гомдлыг хүлээж авах хаягийн өөрчлөлтүүдээ хэрэглэгчдэдээ өгөх. Өнөөдөр жишээ нь харилцаа холбооны операторууд хүртэл тэгж байгаа шүү дээ. Үнийн өөрчлөлтийг сонин дээр жижигхэн зар тавьчихаад бүгдийг нь хэрэглэгчдээ жигдхэн шиг өөрчилчихдөг.

Ерөөсөө хэрэглэгчийг нийтлэг байдлаар хохироодог ийм хэрэглэгчийн гэрээний асуудал битүү байгаа байхгүй юу. Орон сууц худалдаж авах, энэ операторын үйлчилгээнүүд, утасны үйлчилгээнүүд. Дээрээс нь энэ зуучлалын үйлчилгээ байгаа. Эрүүл мэнд болон боловсролын. Ийм зүйлүүд дээр байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг би нэг ултай суурьтай үзээч ээ.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт хэн байна? Гараа өргөөрэй. 5 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Б.Билгүүн: Сайн байцаана уу? Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн байна.

П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль маань өөрөө бас нэлээн хэдэн жилийн өмнө батлагдсан. Одоо гар хүрэх шаардлага нь үүссэн.

Саяын таны хэлж байгаа түмэн зөв өө. Одоо энэ гэрээний асуудлууд байгаа. Хэрэглэгчийн эрх ашгийг зохицуулах хууль эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ шаардлага бий болчихоод байгаа юм.

Энэ дээр сүүлийн үед манай дээр ирж байгаа дийлэнх гомдлын нэг нь цахим худалдаа, цахим үйлчилгээний гомдлууд тасархаа байсан.

Тэгэхээр үүнийг зохицуулсан хууль эрх зүйн орчин Монгол Улсад өнөөдөр байхгүй байгаа.

Тэгэхээр гол нь бид Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль дээр энэ цахим худалдаа, түүнийг дагаж байгаа хуулийн зохицуулалтуудыг юуны түрүүнд зохицуулах шаардлага үүссэн. Цаашлаад бусад хууль эрх зүйн орчинтойгоо уялдуулах. Таны хэлж байгаачлан бусад хуультайгаа уялдуулах, цогцоор нь шийдвэрлэх асуудлыг бүрэн дүүрэн дэмжиж байна.

Энэ дээр Б.Бат-Эрдэнэ гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Хуулийн хэлэлцүүлгүүдээ явуулаад эхэлсэн.

Энэ дээр гарч байгаа санал, дүгнэлтүүдийг бид бүхэн хуульдаа тусгаад явж байгаа. Хуулийн хувьд гэвэл олон улсдаа яг шударга өрсөлдөөний асуудал, өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллага нь хэрэглэгчийн эрхээ давхар хариуцаад явдаг ийм сайн туршлага бол бий. Монгол Улс яг тэр жишгээр явж байгаа улсуудын нэг. Өрсөлдөөний үр дүнд хэн хожих вэ гэдэг асуудлыг голлон ярьдаг юм билээ. Олон улсдаа.

Тэгэхээр өрсөлдөөнийг зөв зохистой түвшинд нь байлгаж, эцсийн дүндээ хэрэглэгчээрээ хожих ёстой.

Тэгэхээр хэрэглэгчийн асуудал энэ дээр зоосны нөгөө тал нь мөн юм гэдэг асуудал энд яригдах юм.

Нөгөөтээгүүр шинэ хуулийн төсөл дээрээ бид Мэргэжлийн нэгдсэн холбооны хуультайгаа бас уялдуулаад зарим чиг үүргээ төрийн бус байгууллагаар хэрэгжүүлэх боломж бололцоог нь бий болгоё. Тэрийгээ энэ хууль дээрээ тодорхой зааж өгье гэдэг байдлаар шийдвэрлэхээр төлөвлөж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй үзэж тодруулъя. П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд Б.Бат-Эрдэнэ гишүүнээр ахлуулаад явж байгаа юм байна.

Тэгээд ер нь хэрэглэгчийн гэрээний асуудлын суурь асуудал нь гэрээний харилцаа байдаг юм шүү.

Түүнээс биш хэт бүх зүйлүүдийг төр оролцоотойгоор бизнесийн байгууллага хэрэглэгч хоорондын юмнууд хутгалдаж орно гэдэг зүйл ерөөсөө байж болохгүй.

Хэрэглэгч гэрээгээ үргэлжлүүлэх, гэрээнээсээ татгалзах, эсвэл эрхийн болон биет байдлын доголдолтой зүйлүүд дээр үйлчилгээ болон бараа, материалаасаа татгалзах гэдэг юм уу, үүнээсээ үүсэж байгаа санхүүгийн болон эдийн засгийн тэр хохирлоо барагдуулах л механизмыг зөв хийж өгөх нь чухал болохоос биш байгууллага байгуулж өгөөд явдаг зүйл байхгүй.

Дээрээс нь ерөөсөө стандартын асуудал байгаа. Жишээ нь, Япон дээр хүнсний бүтээгдэхүүний хаяг дээр доторх тэр савлагаанаасаа өөр өнгө зүстэй зүйлүүдийг реклам болгож хаяг шошго дээрээ тавихыг хориглочихсон байдаг байхгүй юу. Чихрийг нь гаргаад үзээрэй. Яг уутны уутан дээр байгаа чихрийн зурагтайгаа яг адилхан бүтээгдэхүүнүүд байдаг.

Ингэж байж хэрэглэгчийнхээ эрх ашгийг хамгаалдаг, стандарт болон гэрээний харилцааг сайжруулдаг болохоос биш захиргааны байгууллага.../минут дуусав/

Р.Сэддорж: М.Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Би нэг тодруулах маягтайгаар асуучихъя гэж бодож байна.

Энэ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль дээр 4 дэх хэсэг дээр барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ гээд байгаа шүү дээ. Ломбардын. Энэ үйл ажиллагаан дээр нэг ийм асуудал байгаа юм. Одоо ломбардын үнэлгээ болохоор жишээлбэл сая 500-гийн үнэлгээтэй барьцаа хөрөнгө тавиад, тэгсэн мөртлөө үнэлгээг нь гэрээний дагуу бууруулахдаа 500 төгрөгийн зээл олгож байгаа.

Тэгээд тухайн зээлдэгч маань мөнгөө төлж чадахгүйгээс болоод өөрийнхөө барьцаа хөрөнгөө буцааж авах боломжгүй болоход эргээд ломбард сая 500 байтугай 2 сая төгрөгөөр үнэлэгдээд нөгөө хөрөнгийг нь зарчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр манай дээр одоо жишээлбэл яг энэ тохиолдолд зохицуулалтууд ер нь тухайн хэрэглэгчийг одоо юу гэдэг юм үнэлгээгээ алдсанаас тухайн үнэлгээг хооронд нь харьцуулж үзээд илүү гарсан дээр нь буцаан олголт ч гэдэг юм уу, эсвэл тухайн хэрэглэгчийг хохирлоос нь тодорхой түвшинд бууруулах тийм

зохицуулалтуудыг байдаг юм болов уу? Яг ийм тохиолдол дээр яаж зохицуулагдаж явж байгаа вэ гэдгээс нэг тодруулаад асууж болох уу?

Р.Сэддорж: 6 номер. Өөрийгөө танилцуулаад. Хариулт.

Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш.

М.Мандхай гишүүний асуултад хариулъя.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 12.9-д хэрэглэгчийг илтэд хохирооход чиглэсэн гэрээ байгуулахыг хориглох эрх зүйн зохицуулалт одоо ч гэсэн мөрдөгдөж байгаа. Үүний хүрээнд хэрэглэгч таны сая ярьсан тохиолдолд эрх ашиг сонирхол нь хөндөгдөж байна гэж үзэх юм бол хандаад асуудлаа шийдвэрлэх боломж бүрэн байгаа. Ер нь яг энэ төрлийн бас кэйсүүд цөөн ч гэсэн тохиолдоод шийдэгдэж байсан тохиолдлууд бий. 12.9.

Р.Сэддорж: М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: 12.9. Тэгэхдээ энэ чинь шийдэгдэж чадахгүй байгаад байна гэдэг гомдлууд ирээд байдаг байхгүй юу.

Тэгэхээр асуудал бүрэн шийдэгдээд явж байгаа юу гэдэг нь тодорхой бус л юм байна.

Тэгэхээр өөр хуулиар зохицуулагдаж байгаа гэж ойлголоо. Тийм ээ.

Р.Сэддорж: О.Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Асуулгын хариутай танилцсан. 5 асуудал тавимаар байгаа.

Нэгдүгээрт, асуултын хариултуудыг харахаар манай Монополын газар яг энэ монопол шударга өрсөлдөөний чиг үүрэг болон хэрэглэгчийн чиг үүргээ ерөөсөө ялгахгүй байна.

Хэрэглэгчийн хамгаалах чиг үүргээ ялгаагүй байгаа байхгүй юу. Та бүгдийн асуултын яг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад дандаа өрсөлдөөн, шударга өрсөлдөөнийг хангах замаар үнийг яаж бууруулах вэ, картелийг багасгах вэ. Тэр талаар хийсэн ажлууд чинь ихэвчлэн байна.

Тэгэхээр Монополын эсрэг газар буюу яг энэ шударга өрсөлдөөнийг хангах асуудал бол мэдээж үнэтэй холбоотой. Гэхдээ энэ бол ерөөсөө гол чиглэл зорилго

нь зах зээлийг эрүүл байлгах. Тийм ээ. Зах зээл дээр байгаа аж ахуйн нэгж нийлүүлэлт, supply and demand. Тийм ээ. Мэрнийг яг нөгөө зах зээлийн яг цэвэр нөгөө нэг эрүүл орчинд байлгахад л анхаарч байх ёстой шүү дээ. Тийм ээ. Энэ дээр урьд нь цөмөөрөө ажлын хэсэг дээр яаж байсан. Цэвэр манай микро эдийн засагчид ажиллаж байх ёстой. Зах зээлийн анализ хийж байх ёстой газар.

Хэрэглэгчийн эрх ашиг гэхээр энэ зөвхөн үнэтэй холбоотой асуудал биш. Үнэ бол яах вэ зөвхөн нэг хэсэг нь. Хэрэглэгчийн хувьд ерөөсөө дандаа энэ бараа, ажил, үйлчилгээний чанар, үйлчилгээ, дефект асуудал. Тийм ээ. Энэ асуудлууд гарах юм бол яаж хандах вэ, яаж хамгаалах вэ гэдэг асуудал. Үүнтэй холбоотой хариу ирээгүй байсан.

Тэгэхээр энэ дээрээ нэгдүгээрт анхаараач.

Хоёрдугаарт, Хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ хийгдсэн үү гэсэн чинь ер нь юм бичээгүй. 2019 онд бид нэг бичсэн.

Тэгэхээр ерөөсөө хэрэгжилт 2003 оны, одоо 20 жил гаруй болоод байгаа энэ хуулийн хэрэгжилт дээр үр дагаврын үнэлгээ хийгээгүй байна гэж ойлгож байгаа нь зөв үү.

Хоёрдугаарт, ер нь хэрвээ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалъя гэвэл бид нэгдүгээрт би иргэний хуулийн хэрэгжилттэй танилцах ажлын хэсгийг бас ахалж байгаа юм. Суурь иргэний хуулиа харах юм бол манай дээр яалт ч үгүй хэрэглэгчийн гэрээний асуудал манай иргэний хууль дээр хангалттай тусаж өгөөгүй.

Тэгэхээр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр ерөөсөө хэрэглэгч болон үйлдвэрлэгч, худалдаалагчийн bargaining power буюу хүч тэнцвэртэй бус гэрээний харилцааг яаж зохицуулах вэ л гэдэг асуудал орж ирэх ёстой.

Төрийн байгууллагын чиг үүрэг нь энэ дээр яаж орох вэ гэхээр Монгол Улс ерөөсөө импортын орон. Бүх иргэдийн хэрэглэж байгаа ихэнх эд хэрэгсэл, тоглоом, хүүхдүүдийн тоглож байгаа тоглоом бүгд импортоор орж ирж байгаа. Энэ бүгд чинь дандаа нөгөө defects liability period буюу дандаа нөгөө доголдлыг яах, чанарыг нь эргээд яах юм бол manufacturer буюу үйлдвэрлэгчид нь гомдол гаргах эрх нь тухайн улсуудын хуулиараа байдаг. Манай Монгол Улс импортлогчийн хувьд тэгвэл манай иргэд энэ бараа, бүтээгдэхүүнээс болж хохирох юм бол яаж үүнийг тэгвэл бид зохицуулах вэ? Яаж дотоодын эрх зүйтэй бид энэ хүмүүст хариуцлага хүлээ.../минут дуусав/

Р.Сэддорж: О.Номинчимэг гишүүнд 1 минут.

О.Номинчимэг: Анхаарах ёстой.

Тэгэхээр энэ талын асуудлууд Та бүхний хийж байгаа шинэчлэл, хуулийн зохицуулалт дээр орж байгаа юу?

Дараагийн асуудал Зар сурталчилгааны тухай хууль байгаа. Танай асуулга дээр бичсэн байсан. Манай дээр одоо ингээд фэйсбүүк, инстаграм, одоо инфлюенсерүүдийн зар сурталчилгаагаар бараа, бүтээгдэхүүнийг маш их сурталчилдаг болсон.

Тэр нь амьдрал дээр аваад хэрэглэхээр яг сурталчилгаа шигээ биш байдаг. Тийм ээ. Тэгээд та хэд дээр угаасаа энэ Европын Холбооныхон зөндөө сургалт хийсэн байх.

Энэ influencer буюу influencer advertising хийж байгаа, зар сурталчилгаа хийж байгаа болоод заавал зохицуулалт байх ёстой. Ямар нэгэн зөвлөмжүүд байх ёстой гэсэн. Энэ маань өөрөө уг нь зар сурталчилгааны тухай хууль дээрээ орж ирэх ёстой.

Энэ бол өөрөө хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал байхгүй юу. Яг төрийн байгууллагын зохицуулалт хийх хүрээнд. Тэгээд үүнтэй холбоотой ямар нэгэн өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хийж байгаа юу гэдгээр.

Хамгийн сүүлийн асуулт болохоор илүү та бүхний хувьд хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой шүүхийн шийдвэрүүд, иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүд ер нь хэр.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт. 5 номер.

Б.Билгүүн: О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулсан манай тайлан дээр ерөнхийдөө яг өнгөрсөн хугацаанд хийгдсэн голлох ажлууд. Энэ дээр өрсөлдөөн, хэрэглэгч хоёулаа түрүүн хэлсэнчлэн хоорондоо салшгүй холбоотой нэг зоосны хоёр тал байдаг учраас асуумжийн хариултад яалт ч үгүй өрсөлдөөний асуудал маань давхар орж ирээд байгаа юм.

Өрсөлдөөний асуудлыг хэрэглэгчээс ялгаж байгаа гол юм гэвэл та сая хэлж байгаа. Тийм ээ. Бараа, бүтээгдэхүүний чанарын асуудал гээд гэх юм бол яг үүнтэй холбоотой гомдлууд явж байгаа. Түүнийх нь дагуу кэйсүүд үүсээд явж байгаа.

Жилдээ нэг манай дээр 4 мянга гаруй гомдол ирж байгаа. Түүнээс 200 гаруй нь яг кэйс үүсээд явдаг.

Энэ дээр зөрчлийн хэрэг үүсгээд шүүхээр шийдэгдэж байгаа асуудлууд ч бий. Хялбаршуулаад шийдэгдэж байгаа асуудлууд ч би.

Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хувьд гэвэл өрсөлдөөнөө бид бүхэн Өрсөлдөөний тухай хууль дээрээ бас тодорхой заагаад зах зээлийн орчныг тодорхой болгох зорилгоор явж байгаа.

Яг энэ хуулийнх нь үр дагаврын үнэлгээг хийсэн үү гээд асуулаа. Энэ дээр яг одоогоор хийгдээгүй байгаа. Өмнөх хуулийн төсөл дээр хийгдэж байсан. Одоогийнх дээр хийгдээгүй байгаа. Хийгдэхээр хүлээгдэж байгаа.

Гэрээний асуудал бол яг манай энэ хууль дээр бас тодорхой заагаагүй байдаг. Тэрийг тодорхой заах нь аль хууль дээрээ орох вэ гээд П.Сайнзориг гишүүний хэлж байгаачлан тусгаад явах байх.

Зуучлалын асуудал бас манай дээр орхигдчихсон ийм салбар байдаг. Одоогийн хууль дээр бол яг энэ зуучлалын асуудал байхгүй. Үүнийг энэ хууль дээр бас тусгаж оруулъя гэдэг ийм байр суурьтай байгаа.

Нөгөө хоёр асуултад нь манай Ц.Тэрбиш дарга 6 дугаар микрофоноос хариулна.

Р.Сэддорж: 6 дугаар микрофон.

Ц.Тэрбиш: Энэ хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлын хамгийн чухал асуудал бол энэ гэрээний эрх тэгш байдлыг хангах асуудал, ялангуяа энэ стандарт гэрээний асуудал байгаа юм.

Одоо би нэг тодорхой жишээ дурдъя. Манайх эрчим хүчний компаниуд дээр шалгалт хийгээд эрчим хүчний хэрэглэгчийн стандарт гэрээн дээр энэ тэгш байдал алдагдсан байна гээд зөвлөмж шаардлагаа хүргүүлж байсан ийм тохиолдол байгаа.

Эрчим хүчний компаниуд зөвхөн хэрэглэгчийн үүргүүдийг зааснаас бусдаар хэрэглэгчийн эрхүүд тэнд ерөөсөө хангагдах боломжгүй ийм стандарт гэрээ хийгдсэн байсныг бид шаардлага хүргүүлээд гэрээний эрх тэгш байдлыг хангах тодорхой ажлууд хийгдэж байсан кэйсүүд бий.

Тэр Зар сурталчилгааны тухай хуультай холбоотой influencer-ийн.../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж хариулах уу? Гүйцээж хариулъя. 6 номер.

Ц.Тэрбиш: Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд захиалагч, зар сурталчилгаа захиалагч, түгээгч, бүтээгч гурав гурвуулаа адилхан хариуцлага хүлээхээр зохицуулагдаад явж байгаа.

Энэ хүрээндээ асуудал шийдэгдэж байгаа. Тэгэхдээ ер нь яг энэ influencer-ийн асуудлыг Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд

зохицуулах ийм оролдлогууд хийгдэж байгаа. Зарим орны туршлагаудыг судлаад явж байгаа. Тухайлах юм бол манай өмнөд хөрш influenza маань тухайн бүтээгдэхүүнээ заавал өөрөө хэрэглэсэн байхыг шаардах эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлээд эхэлсэн жишээнүүд байдаг.

Тэгээд энэ дээр бид Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд асуудлыг ярьж байгаа.

Р.Сэддорж: О.Номинчимэг гишүүн хариулт хангалтгүй гэж үзье. Микрофон дээр хэлчихгүй юу. О.Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Иргэний шүүхээр Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн зүйл, заалтыг бариад. Тэнд чинь зөндөө олон иргэд бариад очоод хохирсон эрхээ хамгаалуулах зүйл, заалтууд байгаа шүү дээ.

Энэ дээр яаж шүүх шийдэж байгаа вэ? Та бүхэн чинь хэрэгжүүлэгч агентлаг болсон. Хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа агентлаг шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр шүүх дээр очоод яаж байна? Шүүх дээр ер нь хэр их кэйсүүд очиж байна? Ямар байдалтай байна гэдэг дээр дүн шинжилгээ хийсэн юм байна уу гэдэг дээр.

Р.Сэддорж: 6 номер. Хариулт.

Ц.Тэрбиш: Энэ дээр бид чиглэлүүдийг сонгоод судалгаа хийсэн тохиолдлууд бий. Тухайлах юм бол банкны нөгөө 1 хувийн шимтгэлийн асуудал дээр захиргааны болон иргэний 2 кэйс хоёулаа зэрэгцээд явсан байгаа.

Эхлээд иргэнийх нь кэйс нь шүүхээр амжилттай шийдэгдсэний дараа захиргааны хэргийн шүүхийн процесс явахад илүү их дөхөм болж өгч байгаа. Энэ 2 бол яалт ч үгүй нийгэм, харилцааны хоёрыг талыг одоо энэ захиргааны болон хувийн эрх зүйн хүрээнд шийдээд явж болж байгаа ийм тодорхой кэйсүүд байгаа.

Р.Сэддорж: Тодруулгаа авчихсан даа. О.Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Ер нь ойлголоо. Ямархуу хэмжээнд мэдээлэлтэй байгаа, яаж ажиллаж байгааг чинь ойлголоо.

Түрүүн Б.Билгүүн дарга хэлсэн шүү дээ. Энэ хууль дээр хийгдэж байгаа биш. Би асууж байгаа нь 2003 онд баталсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль хорин хэдэн жил болчихлоо. Энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн юм уу? 5 жил тутамдаа хийх ёстой гээд Б.Бат-Эрдэнэ гишүүний асуулга дээр байгаа шүү дээ.

Энэ хууль дээр хэрэгжилтийн үнэлгээгээ хийсэн юм уу? Тэгж байж бид дараагийн хууль руугаа орохгүй бол энэ хуулийн чинь юу нь болохгүй, юу нь

яахгүй байна гэдэг юмаа та хэд одоо нөгөө хийдэг газраар нь хийлгүүлсэн юм уу л гэдэг асуултыг асуугаад байгаа юм. Тэрийг тодруулъя.

Р.Сэддорж: Хариулт. 5 номер.

Б.Билгүүн: О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Яг энэ судалгаа хийгдээгүй байгаа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Б.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Ингээд хэлэлцэх асуудлын 4 дэх асуудал.

Дөрөв.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөрийг мэдээллээ танилцуулахыг урьж байна.

Сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Эдийн засгийн байнгын хорооны даргаас 12 сарын 17-нд Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн талаар, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг сонсохоор төлөвлөсөн байна.

Тэгэхээр энэ мэдээллийг одоо хийгээч ээ гэдэг ийм хүсэлт гэх юм уу, албан даалгавар ирүүлсэн байгаа.

Тэгээд энэ дагуу бид танилцуулгаа гишүүдэд, Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн. Байнгын хорооны удирдлага гишүүддээ түгээсэн гэдэгт найдаж байна.

Тийм учраас би товчхон Та бүхэнд мэдээлэл өгөөд, тэгээд Та бүхэн асуулт байвал асуугаад яваарай гэж хүсмээр байна.

Тэгээд Та бүхэндээ шинэ оны мэнд хүргэе.

2025 он бол Монгол орны эдийн засаг, нийгмийн харилцаанд хамгийн чухал үүрэгтэй он жил болж байгаа. Монгол Улс цаашаагаа хөгжих үү, хөгжихгүй юу, Монголын ирээдүй гэрэлтэй байх уу, үгүй юу гэдгийг 2025 он ерөнхийдөө хагална гэсэн ийм ойлголттой байна.

Ер нь бид урт хугацааны болоод хөгжлийн бодлогыг байнга нэгнээсээ нэхэж байдаг.

Тэгээд яг Монгол төрийн бодлого юу юм бэ, хөгжлийн бодлого юу юм бэ гэдэг ийм эрэл хайгуул бүх түвшинд хийгдэж байдаг.

Тэгээд үнэндээ бид хөгжлийн бодлогоо Үндсэн хуулиа л гэж харах хэрэгтэй гэж хэлмээр байгаа юм. Монгол Улсын Үндсэн хууль бол Монгол орны хөгжлийн болоод ирээдүйн бодлогын хамгийн том баримт бичиг. Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх, Үндсэн хуулийг ягштал мөрдөх гэдэг бол бидний эдийн засаг болоод хөгжлийн хамгийн том бодлого байгаа юм.

Тийм учраас бодлогын баримт бичиг болоод бусад бодлогын төлөвлөлт, хөгжил гэдэг зүйл яг Үндсэн хуулиа бид хэрхэн хэрэгжүүлэх вэ? Ялангуяа монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдарна гэдэг энэ үзэл санааг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Монгол хүн эдийн засгийн эрх чөлөөг бүрэн эдэлнэ гэдгийг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Дээр нь монгол хүн сурч боловсрох, хөдөлмөрлөх бүрэн эрхтэй гэдгийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг энэ зүйл байгаа юм.

Энэ хэрэгжилт бүрэн хангагдах үед Монгол төрийн хөгжлийн бодлого өнөөдөр бүрэн хэрэгжиж байна гэж бүх түвшиндээ ойлгоосой гэж. Урт хугацааны бодлогын тухайд энэ байгаа юм.

Хоёр дахь асуудал мэдээж яг Үндсэн хуулиасаа урган гарсан засаглалын асуудал байгаа юм. Засаглал хэр нээлттэй байх вэ, хэр зэрэг бид энэ парламентын засаглалыг хамгаалж чадах вэ гэдгээс монгол хөгжлийн бодлого маш тодорхой харагдана.

Бид парламентын засаглал, нээлттэй засаглал дээр алдаа гаргах юм бол Монголын хөгжил зогсоно. Монголын хөгжлийг зогсоохыг хүсдэг, дайсагнадаг бүлэглэл, бүлэг хүмүүс үеийн үед оршиж ирсэн. Оршин байгаа. Энэ хүмүүсийн тухайд Монгол Улсыг парламентын засаглалаас нь хазайлгах, Монгол Улсын Их Хурлын нэр хүндэд халдах, Монголын улс төрийн намуудыг хүчгүй болгох, хоорондоо ярилцдаг, хэлэлцдэг зүйлийг таслан зогсоолгох, хөнжилдөө орсон мэтээр. Эс бол найрч байгаа хүмүүс мэтээр ингэж харлуулах нь Монголын хөгжлийг болоод Монголын парламентыг хүчгүйдүүлэх бодлогын үзүүр харагдаж байгаа юм.

Тийм учраас хөгжлийн бодлого гэж юу вэ гэхээр тогтвортой байдлын тухай л ойлголт гэдгийг бүгдээрээ ойлгоосой гэж хүсэж байна. Ялангуяа, Эдийн засгийн байнгын хороо бол засаг төрийн бодлого тогтвортой байх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг бүрэн хэрэгжүүлэх ёстой. Ингэж байж Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн бүтэн байдлыг бид хамгаалах юм байна. Энэ бол одоо бидний алсын хараа, Монгол төрийн хар хайрцгийн бодлого Үндсэн хуульдаа оршино гэдгийг Та бүхэндээ хэлье.

Тийм учраас засаглалаа хамгаалах, ил тод байдлыг бий болгох, цахим засаглалыг бий болгох нь Монголын хөгжлийн хамгийн чухал бодлогуудын нэг байх болов уу гэж би хоёрдугаарт нь хэлмээр байгаа юм.

Гуравдугаарт, мэдээж хэрэг эдийн засгийн эрх чөлөө. Бид ардчилсан хувьсгалынхаа үр дүнд үг хэлэх эрх чөлөөгөө авсан, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө авсан. Одоо эдийн засгийн эрх чөлөөнд хүрэх ёстой. Улс орон ч гэсэн эдийн засгийн тусгаар тогтнолоо олж авах ёстой. Ард түмэн ч гэсэн эдийн засгийнхаа эрх чөлөөг авах ёстой. Хувийн хэвшлийнхэн компаниуд ямар нэгэн дарамт, гаднын нөлөөгүйгээр явж чадах тэр эрх чөлөөндөө хүрэх ёстой. Ингэж байж бидний хамгийн холын бодлого, хамгийн холын зорилт Монгол түмнээ санхүүгийн эрх чөлөөнд хүргэх, Монгол орон өөрөө санхүүгийн эрх чөлөөнд хүрэх.

Энэ эрх чөлөө гэдэг ойлголт бол одоо манай бодлогын цөм хэсэг байна гэдгийг Та бүхэндээ хэлмээр байгаа юм.

Нэг үгээр хэлбэл Монгол төрийн бодлого гэж юу вэ гэдэг энэ асуулт Эдийн засаг, хөгжлийн яам бол ийм 3 зүйл дээр томъёолж байгаа юм. Үүнийгээ бид хөгжлийнхөө хөтөлбөр, бодлого зорилтууддаа оруулаад явж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Бодлого, төлөвлөлтийн тухайд 3 түвшинд харж байгаа. Эхнийх нь “урт хугацааны бодлого”. Дараагийнх нь “дунд хугацааны бодлого”. Хөгжил төлөвлөлтийн хуультай. Энэ хуулийнхаа дагуу Үндсэн хуульд орсон нэмэлтээр хөгжил төлөвлөлтийг хэрэгжүүлнэ гэдгийг Үндсэн хуулиараа хийчихсэн.

Тийм учраас дунд хугацааны хөгжлийн бодлогоо бид гаргадаг. Энэ бол 8-аас 10 жилийн хугацаатай гардаг. Богино хугацааны хөгжлийн бодлогоо гаргадаг. Тэр нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг гаргадаг.

Бид жишээлбэл өнгөрсөн чуулганаар 2025 оныхоо хөгжлийн төлөвлөгөөг баталчихсан байгаа гэж ойлгож болно.

Тэгэхээр урт хугацааны яг Монгол Улсын хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого юу юм бэ гэдэг асуудал байгаа юм. Урт хугацаандаа Монгол Улсын эдийн засгийн бодлого нь юу юм бэ. 2050 гэдэг хөгжлийн бодлогоо бид баталчихсан. Улс төрийн намууд зөвшилцсөн. Нийгэмтэйгээ ойлголцолд хүрсэн.

Ер нь урт хугацааны хөгжлийн бичиг баримттай больё гээд **“Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө-2050”** гэж.

Тэгэхээр энд тавигдсан хамгийн том зорилт нэгдүгээрт “Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ” гэдэг ийм зорилттой байгаа. Тогтвортой хөгжил.

Одоо дэлхий даяараа энэ зарлан тунхаглаж байгаа, эрэл хайгуул хийж байгаа, дэлхийн улс орнууд хүрэхийг тэмүүлж байгаа зүйл бол тогтвортой хөгжил байгаа.

“Тогтвортой хөгжил” гэдэг нь өөрөө өөрийгөө авч явж чаддаг, өөрөө өөрийгөө нөхөн сэргээж чаддаг, нөхөн сэргээх тэр instrument-үүдээ бүрэн ашиглаж дайчилж чаддаг тэр хөгжлийг л тэгж томъёолж байгаа юм. Энэ нь залгаад **“Ногоон хөгжил”** байгаа юм.

Тэгэхээр урт хугацаандаа Монгол Улс тогтвортой, ногоон хөгжлийг чиг баримжаагаа болгож үүнийгээ ажил хэрэг болгож явна гэсэн ийм зорилттой, үүнийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна гэдгээ Та бүхэндээ хэлье.

Хоёр дахь зорилго “шинжлэх ухаанч орон” болохыг зорьж байгаа. Урт хугацаандаа. Өнөөдөр бид шинжлэх ухааныг зүгээр ашиглаж байгаа хүмүүс байгаа. Шинжлэх ухааныг уншиж байгаа хүмүүс байгаа. Шинжлэх ухаантай танилцаж байгаа хүмүүс байгаа. Бид ямар улс болох вэ гэхээр шинжлэх ухааныг бүтээдэг ард түмэн болох ёстой. Бүтээдэг улс орон болох ёстой. Шинжлэх ухааны хэрэглэгчээс шинжлэх ухааныг гаргаж ирж чаддаг тэр бүтээгч сэтгэхүйтэй эдийн засаг, бүтээлч эдийн засаг, бүтээлч ард түмнийг бий болгох зорилго, бодлого бид өнөөдөр урт хугацаандаа хэрэгжүүлж байгаа бодлого юм гэдгийг Та бүхэндээ хэлье.

Гуравдугаарт, мэдээж бид тэргүүлэгч улс болох ёстой. Дэлхий дээрх манлайлагч улс гэхээсээ илүү бид тэргүүлэгч эдийн засагтай орон болно гэдэг ийм зорилтыг урт хугацаандаа бид энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа. Ялангуяа

- ▶ Нээлттэй эдийн засгаараа бид тэргүүлэх ёстой.

- ▶ Эдийн засгийн эрх чөлөөний индексүүдээрээ бид тэргүүлэх ёстой.
- ▶ Авлигын индексээр, сайн улсын индексээр, сайн засаглалын индексээр бид тэргүүлэх ёстой.

Энэ бол манай төрийн урт хугацааны бодлого байгаа юм.

Нэгтгээд хэлэх юм аз жаргалын индексийнхээ араас явна гэдэг ийм урт хугацааны бодлоготой улс гэдгийг Та бүхэндээ хэлье.

Яг Үндсэн хууль дээр заасан шиг ард түмэн тэр эрх чөлөө, аз жаргалаа эдэлж чаддаг ийм улс орон болж хөгжих нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн эдийн засгийн.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр гишүүний микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Би жоохон тайван яриад байгаа нь 25 минут танилцуулга хийнэ гэж ойлгоод ингээд тайван яриад байгаа шүү. Р.Сэддорж дарга аа.

Ер нь бодлогуудаа би Эдийн засгийнхаа байнгын хороонд ярья гэж бодож байгаа юм. Та бүхэн маань бас тэвчээртэйгээр сонсоосой гэж хүсэж байна.

Энэ ямар нэгэн телевиз мэдээлэлд ярьж байгаа зүйл биш. Би Та бүхэнд хандаж Эдийн засаг, хөгжлийн яамны ерөнхий бодлого, чиг баримжааг бол хэлж байгаа юм шүү гэж.

Мэдээж хоёр дахь хөгжлийн бодлого бол “дунд хугацааны хөгжлийн бодлого” байгаа. Дунд хугацааны хөгжлийн бодлогодоо бид үндсэндээ суурь нь юу юм бэ гэхээр “урт хугацааныхаа хөгжлийн бодлого” дээр суурилсан, “Шинэ сэргэлтийн бодлого” дээр суурилсан хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр байгаа. Хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр байгаа.

Тэгэхээр мөрийн хөтөлбөрийг Их Хурал батлахдаа үндсэн хэд хэдэн чиглэл өгсөн. Засгийн газрын санал санаачилгыг дэмжиж үндсэн чиглэлүүд өгсөн. Энэ бодлогын баримт бичгийг өнөөдөр бид ажил хэрэг болгоод явж байна гэж.

Нэгдүгээрт, “үйлдвэрлэгч улс” болно гэдэг ийм зорилтыг дэвшүүлж байгаа юм. Мэдээж “үйлдвэрлэгч улс” болохын тулд “эрчим хүчтэй улс” болно. Эрчим хүчний үйлдвэрлэлээрээ манлайлж байж дагасан үйлдвэрлэлүүд бий болох юм байна. Эрчим хүчний реформ хийгдэж байж эрчим хүчний үйлдвэрлэл бий болох юм байна. Энэ бодлогыг өнөөдөр хэрэгжүүлэхээр бид ажиллаж байна, хэрэгжүүлж байна.

Тийм учраас энэ хүрээнд гол бодлогууд боловсруулагдаж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

Хоёрдугаарт, эдийн засгийнхаа тэргүүлэх салбарыг бид хамгаалах ёстой, улам өндөр түвшинд хөгжүүлэх хэрэгтэй.

Бид нарын дунд хугацааны бодлого дотор ялангуяа яг энэ 4 жилийн хугацаанд хаана хүрэх вэ гэдгийг нэг тоогоор бид илэрхийлсэн. Их Хурал ч үүнтэйгээ санал нэг байгаа.

“Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган америк долларт хүргэнэ” гэсэн энэ бодлогыг одоо бид хэрэгжүүлж байгаа.

Ингэхийн тулд эдийн засгийнхаа өсөлтийг 6 хувиас дээшээ байлгана гэж байгаа юм. Ялангуяа 2025 онд эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэнэ гэсэн ийм зорилттой байгаа.

Инфляцыг нэг оронтой тогоонд хязгаарлана гэдэг энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа юм. Мэдээж ингэхийн тулд уул уурхайн салбараа бид түлхүү хөгжүүлнэ. Хөгжүүлнэ гэдэг нь байгаа зүйлээ юм болгоно гэж байгаа юм. Байгаа зүйлээ илүү чадалтай болгоно. Илүү дэлхийн хэмжээний тоглогч болно гэж байгаа.

Тэр утгаараа Та бүхэн өнөөдөр Эдийн засгийн байнгын хороон дээр ураны олборлолтын төслийг Их Хурал өөрөө дэмжсэн, хэлэлцээрийг дэмжсэн. Энэ төслийг хэрхэн хэрэгжүүлэх тухай бүх шатдаа ярьж байгаа. Жишээлбэл, уран олборлолт зөвхөн эдийн засаг талаасаа биш Монгол Улсын шинжлэх ухааныг нэлээн хол алхуулах төсөл гэж бид харж байгаа.

Олборлолт дээрээ ч бид шинжлэх ухааныг мэдэрнэ. Хийнгээ суралцана, хийнгээ бүтээнэ гэдэг бол яг энэ ураны төслөөс гарч ирэх юм. Хог хаягдал дээрээ ч гэсэн бид шинжлэх ухааныг бий болгож чадна. Одоо айдас хүйдэс байгаа. Яагаад гэвэл мэддэггүй, чаддаггүй, суралцаагүй, шинжлэх ухааныг ашиглаж чаддаггүй, хийж чаддаггүй учраас бид айж байгаа.

Энэ төсөл хэрэгжээд зөвхөн тээвэр дээр гэхэд шинжлэх ухаан их өндөр түвшинд яригдаж эхэлнэ, өндөр түвшинд ойлгодог болж эхэлнэ. Олборлолтоос гадна. Хог хаягдал дээр шинжлэх ухаан үнэхээр Монгол өөртөө итгэлтэй болж эхэлнэ. Байгаль орчин дээр Монгол өөрөө итгэлтэй болж эхэлнэ. Шинжлэх ухааныг мэддэг болно. Тэнд ажилладаг хүмүүстэй болно. Тэнд лабораторитой болно.

Тийм учраас уул уурхайн төслийн хүрээнд жишээлбэл төслүүд өөрөө нэг нь нөгөөтэйгөө амь нэгтэйгээр холбогдож явдаг шүү гэдгийг л хэлэх гэж байгаа юм.

Нөгөө талдаа бид уул уурхайгаар дэлхийд тэргүүлдэг улс болъё гэвэл хамгийн чухал ажлаа бид зарлаж байгаа. Тэр нь хил холболт. Яг хил холболт гэж юу юм бэ гэхээр маш өндөр хэмжээний хүчин чадалтай терминалууд байгуулахыг хэлж байгаа юм. Өнөөдөр хүртэл нэг буруу ойлголт явж ирсэн нь нарийн царигтай

төмөр зам, өргөн царигтай төмөр зам хоёрыг хооронд нь хэрхэн гагнах тухай хүмүүс бодож байсан.

Харамсалтай нь энэ биш. Бид өнөөдөр юуг тэмүүлж байна вэ гэхээр Тяньжиний терминал шиг тийм 4-өөс 5 боомтын тухай ярьж байгаа.

- Гашуунсухайт,
- Ханги-Мандал,
- Шивээхүрэн,
- Бичигт,
- Замын-Үүд,
- Цагаандэл-Уул.

Бид Тяньжин шиг 4-өөс 5 боомттой болчих юм бол Монгол Улсын уул уурхайн өрсөлдөх чадвар эрс нэмэгдэнэ. Яг далайд гарцтай орон шиг бид экспортлогч улс болж чадна.

Тийм учраас энэ Засгийн газар бол энэ дээр амь тавьж байгаа. Бид яг одоо хил холболтыг хийх гээд зорьж байхад манай засгийг унах тухай ярьж эхэлж байгаа. Эсэргүүцэгчид гарч ирж байгаа юм. Турхирагчид гарч ирж байгаа юм.

Энэ хил холболт нь хийгдчих вий дээ гэж чичирч байна шүү дээ.

Та бүхэн сошиал дээр байнга харж байгаа. Хэнийг нь буруутгах вэ, хэнийг нь ажилгүйгээр нь цоллох вэ, хэнийг нь архичин, түүлэгчнээр нь цоллох вэ гээд.

Ер нь энэ Засгийн газар, энэ Их Хурал парламентын засаглалаа хамгаалж гарахын тулд энэ хил холболтыг заавал хийх хэрэгтэй. Ингэх юм бол Монгол орон ирээдүйдээ айхаа болино. Монгол Улс баталгаатай тусгаар тогтносон улс орон болно. Ингэх юм бол айдас хүйдэсгүй гэрэл гэгээтэй ирээдүйн тухай бид маш зөв хардаг, маш зөв төлөвлөдөг болох юм.

Тийм учраас эрхэм гишүүдэд одоо би бид бол одоо мега төсөл яриад хил холболт, тэр олон терминалын тухай ярихаар “за яах вэ дээ, болно биз дээ” л гэдэг. Харамсалтай нь 30 жилийн хугацаанд бид хийж чадаагүй гэдгийг гишүүд маань үргэлж бодож байгаарай. Харамсалтай нь бид нараар хийлгээгүй гэдгийг үргэлж бодмоор байна.

Тийм учраас бид нараас асар их тэвчээр хэрэгтэй. Асар их эр зориг хэрэгтэй. Асар хурдтай байдал, асар ажил хэрэгч байдал хаа хаанаа чухал байна гэдгийг одоо Та бүхэндээ хэлье. Энэ бол одоо Монголын эдийн засгийн болоод Монгол орны хөгжлийн хамгийн том бодлого. Бид 1, 2 тэрбум долларын нүүрс зарах тухай энд яриагүй байгаа.

Бид 4-өөс 5 том, терминал 4-өөс 5 том боомт байгуулж зах зээл рүү гардаг, тэр зах зээлийг өөрийн болгох ийм л улс орны бодлогыг хэрэгжүүлэхийг зорьж байгаа гэдгийг хэлмээр байна.

Дараагийн асуудал мэдээж хэрэг гишүүн болгон хэлдэг, ард түмэн бүгдээрээ хэлдэг. Эдийн засгаа солонгоруулах асуудал.

Эдийн засгаа солонгоруулахын тулд бид нөгөө салбараа татаж унагах биш хөгжихгүй байгаа салбаруудыг хөгжүүлэхийн тулд хэрхэн уян хатан зөөлөн бодлого, нөгөө талдаа дэмжлэгийн бодлого хийх вэ гэдэг зүйл байгаа юм. Энэ дотор хамгийн чухал зүйл хөнгөн үйлдвэрлэл.

Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжихийн тулд бид жишээлбэл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас нь чөлөөлж байгаа юм. Цаашдаа яг үйлдвэрлэгчээ бид өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх бодлогын судалгаануудыг хийж байна. Бид юу үйлдвэрлэж чадаж байна, тэр хэдийгээ яаж дэмжих юм бэ, яаж өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх юм бэ.

Бид эдийн засгаа солонгоруулахын тулд том зах зээл олохын төлөө ажиллаж байгаа. Жишээлбэл, ЕвроАзийн зах зээл. ЕвроАзийн хэлэлцээрийг хийнэ. Ингэж байж бид маш том газар нутаг, маш олон хүн амтай зах зээлийг өөрийн зах зээл болгох ёстой. Энэ хэлэлцээрийг хийхэд өнөөдөр манай үйлдвэрлэгчид бэлэн биш байна гэдэг ийм сигналыг оны өмнө өгсөн.

Магадгүй энэ хэлэлцээрийг хийгээд Монголын үйлдвэрүүд гадна, дотнын хөрөнгө оруулалт татаад босоод ирэх вий гэдэг ийм болгоомжлол ч нөгөө талдаа байна.

Нөгөө талдаа түрүүн П.Сайнзориг гишүүний асуулт. Хэн гишүүн асуусан байв. Тэр монополын асуудал байгаа. Монополоо хадгалахын тулд том зах зээл рүү тэмүүлэх биш дотоодын 3 сая хүнтэй зах зээл дээр амь тавьж байгаа асуудал гарч ирж байгаа.

Өрсөлдөөнийг хүсдэггүй, өрсөлдөх чадалгүй, тэнхээгүй ийм хандлага сүүлийн жилүүдэд бий болсон тодорхой санхүүгийн болоод капиталын ноёрхол дундаас бий болж байгаа юм.

Тийм учраас өнөөдөр гишүүд монополын асуудлыг хөндсөн байх гэж би найдаж байна.

Тийм учраас эдийн засгаа солонгоруулах бодлогыг бид хөдөө аж ахуйн салбар, хөнгөн үйлдвэрлэлийн салбар, бусад үйлдвэрлэлийнхээ салбарууд дээр хэрэгжүүлэх бодлогыг баримтална.

Дээр нь бид авлигагүй орныг бий болгох ёстой. Ингэж байж эдийн засгийн эрх чөлөөнд хүрнэ. Ингэж байж эдийн засгийн орчин сайжирна гэсэн ийм дунд хугацааны бодлого байна.

Авлигын орчноо алга болгох, авлигагүй болохын тулд бид төрөө цомхон болгох, төрийн албаны шинэчлэл хийх, бүтээмжийн хувьсгал хийх, бүтээмжээ сайжруулах гэдэг ажлыг хийнэ.

Бид энэ долоо хоногт Засгийн газраас төрийн өмчит компаниудын ил тод байдлын тухай, шинэчлэлийн тухай асуудлыг засгийн хурлаар хэлэлцээд Их хуралдаа өргөн барина гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байна.

Ер нь төрийн өмчит компаниудын ил тод байдал дээр бид онцгой анхаарч байгаа. Дотоод хяналтыг эрс сайжруулж байгаа. Тэнд ямар ч эргэлзээ тээнэгэлзээгүйгээр, хулгай зэлгийгүйгээр явдаг тэр орчныг, тэр нээлттэй байдлыг бий болгохын төлөө бид чармайж ажиллана.

Тэнд тендерийн болоод бусад хулгай, мөн алдагдалтай байдаг төрийн өмчит компаниудыг хадгалдаг байдал, хэдэн хүнийг ажилтай байлгахын төлөө бөөцийлдөг байдлыг бүрэн халахын төлөө бид ажиллаж байгаа. Энэ бол бид нарын дунд хугацааны том бодлого болно гэж хэлмээр байна.

Тэгээд дунд хугацаандаа эдийн засгийн бие даасан байдлыг бий болгож авна. Ингэхийн тулд Монгол Улс хүн биш хууль засагладаг улс болно. Хууль засагладаг улс болно.

Дэлхий даяараа хүн засагладаг улс руу эргэж байна. Гишүүд ээ. Энэ бол аюул. Хүн засагладаг улс руу тэмүүлж байгаа тэмүүлэл болгон нь ар дээрээ уналт авчирна. Ар дээрээ заавал хувьсгал авчирна. Бид бол Монгол хүний саруул ухаан гаргаж хууль засагладаг улс руугаа тэмүүлэх хэрэгтэй. Энэ парламентын засаглалаа бэхжүүлэхийн төлөө зүтгэх ёстой. Энэ бол бид нарын хөгжлийн цорын ганц тод бодлого байна гэдэгт Эдийн засаг, хөгжлийн яам эргэлзэхгүй байгаа.

Энэ бол дунд хугацааны бодлогуудыг нэгтгээд хэлэх юм бол энэ дээрээ төвлөрч байгаа юм.

Мэдээж хэрэг хүмүүс ажилтай, өндөр цалинтай байхад ямар бодлого байх вэ гэдэг дээр бид хаврын чуулганаар

- ▶ Татварын бодлогоо оруулж ирнэ.
- ▶ Даатгалын бодлогоо оруулж ирнэ.
- ▶ Харилцааныхаа бодлогуудыг оруулж ирнэ.

Ингэж байж ажилтай хүнээ дэмждэг, ажил хийгээд өндөр цалин авч байгаа хүн бага торгодог, ажил хийхгүй байгаа энэ халамжийн бодлогоос татгалздаг, татгалзана. Дунд хугацаандаа татгалзахаас өөр арга байхгүй. Татгалзахгүй бол

энэ цөөхөн монголчууд мөнгө тараадаг ийм бодлогоор цаашаа явах юм бол улс орон дампуурна. Хэзээ ч босож ирэхгүй.

Тийм учраас хэдүүлээ ажилтай хүнээ дэмждэг бодлогыг одоо жишээлбэл манайх энэ дээр ингээд судалгаа хийж байгаа. Миний яриад байгаа энэ бодлого болгон дээр бид судалгаа хийж байгаа. Даалгавар өгөөд судалгаа гаргаад. Одоо үүнийг нээлттэй болгохын тулд бид тэр Үндэсний хөгжлийн хүрээлэнгээ байгуулж байгаа юм. Цахим архив болгоно. Нээлттэй эх сурвалж болгоно. Үүнийг төрийн бодлого болгоно.

Өнөөдөр хүртэл хийсэн судалгаа, шинжилгээ, олон улсын байгууллага, одоо баахан тусламжаар судалгаа хийлгэсэн материалууд нь олддоггүй. Байхгүй. Архивд ч байхгүй, яаман дээр ч байхгүй. Олддоггүй.

Тийм учраас бид Үндэсний хөгжлийн хүрээлэн Монгол Улсад хийж байгаа судалгаа, шинжилгээ, бүх датануудыг ил тод, нээлттэй хадгалдаг цахим архив бий болгохын төлөө бид зорьж ажиллая гэж байгаа юм.

Тэгэхгүй бол юм шүүгээд хардаг. Байдаггүй. Одоо жишээлбэл Монгол Улсын одоо бүр 1994 онд Монгол орны шинжлэх ухааныг хэрхэн өөрчлөх тухай олон улсын байгууллага ЮНЕСКО судалгаа хийгээд тайлан өгчихсөн. Харамсалтай нь тэр тайлан хаана ч байдаггүй. Нэг хуудас цаасыг нь ч ажил хэрэг болгоогүй. Бид.

Ийм байдалтай явж ирснийг засахын тулд энэ хүрээлэнгээ бид байгуулаад ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Тэгээд эцэст нь мэдээж “богино хугацааны бодлого” байгаа. Богино хугацааны бодлого бол 2025 оныг яах юм бэ. 2025 онд хэдүүлээ яг юу хийх вэ. Юу хийхэд бид бэлэн байна. Юуг хийж чадах юм гэдэг зүйл байгаа.

2025 оны сорилт бол засаг руу дайрсан, доромжилсон, Засгийг унах гэсэн оролдлого гаарна, галзуурна. Яагаад гэвэл авлигачид байж ядаж байгаа бүлэглэлүүд байж ядаж байгаа Монгол Улс хөгжих вий гэдэг айдас хүйдэс үнэхээр хүчтэй газар авч байгаа. Парламент нэг зүг рүү харж байгааг олж харсан тодорхой шуналын сэдэлтэй үйлдлүүд одоо үнэхээр хайчин гал шиг орж ирнэ.

Тийм учраас 2025 онд бид их итгэлтэйгээр урагшаа хараасай гэж би гишүүдээсээ хүсэж байгаа юм. Итгэл бидэнд хэрэгтэй.

Бид баталсан засгийн мөрийн хөтөлбөртөө итгэмээр байна. Энэ хөтөлбөрөө ажил хэрэг болгох тийм чин эрмэлзэлтэй баймаар байна.

Тэгээд 2025 онд бид нарын хамгийн чухал зүйл бол энэ улс орны аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын төлөө энэ 14 мега төслөө хэдүүлээ хийнэ ээ, хийе.

Өнөөдөр жишээлбэл

- Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцыг бид хөдөлгөж чадсан.
- Ураныхаа төслийг бид хөдөлгөж чадлаа.
- Хэрхэн терминалтай болох вэ,
- Хэрхэн хил холболттой болох вэ,
- Хэрхэн Хятадын зах зээл дээр бид нүүрсээ худалдах вэ

гэдэг ерөнхий зураглалаа гаргачихлаа.

Энэ хэлэлцээрийг бид ойрын үед багтаж хийх шаардлагатай.

Тэгэхийн тулд бидэнд “тогтвортой байдал” маш чухал юм. Маш чухал юм. Энэ тал дээр гишүүд хэл ам, бодол санаа, оюун ухаанаа цэгцэлж байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа.

“Үйлдвэрлэгч орон” болохын тулд энэ мега төслүүд явна. Ер нь зэс боловсруулах үйлдвэрийн төсөл бэлэн байгаа. Үүнийг энэ ондоо багтаагаад хөдөлгөнө.

Зүгээр хэдэн сая тонн хүдэр бий болгох вэ гэдэг асуудал байгаа.

- Эрдэнэтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломж юу байна вэ;
- Оюу Толгойг түшиглэсэн үйлдвэрлэлээ бид хэрхэн хийх вэ;
- Зэсийн шинэ төслийг ажилд хэрхэн оруулах вэ гэдэг сорилт байна.
- Хармагтайг оруулах хэрэгтэй.

Хэрхэн оруулах вэ.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Тэгээд дуусгачихъя.

Хамгийн чухал зүйл энэ жил бид бизнесийнхээ орчныг хэрхэн эрүүл болгох вэ гэдэг дээр бүх чиглэлээр судалгаа хийж байна. Бүх салбарт өвчин байна. Жишээлбэл, одоо бид энэ “Эрчим хүчний реформ” хийх гээд оролдож байхад Эрчим хүчний хууль дээр л лав 40, 50 заалтыг бид өөрчлөхөөс өөр арга алга.

Эрчим хүчийг үйлдвэрлэж байгаа хувийн хэвшлийг дарамталсан заалт 15-аас 20 байна. Хийх боломжгүй болгочихсон. Үйлдвэрлэлийг хөгжүүлэе гэх юм бол энэ байгаль хамгааллын хууль дээрээ бид маш тодорхой заалтуудыг өөрчлөхөөс өөр арга алга.

Өнөөдөр ТҮЦ байгуулъя ч гэсэн байгаль орчны ерөнхий үнэлгээ гэдэг юм хийж байна шүү дээ. Хэдүүлээ.

Надад Японы нэг том Нобелийн шагналтан хэлж байсан юм. Яг хөгжих гэж байтал нэг ангал үүсдэг юм. Тэр ангал нь аягүй гоё амьдрах гэсэн хүсэл дээр бий болдог юм гэж. Нэг их гоё амьдрал мөрөөддөг. Тэрийгээ давж гардаг стандарт, тэвчээр, капитал, хүний нөөц, зах зээл байдаггүй. Нөгөө гоё хүсэлдээ бүдрээд уначихдаг.

Тийм учраас жишээлбэл энэ Байгаль орчны хууль дээр бид асар их өөрчлөлт хийх юм билээ. Гэх мэтчилэн.

Би одоо сайдууддаа үүрэг өгчихсөн. Бүх салбарын хуулиа хар. Бизнес эрхэлж байгаа хүнд гай болж байгаа заалт болгоныг авч хаяя. Бүх гаргасан журмаа эргээд уншицгаа. Сайд нар бол ерөөсөө журмуудаа уншдаггүй шүү дээ. Урд талын сайд үйлдвэрлээд орхичихдог. Дараа нь тэр журмын дагуу л юм явж байдаг.

Бүх бизнесийнхэнд садаа болж байгаа журмуудаа урж хая гэдэг ийм чиглэл өгчихсөн. Ойрын үед яг энэ чиглэлээр энэ бизнесийн орчныг эрүүл болгох чиглэлээр бүх сайд нар засаг дээр тайлан тавина. Ингээд бид нэгтгээд бид бол өнөөдөр тусгай штаб гаргачихсан яаман дээр ажиллаж байгаа. Гаднын бас зөвлөхүүдийг авчихсан байгаа.

Тэгээд үнэхээр бизнесийн орчноо хэдүүлээ эрүүл болгоод бизнес эрхэлж байгаа хүнээ дарамталдаггүй, айдасгүй, хөндлөнгөөс оролцдоггүй. Зүгээр “тусалдаггүй юмаа гэхэд битгий гай бол” гэдэг энэ үгийг эхлээд хийчихье.

Тэгээд дараа нь туслах тухайгаа бодъё гэсэн ийм ойлголттой байна. Энэ хүрээнд Ерөнхий сайд чиглэл өгсөн. Татварын реформыг яг энэ бизнесийн орчин эрүүл болгохтойгоо зэрэгцүүлээд оруулж ир ээ гэдэг ийм чиглэл өгсөн байгаа.

Тийм учраас энэ дээрээ ажиллаж байна.

Тэгээд хамгийн гол нь бид нарын эдийн засаг өсөөд байдаг. Айлын хаалгаар ордоггүй гэдэг нэг ийм шүүмжлэл байгаа.

Тэгээд “айлын хаалга” гэж юу хэлээд байна вэ гэж судлаад байсан чинь хамгийн сүүлд юу байсан бэ гэхээр “утаа” байсан. Айл орон сайхан амьдрахгүй байгаа шалтгаан юу вэ гэсэн “түгжрэл” байсан. Айл орон сайхан амьдрахгүй байгаа шалтгаан юу вэ гэсэн чинь гэртээ “халуун усгүй” байсан. Цэвэр ус гэрээсээ авч болохгүй байгааг монгол айл болгон тэр авч чадахгүй байгаа хэсэг “манай гэрт Монголын хөгжил орж ирэхгүй байна” гэж хэлж байгаа юм.

Тийм учраас өнгөрсөн жилийн төсвийн тодотголоос эхлээд бид яагаад хэл амтай ч гэсэн урагшаа алхахыг хүссэн бэ гэвэл “Улаанбаатар хотыг мөнгөтэй болгоё” гэсэн.

Улаанбаатар хотод өнөөдөртөө бид бүх хүчээ өгье гэж байгаа юм. Өнгөрсөн жилийн тодотгол дээрээс эхлээд хотоос авдаг байсан дотацийг авахаа больсон.

2025 оны зөвхөн хотын төсөв 5.8 их наядад хүргэсэн. Энэ юу хэлж байгаа вэ гэхээр 2025 оныг бид Улаанбаатар хотын дэд бүтцийг дэмжих жил болгож байгаа юм. Үнэхээр хэдүүлээ 2027 он гэхэд утаагүй болно. Яг энэ төлөвлөлт өөрөө Монголын эдийн засаг “айлын хаалгаар орсон эдийн засаг” болох хамгийн чухал бодлого шүү. Гишүүд ээ.

Хамгийн чухал нь энэ.

- ▶ 2027 оны намар, өвлийг хэдүүлээ “утаагүй” давъя. Хугацаа өгье.
- ▶ 2028 оны өвөл хэдүүлээ түгжрэлгүй байя. Хугацаатай тохиръё, шийдье.

Энэ рүү бүх хөрөнгө, хүчээ хуримтлуулъя гэдэг зүйл бидний богино хугацааны бодлого. Би одоо хоёр хугацаа хэллээ шүү.

- ▶ 2027 оны өвлийг “утаагүй угтъя”.
- ▶ 2028 оны өвлийг “түгжрэлгүй угтъя”.

Энэ хоёр хугацааны төлөө бид жишээлбэл:

- ▶ Туулын хурдны замыг 2 жилийн дотор ашиглалтад оруулах ёстой.
- ▶ Хотын их тойргийг 2 жилийн дотор ашиглалтад оруулах ёстой.
- ▶ Хотын дулааны чадлыг бид 5 дахин нэмэх хэрэгтэй.
- ▶ 7-гоос 8 нь бие даасан дулааны станцыг байгуулах учиртай.
- ▶ 2, 3 шинэ цэвэрлэх байгууламжийг хэдүүлээ хийнэ.

Нэгдсэн дулааны чадамжийг бид “II цахилгаан станц” гэж байгаа. Үүний суурин дээр хэдүүлээ 300 мегаваттын дулааны станцаа барина. Барья.

- ▶ Амгалангийн дулааны станцын хүчин чадлыг дахиад нэмэгдүүлье.
- ▶ Дамбадаржаад баригдсан шинэ дэд төвөө хэдүүлээ дахиад нэмэгдүүлье.

Ийм төлөвлөлтийг хэдүүлээ хийж байгаа. Орон сууцжуулъя.

Яагаад ийм дэд бүтэц бариад байгаа юм бэ, яагаад зам тавиад байгаа юм бэ гэвэл орон сууцтай л болох ёстой. Орон сууц гэж яг юу юм бэ гэвэл цэвэр ус, дулаан, бохир. Энэ 3 шугам байна уу. Дээр нь эрчим хүчний эх үүсвэр байна уу гэдэг л асуудал.

Тэгээд гишүүд маань бүгд мэдэж байгаа. Энэ олон жилийн гол алдаа бол дэд бүтцээ хийгээгүй. Тийм учраас газар олддоггүй ээ. Хотын төв рүү шавцгаасан. 500 төгрөгийн үнэтэй хямд дулаан ашигласан. Одоо хэдүүлээ дулаанаа мянган төгрөг болгосон. Эрчим хүчний үнэ нэмэгдсэн. Үүнийг дагаад хэрэглээ багассан. Үр ашиггүй хэрэглээгээ танаж сурцгааж байна.

Тийм учраас хэдүүлээ ерөөсөө 2 тоог л тохиръё гэж байгаа юм. 2027 онд утаагүй өвлийг угтъя. 2028 онд түгжрэлгүй Улаанбаатарыг харцгаая. Зорчдог больё гэж.

Энэ хугацаанд юу хийх юм бэ гэж. Энэ хугацаанд түүнд хүрэх бүх ажлыг хийнэ. Хэдүүлээ 200 мянган айлын орон сууцыг төлөвлөж ажил хэрэг болгоно. Саяын миний хэлдэг дэд төвүүдийг ашиглалтад оруулна. Магадгүй дунд хугацаандаа Улаанбаатар хотын ундны усны асуудлын эх үүсвэрийг дээд хэсэгтээ шийднэ гэсэн ийм төлөвлөлтийг хэдүүлээ хийнэ.

Мөн бүсчилсэн хөгжлийн үзэл санааг бид бодит ажлын төлөвлөгөө болгох нь 2025 он юм. 2025 онд багтаагаад бүх нөөцийн судалгаа гарна.

- Био нөөц,
- Хүний нөөц,
- Баялгийн нөөц,
- Газар нутгийн нөөц,
- Гадаад харилцааны нөөц

гээд энэ бүх нөөцүүд гарна.

Ингэснээр бид аль бүсдээ ямар бодлого явах вэ гэдэг маш тодорхой гарна.

Зүүн бүсэд би баталгаатай хэлэх юм бол зүүн босоо тэнхлэгийг 2028 он гэхэд бид хийж дуусгана. Зүүн босоо тэнхлэгийг. Бид Буйр нуурыг аялал жуулчлалын бүс болгоод хөгжүүлчихсэн байна гэх мэтчилэн бидэнд төлөвлөөд хийж байгаа ажлууд байна шүү. Гишүүд ээ.

Тэгээд 2025 оны гол зорилго бол эдийн засгийн өсөлтийг бий болгох ёстой. 8 хувь. Энэ рүү зоригтой зүтгэнэ. Ингэхийн тулд Хөрөнгө оруулалтын хуулиа хэдүүлээ хаврын чуулганаар батална. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль бэлэн болчихсон байгаа.

Би ер нь Эдийн засгийн байнгын хороогоо яаман дээрээ урьж байгаа. Тийм ээ, Р.Сэддорж дарга аа. Урьж байгаа.

Та бүхэн ирэх долоо хоногтоо багтаад очоорой. 3 зүйл яримаар байна.

Нэгдүгээрт, Чөлөөт худалдааны хэлэлцээрийг Та бүхэн маань сонсоод саналаа өгмөөр байна.

Хоёрдугаарт, Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг бид боловсруулсан түвшиндээ нэг танилцуулчихъя гэж бодож байна. Энэ дээр Та бүхэн санаа оноогоо хэлмээр байна.

Гуравдугаарт, одоо бид нарын энэ асуулга дээр байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль хэрхэн өөрчилж болох тухай Та бүхэнтэй ярилцмаар байна.

Гишүүдийн надаас нэхэж байгаа зүйл хурдтайгаар хувийн хэвшлийн хувийн хөрөнгө оруулалтыг нийтийн дэд бүтэц рүү дайчлах тэр орчныг хурдтай хийхэд зориулаач ээ гэж. Бид цаг алдаад байна.

Үнэхээр харамсаж байгаа зүйл жишээлбэл П.Сайнзориг даргыг хотод байхад Туулын хурдны замыг концессоор хийж болох байсан. Цаг алдсаар байгаад одоо хурдан хийхийн тулд хот өөрийнхөө төсвөөр хийх гэж байна. Нэг аравны хэдэн их наяд төгрөг.

С.Бямбацогт сайдыг сайд байхад 6 компани төр, хувийн хэвслээр хийе гээд саналаа өгчихсөн байгаа. Саналаа өгчихсөн байгаа. Тийм.

Тийм учраас энэ хууль дээрээ хэдүүлээ санал гаргана. Тэгээд Та бүхэнд үүнийг хүргэмээр байна.

Дараагийн “богино хугацааны зорилт” бол ногоон хөгжлийнхөө зорилтыг хэдүүлээ их тодорхой болгож хуулийг нь баталъя. Ногоон хөгжлийн тухай тодорхой хуультай баймаар юм билээ. Ялангуяа тэр карбон дээр. Сингапуртай хийх хэлэлцээр бэлэн болчихсон. Хуульгүй учраас заавал Их Хурлаар оруулах шаардлагатай болж байгаа юм.

Тийм учраас Ногоон хөгжлийнхөө хуулийг хэдүүлээ ярьж байгаад хаврын чуулганаар өргөн бариад ногоон эдийн засаг гэдэг утгаар нь карбоныг мөнгөжүүлэх.

Бид үнэхээр энэ их том газар нутгийг карбоны зах зээл гэж хараад хөдөлж чадах юм бол манай бэлчээрийн мал аж ахуй цаашаага алхах том хөшүүрэг болох боломж байна. Ингэснээр бид үнэхээр арьсыг бүрэн бүтэн хүлээж авах боломж байна. Малын махыг бид экспортлох боломжийг бид яг энэ хуулийнхаа хүрээнд гаргаж ирэх боломж бас харагдаж байна гэсэн ийм зүйлсийг төлөвлөж байгаа.

Тэгээд 14 мега төсөл дээр би Та бүхэнд. Та бүхэн бараг бүгд мэдэж байгаа даа. Аль төсөл нь ямар хэмжээтэй явааг. Би Та бүхэнд.

149 төсөл байгаа. Яг энэ 149 төслийг бид 4 жилийн хугацаанд бүгдийг нь ажил хэрэг болгоно. Энд Их Хурлын гишүүд битгий эргэлзээрэй.

Энэ 149 бүгд ажил болно. 160 гаруй их наяд төгрөгийн тооцоо гарч байгаа. Тэгэхдээ энэ бүгд хувийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн бие даасан шийдэл гээд бүгд шийдэлтэй.

Харамсалтай нь улс төржсөөр байгаад цаг хугацаа алдчихсан ийм зүйлс байгаа учраас энэ дээр бид эргэлзэхгүйгээр ажил хэрэг болгоно. Ямар ч хувийн сонирхол оруулахгүйгээр энэ төслүүдийг бүгдийг нь хөдөлгөнө гэсэн ийм л төлөвлөлтийг хийж байна.

Нэгдүгээрт, 14 мега төслийн эхнийх нь хил холболт байгаа. Үүний эхний шийдлийг Их Хурал маань гаргасан. Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлж байгаа. Үүнийг хэдүүлээ ажил хэрэг болгоно. Энэ бол богино хугацаанд болчихно. Харж байгаа.

Эрээнцав-Бичигтийн төмөр замыг барих ажил байгаа. Бидэнд авто замыг нь бол бүрэн барих концепц, чиглэл, саналууд ирчихсэн байгаа. Яг авто замыг нь оруулчихна. Төмөр замыг нь одоо хэрхэн хийх вэ гэдэг дээр бид төлөвлөлтөө хийгээд явж байна. ТЭЗҮ нь хийгдчихсэн төсөл.

Гол нь Чойбалсангаас хойшоо явж байгаа төмөр замаа яах вэ, төмөр зам маань хэний мэдэлд байх вэ, Монголын төмөр зам дээрээ байх уу, хөрөнгө оруулагчид нь ямархуу эрх мэдэлтэй байх вэ гээд.

Төмөр замын суурь бүтэц бол улсын мэдэлд байна гэдэг нэг ийм харилцаа байгаад байгаа.

Тэгээд үүнийг хэрхэн давах вэ гэдгээс хамаараад төмөр замынх нь төсөл ажил хэрэг болоод явах юм.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцаа шийдчихсэн.

Тавантолгой бол хоёр компани маргалдсаар байгаад хугацаа алдчихсан. 2 жил алдсан. Одоо манай гишүүдийн хэлээд байгаа энэ Төр худалдан авалтын хуулиа өөрчлөөч ээ гэдэг. Энэ саналыг ялгаа байхгүй энэ чуулганы төгсгөл дээр Сангийн яам өргөн барина.

Тэр үед Та бүхэн маань хэлэлцэж дэмжиж өгөөрэй. Хардах сэвтэх зүйлгүй, ил тод, шуурхай хурдтай ажил хэрэг болдог тийм худалдан авалтын хуультай болъё гэж байгаа юм.

Ингэх юм бол жишээлбэл энэ Тавантолгойн цахилгаан станц ажил хэрэг болоод явчихна.

Газрын тос боловсруулах үйлдвэр дээр нэмэлт 400 гаруй сая долларын санхүүжилтийг Энэтхэгийн Засгийн газар олгох шийдвэрээ өгчихсөн. Удахгүй үүнийгээ бид яг хэлбэрт оруулаад ингээд Их Хуралтайгаа зөвшилцөх ажлыг эхлүүлнэ. Ингэх юм бол газрын тосныхоо үйлдвэрийг бид хугацаанд нь ашиглалтад оруулах боломж байгаа.

Ураныхаа төслийг хэрэгжүүлчихсэн. Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн тухайд бол нэг засгийн тогтоол, мөн одоо Эрчим хүчний хууль гэсэн энэ юман дээр нэг жижиг өөрчлөлт ороод ер нь энэ тархмалуудын чөлөөт байдлыг бид хангаж өгөх юм билээ. Тархмалыг дээрээс зохицуулдаг байдал бол арын хаалга салгахгүй байна. Зөвшөөрөл авдаг. Нэг цементийн үйлдвэр барьчхаад тэрийгээ эрчим хүчээр хангах гэхээр хэн нэгнээс зөвшөөрөл авдаг. Хэн нэгэнтэй үнэ ярих хэрэгтэй болдог.

Нэг хөгийн жишээ байна шүү дээ. Эрдэнэт үйлдвэр өөрөө цахилгаан станц барьчихсан. Түүнийхээ тогийг өөрийнхөө үйлдвэрт ашиглах эрх байхгүй. Төвийн шугамд хямдаар нийлүүлээд, өөрөө төвийн шугамаас үнэтэй эрчим хүч худалдаж авч байгаа. Манай улсын үйлдвэр шүү дээ. Улсын баатар үйлдвэр маань ийм байдалтай хуулийн орчинд амьдарч байна.

Тийм учраас үүнийг хэдүүлээ шийдээд явчихад энэ хөрөнгө оруулалт бол.

Сая Ерөнхий сайд Арабын орнуудад айлчлал хийхэд ер нь энэ сэргээгдэх эрчим хүчин дээр хийх хөрөнгө оруулалт их тодорхой юм билээ. Хөрөнгө оруулагч нар ч их тодорхой юм билээ.

Бид хамгийн гол нь Хятадын Засгийн газартай хийх хэлэлцээр дээр “эрчим хүч экспортлох” гэдэг энэ зүйлийг нэлээн тодорхой болгож чадах юм бол Монголын тал нутаг сэргээгдэх эрчим хүчний маш их нөөцтэй. Энэ нөөцийг бүрэн дүүрэн ашиглах боломжууд бидэнд гарна. Үүнийг хийчихнэ.

Дараагийн асуудал. Энэ кокс, химийн цогцолбор байгаа юм. Энэ бол ажил хэрэг болоод явж байгаа.

Нүүрс, химийн цогцолбороо бид Багануур дүүрэгт энэ хавараас эхлээд барьж байгуулах ажлыг эхлүүлнэ, хийнэ. Нүүрс, химийн цогцолбор орж байж Монгол Улс үнэхээр химийн үйлдвэрлэл талдаа алхсан, шинжлэх ухаанаа харуулсан ийм том алхам болж чадна гэдгийг хэлмээр байна.

Зэс боловсруулах үйлдвэр. Би түрүүн хэлсэн. Энэ бол бэлэн байгаа. Одоо үүнийг шууд ажилд нь оруулна, явуулна.

Гангийн цогцолбор дээр судалгаанууд хийгдсэн. Одоо би түрүүн Та бүхэнд харуулж байгаа нь. Жишээлбэл, арьс шир, ноос, ноолуурын өрсөлдөх чадварын судалгаа манай яам сая захиалга өгөөд хийлгэчихсэн. Яг үүнтэй зэрэгцүүлээд зэс гээд хийчихсэн. Одоо үүнтэй зэрэгцүүлээд металл дээр хийсэн.

Тэгээд гангийн үйлдвэр дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийе гээд яг энэ ган үйлдвэрлэгч нар саналаа ирүүлээд байгаа.

Тэгээд энэ дээр манай дээр тодорхой ажлын хэсэг гараад ажиллаж байна. Энэ ажлыг бид ондоо багтаагаад ер нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр явахаар байна гэдгийг хэлмээр байна.

Мөн “Орхон-Онги” гэдэг том төсөл байна. Үүнийг бид бас хэл холболттойгоо уяж. Нөгөө талдаа нүүрсний солилцоогоор ярилцлага хийж цаашаа явж байна. Гэх мэтчилэн 14 төсөл дээр эргэлзэх зүйлгүй.

Энэ дээр эргэлзээтэй нь мэдээж Эгийн голын цахилгаан станц л байгаа. Мөн үндэсний хиймэл дагуултай болох гэдэг энэ хоёр зүйл байгаа юм. Энэ хоёрыг хэрхэн ажил болгох вэ.

Ер нь үндэсний хиймэл дагуул гэдэг бол өртөг нь өндөр сонсогдож байгаа боловч Монгол Улсын яг үндэсний аюулгүй байдлаа харах юм бол мэдээллийн технологи талаасаа бие даах, бие даан амьдрах. Одоо бид нарын хүсээд байдаг бизнесүүд улс төргүй юм байна гээд байсан чинь одоо бизнест улс төр давхиад орчихсон шүү дээ. Дэлхийн томчуул.

Тийм учраас одоо бид хараат бус болох гэдэг бол бидний хувьд асар чухал болж эхэлж байгаа. Бид мэдээллийн аюулгүй байдал, мэдээлэл, дамжуулах систем. Энэ зүйлээрээ аль нэг улс орон, аль нэг компанийн эрхшээлд ерөөсөө орж болохгүй.

Одоо үндсэндээ хоёр хөрш маань манай мэдээллийн урсгалыг зогсооё гэх юм бол бүрэн эрхтэй. Хийчихнэ. Бид тэгээд мэдээллийн урсгалгүй болохоор байгаа.

Тийм учраас энэ бол үндэсний мөрөөдөл шүү. Зүгээр ямар төсвөөр ямар хэмжээтэйг яаж хийх вэ гэдгээ хэдүүлээ эргээд ярина уу гэхээс биш огт хиймэл дагуулгүй ингээд нэг ядуу орон байя гэдгээс энэ зорилго бол буруу.

Аюулгүй байдлыг хэдээр үнэлэх гэж байгаа юм. Тусгаар тогтнолыг ямар үнэ, мөнгөөр үнэлэх вэ гэдэг асуудал байгаа юм.

Гол нь технологи талдаа үнэхээр орчин үеийн, бие даасан, өөрсдөө удирдаж чадахуйц тийм хиймэл дагуултай хэдүүлээ болно.

Эгийн голын усан цахилгаан станц дээр суурь судалгаанууд хийгдэж байгаа шүү. Гишүүд ээ. Их нааштай байгаа. Бид үүнийг яаж ийгээд байгуулах тал дээр ажиллаж байна. Зүгээр эргэлзээтэй гэж байгаа нь тэр. Бусад нь ажил хэрэг болоод явна.

Нөгөө 149 төсөл гээд байгаа. Одоо энэ миний гарт байна. Энэ 149 төсөл бүгд ажил хэрэг болно. Энэ дотор бүр эргэлзээтэй 4, 5 л арга хэмжээ байгаа. Бүр эргэлзээтэй. Бусад нь ажил хэрэг болно. 2025 онд үүнээс хэдэн хувийг нь

урагшлуулах вэ гэдгийг би та бүхэнд одоо энэ чуулганы завсарлагаанаар төсөл нэг бүрээр нь танилцуулъя гэсэн ийм бодолтой байна.

Яагаад гэвэл бид үүнийг 4 жилийн дараа сонгогчдодоо очиж тайлагнах ажил бол энэ байгаа. Бүх улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр. Дээр нь Та бүхний сонгуульд амласан амлалт. Мөн Их Хурлаар баталсан хамгийн том баримт бичиг. Үүнийг ажил хэрэг болгох үүрэг нь Засгийн газарт байгаа. Үүнийг л бид Та бүхэнд тайлагнах учиртай.

Би итгэлтэйгээр хэлэх нь бол эндээс алсрагдах, алдагдах, хаягдах төсөл бол байхгүй. Бүгд гаргалгаатай. Гаргалгаатай учраас Засгийн газар ч оруулж ирсэн юм билээ. Гаргалгаатай учраас гишүүд ч гэсэн санал гаргасан юм билээ. Тэгээд баталсан юм билээ.

Тэгэхээр энэ дээрээ битгий эргэлзээрэй гэж хүсэж байна.

Тэгээд анхаарал тавьсанд баярлалаа.

Нарийн ширийн мэдээлэл байвал манай газрын дарга нар ирчихсэн байгаа.

Дараагийнх нь тэр Хөрөнгө оруулалтын хуулиа хэлсэн. Ер нь боловсруулаад манай Т.Доржханд сайд удирдаад зохион байгуулаад нэлээн урагшаа явчихсан хууль.

Манай дээр бас ажлын хэсэг гараад ажиллачихсан. Тэгээд эцэслээд Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын хурлаар ойрын үед оруулна. Ингээд Их Хуралдаа өргөн барина.

Тэгээд түүнээс өмнө Та бүхнээс зүгээр санал сонсох маягаар уулзалт хийе гэж бодож байгаа. Өнөөдөр дэлгэрэнгүй ярих боломж бага байна. Хуулийг өргөн барихаас өмнө хамаагүй ярьдаггүй. Олон нийтийн хэлэлцүүлэг рүү орохоос өмнө Та бүхэнтэй санал бодлоо хуваалцана гэсэн бодолтой байна.

Эцсийн асуулга бол төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрхэн явуулах вэ гэдэг асуудал байгаа. Мөн хуулийн ганц нэг нэмэлтүүдийн тухай бид хийж байна, судалгаанууд хийж байна, хуучин хуультай нь харьцуулж үзэж байна.

Хамгийн гол нь сайн хууль. Ганц зүйл. Хэрэгжихэд жоохон цаг алддаг юм байна. Амьдралаас жоохон тасархай юм байна. Яг төсвийн хууль шигээ хийчихсэн юм байна. Сангийн яам тийм сэтгэл зүйгээр хандсан байна гэдэг нэг ийм жижиг жижиг доголдлууд бол байна. Ний нуугүй хэлэхэд.

Тэгээд үүнийг засаж янзлаад бид Та бүхний саналыг авч байгаад, ялангуяа тэр Замын сайд, Барилгын сайд гээд, хотын хотын удирдлагууд гээд яг энэ ахуй дээр ноцолддог хүмүүсээс санал авахаар арай өөр юм харагдаад байна.

Тийм учраас яг тэр ахуйтай, хөрөнгө оруулагч нартай ярилцаж байгаад ганц нэг заалтыг өөрчлөөд өргөн барих асуудлыг хийнэ. Байгууллагаа бид байгуулчихсан. Өнөөдөр яг ажилдаа ороод явж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв маань. Яамдаас санал авах, аль ажлыг энэ жил концессоор хийх вэ гэдэг, түншлэлээр хийх вэ гэдэг саналыг яамдуудаас санал авахаар ингээд саналаа авч байна.

Мөн өөрөө өөрийгөө тэжээж чаддаг аймгууд маань төр, хувийн хэвшлийн түншлэлийг хийх эрхтэй болчихсон. Энэ аймаг буюу хотоос саналууд авч байна.

Тэгээд тэр газрууд маань тэндээ бас хэрэгжүүлнэ. Төв маань тодорхой төслүүдийн менежмент, газрын зураглал, мөн төслийн санхүүжилтийнх нь хэлбэр гэдэг хөрөнгө оруулалтынх нь нөхцөл байдлын судалгаануудыг хийж байна.

Тэгээд бид хавартаа багтаагаад авто замын 2-оос 3 төслийг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна. Ингээд цаашаага алхана гэсэн ийм ойлголттой байгаа.

Анхаарал тавьсан гишүүддээ баярлалаа.

Жоохон сунжруу ярьсан бол уучлаарай.

Р.Сэддорж: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Зандангийн Баярхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Лхагвадоржийн Бат-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын Төслийн нэгдсэн удирдлага, мониторингийн хэлтсийн дарга, Баяраагийн Урьболд Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн, Галсангийн Дэнзэн Эдийн засаг, хөгжлийн яамны Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал, Содномсамбуугийн Дэмбэрэл Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, Монхоогийн Амгаланбаатар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн захирал, Г.Элбэгсайхан Оюуны өмчийн газрын дарга.

Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Н.Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа. П.Батчимэг гишүүн, М.Мандхай гишүүнийг нэмье.

Ингээд П.Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Мэдээлэл өгсөнд баярлалаа.

Тэгээд маш олон зүйлийг яримаар байна. Тэгэхдээ цаг хязгаартай учраас товчхон хэдэн зүйлийг асууя.

Ер нь хөрөнгө оруулалтыг татах, өмчийн баталгаа болгон хүний эрхийн бүртгэл байдаг юм. Гэтэл өнөөдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар дээр төрийн албаны туршлагагүй хүн газрын дарга хийгээд байгууллагынх нь даргын үүрэг гүйцэтгэл хийж байгаад байгууллагуудын мэдээллийг өөрчлөөд дарга, цэргийг нь өөрчилж байна.

Үүнээсээ эхлээд Тэргүүн Шадар сайд та Засгийн газар дээр ярьж, хэлэлцэж, анхаараач ээ.

Энэ өмчийг хэзээ ч булааж мэдэхээр болчихлоо шүү дээ. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг боловч энэ чинь цаанаа Монгол Улсад орж ирж байгаа хөрөнгө оруулагч өмчийн бүртгэлийн асуудлыг бүртгэж байдаг. Тэнд байгаа төрийн бус байгууллага сая нэг гарч байх шиг байна.

Зүгээр л мэдээллийг нь хувийн зорилгоор өөрчлөөд дарга, цэргийг нь сольчихож байна шүү дээ. Тэр үүрэг гүйцэтгэж байгаа хүн. Ийм байхад Монгол Улсад хөрөнгө оруулагч орж ирэхгүй. Үүнээсээ эхлээд Засгийн газар хариуцлагатай баймаар байна. Тэр сайдад нь энэ зүйлийг нь анхааруул. Яагаад улс төрийн өөрийнх нь зөвлөх хийж байсан хүн өнөөдөр тэнд оччихсон самраад хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах тийм үйлдлүүд, том мессежүүдийг хийгээд байгаа юм бэ. Үүнийг одоо яримаар байна.

Би тэгээд хэдэн саналыг ярья. Би энэ саналыг маш олон газар тавьж хэлсэн боловч бас дэмжигдэхгүй байгаа юм.

Ер нь Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр Монгол Улс төлөөлөгчдийн тоог нэммээр байна.

Түүнээс биш Швейцарь дахь Элчин сайдын яам давхар энэ үүргийг гүйцэтгэж ерөөсөө болохгүй. Өнөөдөр Дэлхийн оюуны өмчийн байгууллага Ази, Номхон далайн бүсийг хариуцах бололцоотой байж байхад бид хэд энэ дээрээ хөрөнгө мөнгөнөөсөө татгалзсаар байгаад одоо асуудал үүсэж байгаа байхгүй юу.

Тэнд Дэлхийн худалдааны байгууллага дээр явж байгаа маргаануудыг сонсоход бид энэ дээрээс яаж урьдчилан сэргийлж чадах вэ, ямар давуу талыг олж чадах вэ гээд ядаж мэдээллийг аваад байж байх ёстой байгаа юм.

Оюуны өмчийн асуудал гэдэг бол цаана нь патент болон бүх салбарын шинжлэх ухааны ололтыг бид мэдэж байна гэсэн үг. Энэ дээр хүртэл лобби хийж чадахгүй бид ерөөсөө гол салбарууд дээр ерөөсөө ач холбогдол өгч чадахгүй байна.

Энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам одоо таны салбар дээр ирсэн учраас энэ Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр бүр нэг томоохон төсөв мөнгийг нь тавиад бүрэлдэхүүн энэ тэрээ явуулдаг баймаар байна. Эндээс мэдээллүүд авдаг баймаар байна.

Дэлхийн худалдааны горим, дэг журам яаж явах гээд байгаа нь мэддэг баймаар байна. Ямар ямар шинжлэх ухааны ололтууд бүртгэгдээд үүнээсээ ашиглалтаасаа бид хямд өртгөөр. Наад захын эмийн бөөний худалдааг Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээрээс бид авч чадах байхгүй юу. Эмийн патентыг бүртгүүлэхэд л. Ерөөсөө авч чадахгүй байна.

Тэгэхээр ийм зүйлүүд дээр анхаараач ээ гэдэг зүйлийг хэлж байна.

Сая төсөв батлагдахад “ногоон эрчим хүч”, “ногоо эдийн засаг”-ийг дэмжих хуулийг оруулж ирээрэй гэсэн. Та оруулж ирнэ гэж байгаад баяртай байна. Үүнийг яаралтай хиймээр байна.

Хоёрдугаарт, энэ асуудлыг би зөвхөн манай хүнс, хөдөө аж ахуйн салбарт хүртэл нөлөөлөхөөр болчхож байгаа юм. Өнөөдөр дэлхийн томоохон хувцасны брэнд.../минут дуусав/

Р.Сэддорж: Асуулт. Дараа нь асуух уу? Тийм ээ. Хариулт. Хэдэн номер вэ? 6 номер. Өөрийгөө танилцуулаад.

Г.Элбэгсайхан: Та бүхэнд энэ оройн мэндийг дэвшүүлье. Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан байна.

П.Сайнзориг гишүүний хэлсэн саналыг хүлээж авлаа.

Сүүлийн хоёр, гурван жил бид Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Сангийн яаманд энэ асуудлыг уламжилж байсан боловчиг энэ төсөвтэй холбоотой, хэмнэлтийн хуультай холбоотойгоор манай төсөв бол Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр суурин төлөөлөгч суулгах асуудал жил болгон хасагдаж ирсэн. Тийм. Иймэрхүү байдалтай байгаа. Яг энэ асуудал дээр.

Бусад мэдээлэл авах, Дэлхийн оюуны өмчийн байгууллагын мэдээллүүдийг бид бүгдийг нь 2022 онд Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай хамтын

ажиллагааны гэрээгээ шинэчлэн байгуулаад бүх мэдээллийг цахимаар манай байгууллагын веб сайтаар дамжуулан ил тод байлгаж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: П.Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Товчхон саналууд хэлье.

Тэгээд ер нь ноос, ноолуурыг жишээ нь дэлхийн томоохон брэндүүд худалдаж авахад яаж энэ хүлэмжийн хийг бууруулсан юм бэ гэдэг шаардлагыг тавьдаг болчихсон. Манай хөдөө аж ахуйн салбар өрсөлдөхөд маш хүнд болж байгаа.

Тэгэхээр энэ ногоон эдийн засгийг дэмжих хуулийг яаралтай оруулж ирж үүнийг бодлогоор дэмжиж өгөхгүй бол энэ ноос, ноолуурууд чинь ч гэсэн дэлхийн зах зээл дээр гаргаад хүнд болсон шүү.

Тэгээд ямар сайндаа хэдэн ноос, ноолуур бэлтгэж байгаа компаниуд чинь дээрээ нэг сэргээгдэх эрчим хүчний хэдэн панелийг тавьж үзүүлж харуулаад л явж байх жишээтэй л байна.

Энэ тендерийн хуулиа оруулж ирмээр байна. Open tender-ээр энэ томоохон төслүүд явахгүй. Сая нийслэл анх удаа хоёр шатлалтай тендер хийж үзүүлээ.

Ер нь restricted tendering буюу энэ чаддагуудыг нь урьж оролцуулж байж лист үүсгэж байж энэ томоохон худалдан авалт явуулах юмнуудаа явмаар байна.

Хоёрдугаарт, бодлогын хүрээнд ер нь хөрөнгө оруулалтыг хамгийн их гацааж байгаа юм манай хууль зүйн салбар байгаа. Тэр дундаа шүүх эрх мэдэл. Арилжааны шүүхтэй болох асуудал дээр манай мэргэжлийн яам юу гэж бодож байгаа вэ? Газрын багц хууль хэзээ орж ирэх вэ?

Ерөнхий чиг үүргийн яамдаас бусад.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Тийм. Ер нь бид мэдээж яг Эдийн засаг, хөгжлийн яам бол салбар дундын бодлого, зохицуулалт салбар дундын бодлого дээр байнга сууж байгаа.

Тийм учраас бид зөвхөн эдийн засгийн макро түвшний ажил биш. Би түрүүн яриад, салбар салбар луу орж яриад байгаа шалтгаан нь энэ. Яам болгон бодлогоо гаргана аа. Гаргалгүй яах вэ. Хоорондынхоо уялдаа холбоо хөгжлийн төлөвлөгөөнд хэр нийцэж байна, Монгол Улсын хөгжлийн бодлого Монголын хар хайрцгийн бодлогоос зөрж байна уу, зөрөхгүй байна уу гэдэг гол шинжилгээ, судалгаа. Дээр нь тэр санал санаачилгууд манай яамнаас гараад явахаар бид бол хүний нөөцөө ингэж харж байгаа юм. Жишээлбэл, Эдийн засаг, хөгжлийн яамны

хүний нөөцийн нас бол дундаж нас нь бараг 30 хүрэхгүй шүү дээ. Дандаа сайхан залуучууд, шинээр орсон залуучууд ажил хэрэг болоод явдаг.

Магадгүй энэ байгууллага ирээдүйд улс төржихгүй бол асар сайн хүний нөөцтэй Монголын эдийн засаг, хөгжлийн бодлогыг гаргаж чаддаг ийм чадавхыг бий болгосон ийм.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариултыг гүйцээж хариулъя. Л.Гантөмөр сайд. 3 номер.

Л.Гантөмөр: Тийм хүний нөөцийг бүрдүүлнэ гэдэгт итгэж байна.

Нөгөө талаар Дэлхийн худалдааны байгууллага оюуны өмчийн байгууллагатай хамтарч ажиллах П.Сайнзориг гишүүний саналыг бүрэн дэмжиж байгаа.

Ер нь бид хөгжлийн яаман дээр харьяалагдаж байгаа гэдэг утгаараа Оюуны өмчийн газар үнэхээр Монголчуудын оюуны өмчийг баталгаажуулах, хэлбэржүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх энэ ажил дээр их хурдтай байх хэрэгтэй. Нөгөө талдаа ногоон хөгжилтэй холбоотой таны саналыг бүрэн дэмжиж байгаа.

Тийм учраас ногоон хуулиа бид яаралтай өргөн барина. Тэгэхгүй бол үнэхээр бид энэ хөгжлийн хоцрогдол, нөгөө тогтвортой хөгжлийн гадна талд байгаа улс болж үлдэх ийм эрсдэлтэй.

Нөгөө талаар яг энэ худалдан авалтын хууль дээр бид тодорхой вакумжсан Засгийн газрын бодлогын workshop-ийг ойрын үед хийнэ. Хэн нэгэн Сангийн яаманд найдахаас илүүтэйгээр тал талын энэ зовлон жаргалыг ойлгодог хүмүүс.../минут дуусав/

Р.Сэддорж: Тодруулах шаардлагатай гэж үзээд П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд Л.Гантөмөр сайд аа, өөр бас нэг зүйлийг таны амнаас хэлсэнд баяртай байна.

Энэ байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал дээр наад байгаль орчны хуулиуд чинь үнэхээр тээг болж байна.

Эгийн голоор чинь дүүрэн тул байхад агнуулж болдоггүй. Нөгөө тул нь үржээд үхэж байна. Нөгөө дундаж хэмжээний загаснууд нь хоол болсоор байгаад сүүлдээ наад голд чинь ер нь загас үлддэггүй. Уламжлалт агнуур буюу морин дээрээс хүртэл загас агнадаг соёлыг устгачхаж байгаа байхгүй юу.

Бид хэд нэг юмыг хийхдээ маш туйлшруулах юм. Өнөөдөр манай баруун чиглэл дээрээ энэ захчин ястнууд ангийн соёлтой. Энэ дээрээс эм найруулдаг уламжлалт соёл нь энэ байгаль орчны хуулиудаас болоод байхгүй болчихлоо.

Тэгээд энэ зүйлүүдийг нь нутгийн иргэдийн квот ч гэдэг юм уу, аялал жуулчлалтайгаа хослуулаад бас нэг жоохон уян хатан бодлогоор явуулж өгөөч ээ гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд ер нь энэ дэд бүтцийн шугам, сүлжээний өмчлөлийн асуудлыг шийдэхгүй бол Зайсан дээр төв магистрын шугамаас жоохон шугам татаад үүнийгээ дамладаг хэсэг бүлэг этгээдүүд чинь хөрөнгө оруулалтыг, хот төлөвлөлтийг ер нь будаа болгож байна. Тэгээд яриад байвал маш.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд. 3 номер.

Л.Гантөмөр: Тийм. Тэгэхээр аль нэг яам харахаас илүү бид нарын хамтын ажиллагаа их чухал.

Тэгэхээр Их Хурал дээр байгуулагдсан 50 хэдэн ажлын хэсэг их үр дүнтэй ажиллаасай гэж хүсэж байгаа. Манай яамтай холбоотой асуудал дээр бид нээлттэй ажлын хэсгүүдтэй хамтарч ажиллана.

Энэ чиглэлээр би яамныхаа хүмүүст үүрэг өгчихсөн. Нэг жишээ хэлэхэд өнөөдөр чоно гаарчихлаа шүү дээ. Одоо айлын сүрэг рүү дайрч байна. Бүр гэрт нь хүн байхыг тоохгүйгээр 100 гаруй малыг нь сэглэлээ шүү дээ. Одоо тоглоом биш. Бүгдээрээ энд байгаа хүмүүс мал ахуйтай. Ерөөсөө төл авахаа больсон. Үндсэн шалтгаан нь чоно. Одоо ялангуяа Дорнод тийшээ гээд, Сүхбаатар тийшээ.

Гэтэл нөгөө чоноо агнаж болдоггүй хуультай. Чоно алж болдоггүй хуультай.

Тийм учраас бид энэ яг тоглоом биш. Ахуй амьдралдаа нийцсэн гаргалгаануудыг хэдүүлээ ойрын үед гаргаж явахгүй бол их том бэрхшээлүүдийг өөрсдөө их сайн сайхан сэтгэлээр дандаа өөр.../минут дуусав/

Р.Сэддорж: Баярлалаа. Н.Батсүмбэрэл гишүүн асуулт асууна.

Н.Батсүмбэрэл: Эдийн засгийн яам Тэргүүн Шадар сайд энэ мэдээлэл өгч байгаа явдалд талархалтай байна. Нэлээн өргөн хүрээний мэдээллүүд өгч байна.

Хоёр зүйлийг тодруулж асууя. Нэгдүгээрт, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр та бид санаа ойролцоо байх шиг байдаг. Харахад.

Тэгээд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хөгжүүлэх, цааш нь үүнийг хэрэгжүүлэх тал дээр танай яам судалгаа хэр хийж байна. Үүний нэг том жишээ одоо та Засгийн газраас өргөн барьсан тэр Хархорин хотын тухай хууль гэж би хараад байгаа.

Хархорин хот бол нэг талаас Монголын түүхэн хот, нөгөө талаас газар зүйн хувьд төвд оршиж байгаа хот. Үүнийг сэргээн байгуулж хийх нь маш том алхам. Магадгүй Засгийн газрын 15 дахь том төсөл ч байж болзошгүй. Тийм ээ.

Тэгэхээр энэ хуулийг жишээлээд баруун бүсийн, хойд бүсийн, төвийн бүсийн, говийн бүсийн, зүүн бүсийн төвүүдийг аль аймаг нь, хаана нь төв нь байна вэ? Энэ төвүүдийг хэрхэн хөгжүүлэх талаар Эдийн засгийн яам судалгаа хийж байна уу? Үүнийг Та бүхэн хууль эрх зүйн хувьд хэрхэн нээлттэй болгох вэ? Тэр төв дээр яаж хөгжлийг бий болгох эрх зүйн боломжуудыг нээж өгөх вэ гэдэг энэ асуулт байна.

Тодруулаад хэлбэл та бүхэн Халх голын асуудал хөндөж байна. Нэгэнт тэгж байгаа бол яагаад тэр Дорнод аймаг дээр зүүн бүсийн төв байж болдоггүй юм.

Тэрийг та нар одоогоос төлөвлөөд, олон улсын онгоцны буудал, хойд урд хөрштэй холбосон авто болон төмөр замын трасс гээд олон асуудлуудыг яагаад хийж болохгүй байна. Энэ судалгаа хийгдэж байна уу гэдэг нэг ийм асуулт.

Хоёр дахь нь, гадаад хамтын ажиллагааг идэвхжүүлэх асуудлыг хөндөж байна. Энэ бол маш чухал. Маргааш эхний Элчин сайдын асуудал орж ирэх юм шиг байна. Цаашид Засгийн газар дээр ярихдаа гадаад томилгоонуудыг мэргэжлийн тал руу нь явуулах.

Одоо энэ чинь Монгол Улс чинь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Франц Улстай хамтарсан төслүүд ойрын хугацаанд явуулахаар хууль эрх зүй нь нээгдчихлээ.

Мөн Бүгд Найрамдах Энэтхэг Улстай хамтарсан төсөл явж байна.

Дараа дараагийн том улсуудтай хамтарсан төслүүдийг явуулах даа энэ гадаад томилгоо, гадаадад байгаа мэргэжлийн хүмүүсийн үүрэг оролцоо чухал. Энэ дээр Та бүхэн, ялангуяа Эдийн засгийн яам чухал мэргэжлийн байр суурь гаргаасай гэж бодож байна.

Энэ дээр Та бүхэн ямар байр суурьтай байгаа вэ?

Нэг зүйл нь, уул уурхайг бид ярьдаг. Нэг хэсэг нь хааж ярьдаг. Нэг хэсэг нь дэмжиж ярьдаг.

Тэгэхээр энэ уул уурхайн хайгуулыг нэмэгдүүлэх бодлогыг Эдийн засгийн яам хийж байна уу? Энэ тал дээр холбогдох яамтай яаж ажиллаж байна. Энэ хайгуул нэмэгдүүлэх шаардлагатай байдаг гэж би хувьдаа бодож байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхний байр суурийг сонсьё. Ер нь тэгээд юм болгоны хэмнэлт рүү бид хийгээд их сурчихлаа. Одоо хэмнэлтээс бүтээмжид шилжих

чиглэл дээр Эдийн засаг, хөгжлийн яам ямар байр суурьтай байна вэ? Үүнийгээ та бүхэн яаж харж байна гэдэг дээр байр сууриа илэрхийлээч.

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариульъя.

Ер нь Н.Батсүмбэрэл гишүүн бол энэ сумдыг цөөлөөд, цаашдаа ер нь амьдрах чадвартай төв суурин бий болгох төрийн бодлогыг нэхээд байгаа юм. Нэг өдөр энэ таны хүсэж байгаа бодлого хэрэгжинэ гэдэгт би эргэлзэхгүй байгаа. Ер нь таны тэр харж байгаа өнцөг асар зөв.

Яг өнөөдөртөө бид ийм механик шилжилт хийх тэнхээ манай хамтарсан Засгийн газарт бол алга. Үнэнээ хэлье. Бид зүгээр хил холболтоо хийнэ, 14 мега төсөл явуулна гэхэд энэ засгийг унагах тухай асар их яриа, хов жив, бүлэглэлүүдийн үйлдэл, зарим нэг улс төрчдийн санаархал асар ихээр цухалзаж байна шүү дээ.

Тэгэхээр Монголын яг эмзэг мөртлөө магадгүй ирээдүйн хөгжлийг шийдэх таны хэлээд байгааг би олон удаа сонссон л доо. Засаг захиргааны нэгж дээрээ гол эдийн засгийн бодлого чинь явах юм биш үү гэж.

Тэгээд энэ рүү өнөөдөртөө бид орж чадахгүй байгаа шүү гэдгээ бас үнэнээ хэлэх хэрэгтэй.

Нөгөө талдаа яг төвүүд нь хэрхэн бий болох вэ гэж. Энэ бол кластераар өөрөө бий болно. Яг бодит байдал дээр зүүн бүсийн босоо тэнхлэг хийчихээр аяндаа Чойбалсан бол зүүн бүсийнхээ төв болчихно.

Баруун бүсийн босоо тэнхлэг явахаар зэрэг аандаа аль нь болох вэ гэдэг зүйл бол харагдана.

Төвийн бүсийнх дээр аль нь болох вэ гээд тэгээд их тодорхой байгаа шүү дээ. Төвийн бүс бол Дархан-Уул аймаг байна гэдэг нь тодорхой.

Хойд бүс дээр төв нь Эрдэнэт, Орхон аймаг байх юм байна. Эрдэнэт хот байх юм байна. Одоо бид нөгөө хотынх нь статусыг хийгээд тэнд хот гэдэг юугаараа хөгжих юм бол тэнд хойд бүсийн төв бий болно.

Хангайн бүсийн төв нь одоо Хархорум болох юм байна.

Говийн бүсийн төв бүр яг ингээд нарийн харах юм бол бараг Цогтцэций шахуу. Нөгөө эдийн засгийн эргэлтээрээ тэгж харагдаж байгаа юм.

Гэх мэтчилэн энэ төвүүд механикаар биш аандаа нөгөө бүсчилсэн хөгжлийн бодлого гараад ирэхээр тэр бодлогыг хэрэгжүүлэхэд аль нь кластер хийж

болохоор байна вэ. Яг тэрийгээ дагасан тэр дэмжлэгүүдийг өгснөөр тухайн төвүүд өөрөө бойжоод гараад ирэх юм байна. Энд 5-аас 10 жилийн хугацаа орох юм байна гэж харж байгаа юм.

Хайгуулыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Хайгуулаас хамгийн гол зүйл бол бид тэр хайгуул хийх эрхийг харамлахыг хэрхэн болих вэ гэдэг зүйл байгаа юм. Эрхээ харамламааргүй байгаа юм.

Нөгөө талдаа хайгуулын зардлаас бид татвар авдаггүй орчин бүрдүүлэх хэрэгтэй. Одоо хайгуул хийж байгаа хүмүүс юу вэ гэхээр ирээдүйн хөгжлийг эрж байна гэсэн үг. Ирээдүйд Монголыг сайн сайхан явах ажлыг хөрөнгөө гаргаад риск хийгээд эрж байгаа хүмүүс. Эрж байгаа.

Тэгэхээр тэр хүмүүсийг бид татвараар дарамталдаггүй байхыг энэ татварын шинэ бодлого дээр оруулна. Ялангуяа хайгуулын зардалд бид аль ч талаас нь татвар төлдөггүй байх, татвараас бараг зарим зардлуудыг нь чөлөөлдөг байх ийм зүйлийг хийж байж явах юм байна.

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд гүйцээж хариулъя. 3 номер.

Л.Гантөмөр: Тантай санал нэг байгаа нь бид бүтээмж гэдэг зүйлийн араас явна. Бүтээмжээр явахад санхүүжилтийн шинэ бодлого нэвтрэх учиртай.

Одоо яг Шинэ Зеланд шиг тодорхой санхүүжилтийг яг тухайн төсөлд гэхээс илүү тухайн ажлын үр дүнгээр нь хэмждэг үр дүнгийн санхүүжилтийн систем рүү бид шилжинэ.

Энэ шилжилт л ер нь бидний засаглалын төгсгөл рүү амилах болов уу гэж би харж байгаа юм. Бид шууд шилжихэд бэрх. Нэг удаа шилжиж үзсэн. Үр дүнгийн санхүүжилт рүү нэг удаа шилжээд үзсэн. Тэрийгээ хийж чадаагүй fail_[бүтэлгүйтсэн]-дсэн.

Одоо Эрүүл мэндийн даатгалын сан дээр Та бүхэн их анхаарал хандуулах хэрэгтэй. Эрүүл мэндийн даатгалын сан яг үр дүнгээр санхүүждэг систем рүү одоогоор шилжчихсэн байгаа хамгийн сайн кэйс байгаа. Үүнийг амь оруулах хэрэгтэй. Энэ дээр авлига, хулгайгүй болгох хэрэгтэй. Дээрэмгүй болгох ёстой. Жишээлбэл, бид шинжлэх ухааныг хөгжүүлэх ганц арга бол үр дүнгийн санхүүжилт гэж би сайдын хувьд харж байгаа юм.

Тэгээд С.Дэмбэрэл Ерөнхийлөгч маань энэ хажууд сууж байна.

Бид үр дүнгийн санхүүжилт рүү орно. Жишээлбэл, одоо бидэнд нэг инээдтэй юм байгаа байхгүй юу. Хүний хөдөлмөрийг үнэлэхдээ цэрэг цолны нэмэгдэл гэж өгөөд байдаг. Доктор гэдэг чинь тухайн хүн юу сурсныг илэрхийлдэг бичиг баримт болохоос биш тухайн хүнийг хэрхэн бүтээмжтэй байх тухай нотолгоо бол ерөөсөө

биш байхгүй юу. Гэтэл докторын нэмэгдэл өгнө гэх мэтчилэн бид хөдөлмөрийн үнэлгээг их буруу хийгээд байгаа.

Тэгээд хөдөлмөрийн үнэлгээгээ зөв болгоод, тэгээд үнэхээр үр дүнгээ зөв тооцоолоод, тухайн ажлынхаа үр дүнг нэхсэн санхүүжилт рүү шилжиж чадах юм бол бид бүтээмж рүү бүрэн шилжинэ. Жишээлбэл, Эдийн засаг, хөгжлийн яаманд 170 хүний төсвийг нь өгөөд хэнд ямар цалин өгөх эрхийг нь өгөх юм бол би магадгүй далан.../минут дуусав/

Р.Сэддорж: Н.Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Цаашид ер нь Эдийн засгийн яаман дээр явж байгаа мэдээллүүдийг нэлээн сайн нийтэд хүргэх, гишүүд сонсож байх нь их зөв байгаа.

Ер нь их өөдрөг төсөөллүүд, бас улс орны өмнө байгаа том асуудлуудыг шийдэх тал дээр энэ 3 намын хамтарсан Засгийн газар нэлээн үр дүнтэй ажиллах байх гэж бодож байгаа. Тийм хүлээлт ч байна.

Тэгээд энэ ажлыг сайн хийгээсэй гэж Эдийн засгийн яаманд хүсэж байна.

И.Батхүү мэтийн сайн боловсон хүчнүүд байгаа учраас энэ дээр эргэлзэх юм алга.

Тэгээд Та бүхэнд амжилт хүсье.

Р.Сэддорж: Санал гэж ойлголоо. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам аймаг, сумдын дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөг нэгтгэж хянадаг байх гэж бодож байна.

Тэгэхээр одоо энэ 21 аймаг, 330 сумын төлөвлөгөөнүүдийг аваад тухайн аймаг, сумдын газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн одоогийн нөхцөл байдал зэргээр нь аваад үзэхээр хэдэн бүлэглэлд ер нь сумдыг, аймгуудыг ангилдаг юм бэ гэж нэг тийм асуулт байгаа юм.

Тэгээд үүнийхээ хүрээнд аймаг, сумдууд өөрсдийнхөө 2025-2028 оны жилийн төлөвлөгөөнүүдээ боловсруулж байгаа байх.

Тэгэхээр энэ тал дээр нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас ямархуу чиглэл, зөвлөмж өгч ажилладаг вэ гэдэг нэг асуулт байна.

Хоёр дахь асуулт маань болохоор ерөнхийдөө бизнес эрхлэгчидтэй уулзаад явахаар ер нь боловсон хүчний асуудал бүх салбарт байна. Дутагдалтай. Ингээд ажиллах хүчний оролцоо маш бага байна гэж яригдаад байдаг.

Тэгэхээр бид богино хугацаанд хүн амаа өсгөж чадахгүй. Тэгэхээр одоо байгаа хүмүүсээ яаж ажлын, хөдөлмөрийн зах зээлд оролцуулах вэ гэдэг нэг асуудал. Нөгөө талдаа одоо ажиллаж байгаа хүмүүсийн бүтээмжийг яаж нэмэгдүүлэх вэ? Та сая ярьж байна.

Тэгэхээр энэ чиглэлээр холбогдох яамд, Эдийн засаг, хөгжлийн яам маань ямар чиглэл, зөвлөмж өгч ажиллаж байгаа вэ гэж хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт болохоор сумд маань ерөнхийдөө хөгжлийнхөө дагуу ер нь бүгдээрээ төвлөрсөн халаалт, нэгдсэн цэвэр, бохир усны системийг барьж байгуулах чиглэл рүү ингээд ажиллаж эхэлчхээд байна.

Тэгэнгүүт яг тэр ажлыг хийж хэрэгжүүлж байгаа тухайн төрийн байгууллагын, тухайн сумын өмч байх юм бол, төрийн өмч байх юм бол хариуцаж ажиллаж байгаа байдлууд нь харилцан адилгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр ингээд хамгийн сайн ажиллаж байгаа газруудыг нь харахаар ихэнх нь хувийн сектор яг тэр асуудлыг нь хариуцаж ажиллаж байгаа сумдын халаалт, цэвэр, бохирын асуудлууд нь харьцангуй гайгүй явж байна.

Тэгээд би энэ дээр юу гэж асуух гээд байна гэхээр одоо жишээлбэл манай Дорнод аймгийн Халхгол сумынх бол одоо Шинэ сум төслийн хүрээнд ингээд шинээр уурын зуух гээд маш олон барилга байгууламжууд баригдсан. Сүүлийн жилүүдэд байнга уурын зуух нь цоороод эвдэрч байдаг.

Тэгэхээр юунаас болж байна вэ гэхээр мэргэжлийн ажилтан олдохгүй. Төр өөрөө хариуцаж байгаа учраас энд ийм асуудал үүсээд байна.

Тийм учраас үүнийг одоо ер нь хувийн секторт шилжүүлээд, гэрээгээр, гэрээний үндсэн дээр. Ингээд ажиллуулдаг болёе гэдэг саналаа Эдийн засаг, хөгжлийн яаманд өгчихсөн. Танайхаас хариу хүлээж байгаа юм байна гэж би ойлгосон.

Тэгэхээр энэ тал дээр мэдээлэл байвал өгөөч ээ гэж хүсмээр байна.

Тэгээд энэ тайлан дээрээс харахад ер нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд гомдлоо шийдүүлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар ер нь явсаар байгаад 2-оос 3 жил болж байгаа тухай асуудал дурдагджээ. Энэ асуудал бол ер нь банкны салбар ч гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл муу зээлийн асуудлыг шүүхээр шийдвэрлээд л явахаар 6-аас 7 жил болдог.

Тэгэхээр өнөөдөр манайх чинь нөгөө зээлийн хүү өндөр байна гэж яриад байдаг. Тэгтэл зээлийн хүүд нөлөөлж байгаа бас нэг нөхцөл байдал манай энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал байгаа.

Тийм учраас энэ тал дээр Эдийн засаг, хөгжлийн яам маань ямар бодлогын чиглэлийг хууль зүй.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Тийм. Бид 21 аймгийн хөгжлийн төлөвлөгөөг айхтар ингэ тэг гэдэг зөвлөмж, зөвлөгөө гэх юм уу удирдамж бол өгдөггүй юм.

Ерөнхийдөө манай хөгжлийн төлөвлөгөөтэй нийцэл байна уу, байхгүй юу гэдэг дээр нь зөвлөгөө өгдөг. Ер нь аймгууд өөрийнхөө хөгжлийнхөө төлөвлөгөөг өөрийнхөө концепцоор гаргаж ирэх үүрэгтэй.

Зүгээр бид нарын алсын хараа бол аймаг дээр байгаа Хөгжлийн төлөвлөлтийн хүнтэй энэ яам холбоотой болох ёстой юм билээ. Хуучин манай Төлөвлөгөөний комисс аймаг болгон дээр хүнтэй л байсан юм байна лээ л дээ.

Тэгээд энэ тал дээрээ өнөөдөртөө их учир дутагдалтай байна. Яг үнэндээ шинэ тутам байгуулагдсан яам учраас хөл байхгүй. Тэр доор байгаа амьдралаас бас тасарчихсан.

Би одоо бодит байдлыг л Та бүхэнд хэлмээр байгаа юм. Яг үнэндээ бидний ойрын үед шийдэх асуудал бол яг тэр Нэгдсэн хөгжил төлөвлөлтийн газрын хэлтсийн дарга нь энэ яамны ямар нэгэн бүрэн эрхт төлөөлөгч ч юм уу. Тийм ээ. Харилцаанд орох ёстой юм билээ. Ямар нэгэн байдлаар харилцаанд.

Би өөрийн гэсэн хүнтэй больё гэж байгаа юм биш. Хэлтэстэй больё ч гэхгүй. Тэнд байгаа тэр байгууллага яам хоёр бүрэн эрх зүйн харилцаанд ямар нэгэн байдлаар орох ёстой. Хамтын ажиллагааны харилцаанд.

Тэр дээр хэдүүлээ, бид нэг ажил хийгээд тодорхой зүйл гаргая гэж бодож байна. Айхтар аймгуудаа бүлэглэж барьсан юм бол байдаггүй юм билээ. Зүгээр ерөнхийд нь хараад явдаг.

Хүний нөөцийг яг бүгдийг нь татаж оролцуулах, монголчуудыг яг ажилтай байлгах асуудал дээр нэг л зүйл байна.

Хэдүүлээ ер нь энэ цалингийн бодлогоо яаж шинэчлэх вэ гэдэг асуудал. Яг үнэндээ бодитой. Бодитойгоор бид цалингаа 1000 долларт хүргэх ёстой. Энэ бол бид нарын ямар нэгэн байдлаар тийм хувьсгалын маягтай, тэгэхдээ механик биш. Байгалиараа монгол хүн 1000 долларын цалин авдаг тэр орчин яаж угсрах вэ гэдэг ийм бодлогын шийдлийг бид эрэлхийлж байна. Гишүүн ээ. Ингэж байж хүн бүр ажилтай болно.

Нөгөө талдаа ерөөсөө л халамжаас татгалзах. Энэ рүү л хэдүүлээ одоо ингээд л чангараад л яваад байхаас өөр арга байхгүй. Дэлхий дээр байгаа Монгол шиг халамжийн улс бол одоо ер нь байхаа больсон.

Тийм учраас энэ ажил хийдэг хүнийг урамшуулдаг, компаниудыг дэмждэг гэх юм уу, хувийн хэвшлийнхэн Монгол Улсын баатар юмаа гэж тэр сэтгэл зүйг хэрхэн бий болгох вэ гэдэг их чухал ажил болох байх.

Ер нь суман дээр байгаа уурын зуух дээр ойлголоо. Таны хэлснээр Халх гол суманд тэр зөвшөөрлийг яаралтай чиглэлийг нь өгье. Хувьчлах хэрэгтэй. Ядаж гэрээгээр хувийн компани тэрийг гүйцэтгэх учиртай.

Ер нь бид энэ нийтийн дэд бүтэц гэж яригдаж байгаа. Эрчим хүчний реформ тэр шүү дээ. Үйлдвэрлэгч тал дээрээ хувийн хэвшлийг хэдүүлээ дайчилъя. Түгээлт дээрээ хувийн хэвшилдээ эрхийг нь олгоё. Боломжийг нь олгоё. Тэр дамжуулах.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Л.Гантөмөр сайд. 4 номер.

Ц.Эрдэнэбат: Ц.Эрдэнэбат. Л.Соронзонболд гишүүний асуултад нэмж хариулъя.

Улсын Их Хурал бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан. Үүний дагуу бүсчилсэн хөгжлийн концепцууд явж байгаа. Үүний тод жишээ нь хөгжлийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд дээр үндсэн 4 бүлэг нь “Бүсчилсэн хөгжил” гэж явж байгаа.

Яг тухайлсан аймаг, сумууд дээр бол 21 аймгийн төв болон нэмэх нь 70, 91 байршлийг эдийн засгийн хувьд хөгжүүлэхэд тохиромжтой гээд Улсын Их Хурлын тогтоол дээр заачихсан байгаа.

Одоо бид 2025 он болон 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр үүнийг бүр нарийвчилж гарч ирнэ. Суурь судалгаа хийсний үндсэн дээр яг энэ бүсүүд дээр яг юу хийгдэх юм. Тэрний ТЭЗҮ нь тодорхой бэлэн болоод, тэгээд бусад Цагаан суварга дээр жишээлэхэд Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн төлөвлөгөө гараад явж байгаа.

Түүн дээр жишээлэхэд Дисней Лэйндс шиг бүх үйлчилгээ нь төвлөрсөн байхаар нэг жишиг төлөвлөлт хийгээд явж байгаа юм билээ. Энэ тохиолдолд бусад яамд, соёлын үйлчилгээ нь Соёлын яам ч байдаг юм уу ингэж уялдах ёстой болчихоод байгаа.

Тэгэхээр энэ оны улсын хөгжлийн төлөвлөгөө дээр энэ бүсчилсэн хөгжлийг онцгой анхаарч тэр аймаг сумдуудын яаж хөгжих юм, тэр эрчим хүч, дэд бүтцийг нь яаж шийдэх юм гэдэг нэгдсэн уялдсан төлөвлөгөө нэлээд түлхүү орж ирэхээр эхний ажлууд хийгдээд явж байна. Тухайлбал, өчигдөр хөг зуугаад хүн оролцсон бүсчилсэн хөгжлийн чуулган хийсэн.

Тэгэхээр энэ чуулган дээр аймгуудын иргэдийн Хурал болон яг энэ бодлого төлөвлөлт хариуцсан хүмүүс ирсэн.

Мөн оны өмнө бид бас Удирдлагын академитай хамтарч орон нутаг, аймгуудын Стратеги бодлого, төлөвлөлтийн газрынхантай хоёр сургалт хийсэн байгаа. Гэх мэтчилнээр ингээд хамтран ажиллаад явж байна. Эхний ажлууд хийгдсэн одоо нарийвчилсан хэрэгжилтийн ажил руугаа эхний ажлууд нь ороод явж байгаа.

Р.Сэддорж: Тодруулж асуух юм уу? 4 номер гүйцээж хариулъя.

Ц.Эрдэнэбат: Хөдөлмөрийн зах зээлтэй холбоотойгоор “Ерөнхий сайдын албан даалгавар-2” гэж гарсан байгаа. Энэ дээр 3 чиглэлээр.

- ▶ Нэг нь, хиймэл оюун ухаан, өндөр технологи,
- ▶ Хоёр дахь нь, ногоон хөгжил,
- ▶ Гурав дахь нь, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын шилжилттэй холбоотойгоор.

Үүний дагуу Ажлын хэсэг өнөөдөр ингээд Ерөнхий сайдын захирамжаар гарч байна. Манай яам энэ дээр нарийн бичиг нь болоод явах юм.

Тэгээд энэ дээр хэд хэдэн нарийн судлах юмнууд байгаа юм билээ. Давуу талууд байна. Сул талууд байна.

Давуу тал нь бол энэ өндөр технологийн эрин зуунд хиймэл оюун ухаан, робот болон шинэ технологиуд бид нарын бүтээмжийг өсгөх, одоо дутагдаж байгаа хөдөлмөрийн зах зээлийг нөхөх боломжууд байна. Нөгөө талаасаа бас зарим ажлын байрыг байхгүй болгох, эсвэл тэр ажлын байр дээр бас эрсдэлүүд үүсэхээр ийм харагдаж байгаа.

Тэгэхээр бид бүх яамд, бүх төрийн байгууллагууд, орон нутаг энэ гурван чиглэлээр стратеги төлөвлөгөөгөө боловсруулна. Үүнийг манай яам нэгтгээд Засгийн газар танилцуулах ийм үүрэгтэйгээр ажлууд хийгдээд явж байгаа.

Р.Сэддорж: 5 номер хариулъя.

Б.Анар: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар Б.Анар.

Л.Соронзонболд гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой хөрөнгө оруулалт, гаднын хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа томоохон шалтгаануудын нэг нь бол яг энэ гадаадын хөрөнгө оруулалтын эрх ашгийг хамгаалдаг ийм тогтсон механизм байхгүй.

Дээрээс нь энэ эрх ашгийг нь хамгаалахгүй байгаагаас үүдээд маргаан нь томроод өөрөө шүүхийн маргаан болоод явдаг. Шүүх дээр очоод өөрөө дунджаар 2-оос 3 жил зарцуулагддаг. Шүүхээр шийдвэрлэгдсэн маргаан нь үргэлжлээд шүүхийн шийдвэр албан дээр очоод Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаагаар шүүхийн гарсан шийдвэрийн ойролцоогоор 10 орчим хувь нь л биелэгддэг, үлдсэн нь биелэгдэхгүй ингээд үлдээд байна гэсэн ийм судалгаанууд байгаа.

Түрүүн Л.Гантөмөр сайдын хэлсэнчлэн яг энэ гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн багц төслийг боловсруулчихсан байгаа. Удахгүй олон нийтийн хэлэлцүүлэгт шилжүүлэх гэж байх шиг байна.

Энэ хууль дээр ямар зохицуулалтууд туссан бэ гэхээр хоёр төрлийн зохицуулалт.../минут дуусав/

Р.Сэддорж: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. Яах вэ, үүнийг бүрэн үзсэн л дээ.

Тэгээд энэ дээр гол асуудал нь энэ газартай холбоотой л асуудал байгаа юм. Энэ дээр зүгээр хязгаар тогтоогоод ингээд орон сууц барих. Яагаад гэвэл орон сууц барьсан газар бол эргээд нийтийн өмчлөлд эзэмшилд шилждэг шүү дээ.

Тэгээд энэ асуудлыг ер нь яаж хялбарчлах вэ? Ер нь либералчлах гээд яриад байгаа шүү дээ. Тэгээд энэ зүйл энэ хууль дээр бол их учир дутагдалтай байгаа. Нэг.

Хоёрт нь, жирийн иргэд аж ахуй эрхэлье гэхээр яг үнэндээ энэ газар дуудлага худалдаа гэхээр авч чадахгүй л байгаад байгаа юм. Би үүнийг бас чуулган дээр Л.Гантөмөр сайдаас асууж байсан. Энэ дээр ер нь тэрнээс хойш, энэ намараас хойш ер нь ямар өөрчлөлт орсон бэ?

Хоёрдугаарт нь, энэ худалдааны хууль өргөн барина гэж байгаа юм. Одоо бол ингээд Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж байна. Тусдаа худалдааны яам байхгүй. Гадаад худалдааны асуудал бол аймаар том асуудал. Энэ бол төр баталгаа гаргаж энэ хил үнэ, бусад нөхцөлөөр аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт хийх. Гадаадын. Дотоодын аж ахуйн нэгжүүд энэ хөрөнгө оруулалтын эргэлтэд орох дээр үүнийг их тодорхой болгож төр өөрөө батлан даадаг болгохгүй бол энэ бас ингээд л нэг л болохгүй л яваад байгаа юм даа. Энэ дээр Тэргүүн Шадар сайд ямар өөрчилж шинэчлэлт, реформ хийх гэж байгаа вэ?

Гуравдугаарт нь, бүсийн шинж чанартай энэ олон улсын нисэх онгоцны буудлуудыг шинэчилнэ, төр, хувийн үйлчилгээ хийнэ гэж байгаа. Энэ маш олон удаа тендер зарлагдаад тэгээд энэ хэрэгжихгүй яваад байгаа юм.

Тэгэхээр ямар санал байна гэхээр эхний ээлжид энэ нисэх буудлуудын хөөрөх буух зурвасыг ядаж шинэчилмээр байна. Тэгэхгүй бол Дорнод аймгийн Чойбалсан олон улсын нисэх онгоцны буудал гэхэд ийм нөгөө Оросын цэргийн үеийн, дээр үеийн гэж хэлэх үү дээ. Онгоц буудаг байсан учраас ийм хавтан замтай 6:2-ын харьцаатай. Тэгээд энэ нь ийм нөгөө завсартаа заагтай учраас орчин үеийн онгоцнууд бууж болохгүй. Технологи нарийн болчихсон. Өндөр мэдрэгч ихтэй учраас энэ буухгүй. Тэгээд л 650 километр байдаг Чойбалсан хот, Дорнод аймаг ингээд нисэх онгоцны буудал ажиллахгүй байх жишээтэй байна шүү дээ.

Тэгэхээр аймаар том барилга барина гэхээсээ илүүтэй эхний ээлжид энэ зурвасаа шинэчлэх үү? Энэ дээр ямар бодлого барих вэ?

Дараагийнх нь энэ бүсүүд бол татах хүч буюу бүсийн төвүүд байж л энэ уг нь хөгжил яригдана л даа. Бүгд Улаанбаатар луугаа бөөгнөрөхгүй шүү дээ. Энэ дээр нэг тийм Эдийн засаг, хөгжлийн яамнаас яг ямар томоохон бодлого баримталж байгаа вэ?

Дараагийнх нь, энэ хуурай боомт гээд төлөвлөлтөд байгаа л даа. Манай зүүн бүст гэхэд Бичигт боомт, Чойбалсан хот гээд. Энэ бол яг олон улсын зарчим нь нисэх буудалтай, төмөр замтай, авто замтай байгаа тохиолдолд шалгуур нь байдаг гэж ойлгож байгаа юм. Гэтэл энэ нисэх буудал нь жишээлбэл Чойбалсанд.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут. М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Тэгэхээр яах вэ, одоо хол сонсогдож байж магадгүй.

Тэгээд л мөдхөн л гүний гааль гэдэг шиг хуурай боомтын асуудал шийдвэрлэгдэнэ шүү дээ.

Тэгэхээр энэ асуудал дээр ер нь ямар байр суурьтай байгаа вэ? Эдийн засаг, хөгжлийн яам.

Хамгийн сүүлийнх нь, байгаль орчинтой холбоотой асуудал дээр бас жоохон буруу ойлголтууд явчав уу гэж би зүгээр бодож байна. Энэ тул загас гэдэг бол дэлхий нийт үүнийг чинь бүр аягүй өндөр түвшинд хайрладаг, хамгаалдаг болчихсон. Энэ чинь цэнгэг усны чоно гэсэн үг. Энэ голын усанд байгаа загасыг хамгийн дээд талд нь хянаж байдаг ийм л амьтан байхгүй юу.

Замагаар хооллодог загасыг тул загас тоо хэмжээг нь зохицуулж хянадаг гэх юм уу. Байгалийн зүй тогтолыг цаашдаа хамаагүй ингэж ярьж болохгүй л гэж бодож байна. Би П.Сайнзориг гишүүнд үүнийг санал болгож хэлсэн. Иэгээд энэ бол тийм болохгүй сэдэв шүү. Дэлхийн хөгжлийн чиг хандлага өөр байгаа. Чоно ч гэсэн.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд хариулъя. 3 номер тийм.

Л.Гантөмөр: Тэгэхээр бид бүсчилсэн хөгжил гэдэг нь тухайн бүс нутагт, аймаг, сум, багийн түвшинд жижгэрэхгүйгээр яг бүс нутгийн түвшинд бизнес эрхэлж болохуйц, бүс нутгийн түвшинд эдийн засгийн харилцаанд орж болохуйц тэр хөгжлийн стратегийг л хэдүүлээ яриад байгаа юм л даа.

Тэгэхээр нэрлэхгүйгээр их тодорхой зүйл байгаа шүү дээ. Зүүн бүсэд зүүн босоо тэнхлэг орчихоор тэр босоо тэнхлэг өөрөө хөгжлийн гол гарц нь болох нь тодорхой. Энд авто зам, төмөр замын хоёр том коридор бий болно.

Тэгээд энэ коридорын төвд байгаа нь Чойбалсан хот. Тэгэхээр Чойбалсан хот өөрөө татах хүч болно.

Тэгээд түрүүн хэлдэг Эрдэнэт хот, Дархан хот гээд энэ хотууд цаашаагаа Хархорум хот гээд энэ хотууд цаашаагаа төвлөрлийг татаад явах нь их ойлгомжтой л байгаа юм л даа.

Нөгөө талдаа Чойбалсан хот маань өөрөө нисэх буудалгүй байна гэдэг бол өнөөдөр бид анхиагүй унхиагүйн л шинж шүү дээ.

Тийм учраас үүнийг яаралтай хэдүүлээ хийчих хэрэгтэй. Тэр заавал хувийн хэвшлээ хүлээлгүйгээр нисэх буух зурвас барих хэмжээнд бол манай улсын эдийн засаг байгаа шүү дээ.

Тийм учраас одоо бид энэ төв үнэхээр одоо Чойбалсан өөрөө яг Зүүн хойд Азийн эдийн засгийн холболт дээр Монгол Улсын хамгийн чухал газар байхгүй юу. Монголыг үзье гэвэл Солонгосоос заавал Улаанбаатарт ирж яах юм бэ. Чойбалсанд буугаад тэр хавьд аялал жуулчлал хийгээд буцаад нисэхэд бол нислэгийн цаг хамаагүй хөнгөрнө шүү дээ. Ер нь Буйр дээр буугаад Буйр дээр амарчхаад буцаад явахад Монголд ирсэнтэй ялгаагүй. Зүгээр харин тэр кластер дээр Монголд байж болох бүх л үйлчилгээ юм нь бол тэндээ хөгжчих юм бол би энэ Азийн аялал жуулчлал бараг Чойбалсан хот. Тэгээд наашаа эргээд нөгөө Дэлүүн Болдог хавьдаа бүтэн эргэлт тэнд байгаа байхгүй юу. Нисэх цаг хамаагүй хэмнэгдэнэ.

Тийм учраас бид зүгээр энэ талаасаа харж, нөгөө ирэх хүмүүсийнхээ цаг, сонирхол, тэгээд үйлчилгээ гэдэг зүйлээ харах юм бол бид энэ төвүүдээ ингээд хийчхэж болно.

Газрын асуудал Газрын багц хуулиа бид боловсруулна. Яг өнөөдөртөө би цаг хугацаа хэлж мэдэхгүй байна.

Тэгээд энэ дээр ингээд тал талаасаа их нэлээн нухацтай ажиллана. Монгол хүмүүс газартай байх тэр зарчим бол газар нь том байх гэдэг зарчим руу бараг

шилжих байх. 0.07 их тийм хомсхон газрын тухай бид яриад байгаа юм л даа. Байсан нөгөө айлуудын хашаагаараа багцаалчихсан. Гэтэл бид энэ монгол хүний амьдрах орчин, тэр хэрэгцээ шаардлага бол тэр 0.007-гоо давчихсан шүү дээ.

Тэгэхээр яг бодитой амьдрал дээр ямар хэмжээний газар дээр монгол хүн ахуй эрхлээд амьдарч болохоор байна вэ гэдэг ийм зүйлсийг ярина. Нөгөө талдаа арилжааны чиглэлийн бизнес эрхлэх газрын тухайд ямар боломж бололцоог хэдүүлээ гаргах вэ гээд энэ багц.../минут дуусав/

Р.Сэддорж: Дараа нь үг хэлэх юу байгаа. Тэр дээрээ хэлэх үү? М.Бадамсүрэн гишүүн. Асуултаа нэмэх үү? Тодруулж асууя. Эхлээд Л.Гантөмөр сайд тэгвэл хариултаа дуусгачихъя. 3 номер.

Л.Гантөмөр: Тэгэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээрээ хэдүүлээ жоохон хурдтай явуулах тухайд л юмаа бодмоор юм билээ.

Тэгээд тэр чинь түншлэл гэж юу юм бэ гэхээр одоо жишээлбэл нэг замын эрхийг нэг компанид өгч байгаа юм. Тэр нь 30 жил ашиглаад юм уу, 15 жил өөрөө хийгээд бизнесээ нөхөөд ашгаа олоод буцаагаад улсад нь өгнө гэж байгаа юм. Газраа өгч болохгүй хэсэг дээрээ түншлэл яриад байгаа байхгүй юу. М.Бадамсүрэн гишүүн ээ. Тэрийг хэдүүлээ ойлгох хэрэгтэй. Түүнээс биш 100 жилийн хугацаатай, эсвэл мөнхийн бизнес маягаар өгье гэвэл түншлэл хийх албагүй. Тухайн компани хөрөнгөө оруулаад Газрын хуулиараа явчих боломжтой.

Тийм учраас бид энэ тодорхой хугацаатай юм байна. Тэгээд нийтийн эзэмшил дээр хийх юм байна. Буцаад улсад нь өгөх юм байна гэдгийг л бүгдээрээ ойлгочход түншлэл бол өөрөө явчихна.

Жишээлбэл, гангийн үйлдвэр дээр санал өгч байгаа гаднын хөрөнгө оруулагч хэлж байгаа шүү дээ.

Би 15 жилийн дотор ашгаа нөхчихнө. 15 жилийн дараа гангийн үйлдвэрээ би хүний.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт нэмэх шаардлагатай. М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Газрын асуудал өөрөө их суурь харилцаа л даа. Эмзэг асуудал. Ойлгож байгаа.

Гэхдээ миний асуугаад байгаа нь жишээлбэл ингээд дахин төлөвлөлт гээд хийж байна. Нийслэлд бол ингээд дахин төлөвлөлтийн эрх олгоод, тодорхой бүс нутгуудад газрыг нь чөлөөлөөд хувийн хэвшилтэй тохиролцоод газрыг нь аваад ингээд орон сууц бариад явах нэг хувилбар.

Нөгөө хувилбар нь яг Сэлбэ дэд төв шиг төр өөрөө 500 айлын газрыг мөнгө мөнгө гаргаж, хөрөнгө гаргаж өмчлөлийн газрыг нь чөлөөлж худалдаж аваад тэр дээр нь төлөвлөлт хийх.

Тэгэхээр бид юу гэж хараад байна гэхээр орон нутагт энэ орон сууцын хүртээмжийг. Одоо нийслэл ч гэсэн ялгаагүй хоёр тал руугаа Багануур хүртэл, баруун талдаа Өвөрхангай хүртэл ч байдаг юм уу хурдны галт тэрэг ирээдүйд мэдээж байгуулагдахаас өөр гарц байхгүй. Тэгж байж энэ хонхроосоо бид гарна. Энэ 4 уулынхаа дундаас.

Тэгэхэд энэ газрыг төрөөс дэд бүтцийг нь татаад боломжийг нь олгоод энэ газар дээр орон сууц барья гэхээр дуудлага худалдаагаар авна гэвэл метр квадратын чинь үнэ нэмэгдээд байна. Одоо орон сууцын үнэ яг үнэндээ маш хяналтгүйгээр дээшээ өсөөд байгаа байхгүй юу. Үүнийг яаж тогтоон барих вэ гэдэг дээр хэд хэдэн арга байгаа. Жишээлбэл, миний.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулах хүн байгаа юу? 3 номер. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Тийм. Түрүүн бас М.Бадамсүрэн гишүүн тэр нөгөө байгаль орчны асуудал дээр жоохон буруу ойлголт авчихсан.

Уг нь миний хэлсэн тайлбар ер нь энэ байгаль хамгаалах гэдэг ойлголтын дотор бүх бизнесээ гацаадаг, зогсоодог, авлигал авдаг, тэгээд хугацаа сунгадаг ийм асуудал байгаа байхгүй юу. М.Бадамсүрэн гишүүн ээ. Цаг алддаг. Үүнийг хөнгөвчлөх тухай л би ярьж байгаа юм. Жоохон хурдтай байя, богинохон хугацаанд хийе, ил тод байя гэж байгаа юм.

Түүнээс тэр агнуурын тухайд бол П.Сайнзориг гишүүний л санаа болохоос биш бид энэ эдийн засаг ярьж байгаа юм. Тийм. Үүний жишээ болгож би тэр чоно ярьсан. Чоныг хориглоно гэдэг чинь энэ монгол ахуйгаас бид хэтэрхий тасарсны л шинж байхгүй юу даа. Чоно дэлхийн ховор амьтны тоонд ороогүй шүү дээ.

Мазаалайг хамгаалдаг шиг чоныг хамгаалж болохгүй байхгүй юу. Бид үнэхээр малаа барж байна шүү дээ. Одоо та Дорнодоос зөндөө тан руу ярьж байгаа биз дээ? Зээр байхгүй болчихлоо. Ноднин өвлийн зуднаар явчихсан. Одоо чоно.../минут дуусав/

Р.Сэддорж: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл өгч байна. Баярлалаа.

Ирэх жил төлөвлөсөн ажлууд их байна. Тэгээд ялангуяа хамгийн таалагдсан нь энэ бизнес эрхлэх эрх чөлөөг нь олгож өгье. Хувь хүн аж ахуйн нэгж ажил хөдөлмөр эрхлээд, орлогоо өөрсдөө олоод явдаг. Амархан байдлаар, энгийн

байдлаар. Дэм болохгүй бол битгий гай бол гэж байгаа. Түүн рүү шилжье гэж байгаа нь их зөв байна. Тэрийг магтаж байна.

Тэгээд энэ барилгын салбар дээрээ жоохон анхаараасай гэж бодож байгаа. Хот байгуулалтын сайд Ж.Батсуурь сайдтай бас энэ дээр бас Эдийн засаг, хөгжлийн сайд хамтарч ажиллаасай гэж хүсэж байна. Манай барилгын салбар бол бараг энэ бүх салбар дотроосоо хамгийн хүнд нөхцөлтэй байгаа.

Нэгдүгээрт нь, барилгын тусгай зөвшөөрөл гэж зүйл байгаа. Ер нь энэ тусгай зөвшөөрөл гэдэг төрөөс хувь хүн аж ахуйн нэгжид ажил хийх гэж байхад нь зөвшөөрөл олгоно гэдэг энэ нэг хоцрогдсон социалист тогтолцоогоо нэг бүрэн халж хаямаар байна.

Одоо нэг хоолны газар ажиллуулах гээд шорлог шарахын тулд зөвшөөрөл байхгүй гээд хөөгдөөд явдаг юм шүү дээ. Тэр хүн чинь амьдрах гэж байгаа шүү дээ. Ийм зөвшөөрлийн тогтолцоонуудыг нь байхгүй болгоод яг зөвшөөрөлгүй болгоод стандартаа мөрдүүлнэ. Эсвэл стандартгүй газар зөвшөөрөл хэрэгтэй байдаг юм уу. Энэ чинь зоосны хоёр тал шүү дээ. Манай аж ахуйн нэгжүүд зөвшөөрлөө авчихна. Дээрээс нь нэмээд стандартаа мөрдөнө гээд нуруугаа авхуулж байгаа шүү дээ. Аль нэг талдаа гарах ёстой байгаад байгаа.

Тэгээд энэ барилгын салбар дээр энэ Барилгын хөгжлийн төв гэж байгаа, улсын комисс гэж байна. Захиалагчийн хяналтын ажлыг л хийгээд байгаа юм л даа.

Энэ захиалагчийн хяналтынхаа салбарыг нь төр нь өөрөө монополдчихоод хүнд суртал, авлигал, хээл хахуулийнхаа үүр нь болчихоод сууж байгаа шүү дээ.

Бас нэг зураг төсөл болон барилгын жишиг үнэ гэж нэг юм байгаад байгаа юм. Нөгөөхийгөө тогтоочхоод шинэчилдэггүй. Архитектур инженерүүдийн бүтээлч сэтгэлгээг нь нэг маягийн жишиг үнээр үнэлээд байхаар энэ салбар хөгжихгүй. Үүнийг нь бас эдийн засгийн талаас нь сайн хараад Ж.Батсуурь сайдаас шийдэл гаргаж өгөөсэй гэж хүсэж байна.

Хоёр асуулт байна. Эхнийх нь 2025 ондоо багтаад Солонгос Улс болон Евро-Азийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны түр хэлэлцээрүүдийг байгуулна гэж байна. Шинэ юм хийх гэж байгаа бол эхлээд хуучин юмаа дүгнэж сурмаар байгаа юм л даа. Манай Засгийн газар.

Манайх Япон Улстай 2016 онд гэрээ байгуулсан шүү дээ. Байгуулснаас хойш бид бараг жилдээ 700 сая долларын гадаад худалдаа хийж байхад манайх экспортолж чадаж байгаа нь үсрээд л 30, 40-хөн сая доллар байгаад байгаа юм. Яагаад бид ийм юман дээр алдаад байгаа юм. Солонгос дээр Евро-Ази дээр ийм алдаагаа давтах юм уу, үгүй юм уу? Ямар алдаан дээр юу сурсан юм гэдэг тийм нэг үр дүнгийн тайлан гэдэг зүйл бас авмаар байна. Үүнийг гаргаж байгаа болов уу? Судалгаа хийж байгаа болов уу?

Дараагийн асуулт нь, гаднын хөрөнгө оруулалтад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв гэж байгаа. Манайх үнэхээр экспортлогч орон болох гэж байгаа юм бол гадагшаа бүтээгдэхүүн экспортлох гэж байгаа аж ахуйн нэгжид зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв бас байх хэрэгтэй байгаа юм. Ийм зүйлийг байгуулах ажлыг хийх үү гэсэн хоёр асуулт байна.

Р.Сэддорж: 3 номер Л.Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Г.Лувсанжамц гишүүний санал санаачилгад үнэхээр талархаж байна.

Ер нь экспортыг дэмждэг, үйлчилгээ үзүүлдэг байх учиртай. Хөрөнгө оруулагчдыг ч гэсэн дэмждэг үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй.

Гол нь одоо яг өөрийн чинь хэлж байгаа нөгөө экспортыг дэмжих үйлчилгээ байхгүй, өрсөлдөх чадварыг дэмжих дэмжлэг үйлчилгээ бодлого байхгүй учраас бид Японы зах зээл дээр өрсөлдөж чадахгүй байна.

Японы чанартай бараа худалдаж авч байгаадаа бид эмзэглээд хэрэггүй. Сайн бараа авдаг, чадалтай бараа авдаг: Сайн. Зөв. Эргээд бид нарт олдож байгаа тэр зах зээлийн том боломжийг ерөөсөө ашиглаж чадаагүй. Хийхгүй байгаа. Японы зах зээл рүү.

Одоо жишээлбэл ингээд байхгүй юу. Монгол руу одоо Евро-Азиас архи орж ирээд Монголын зах зээл дээр зарагдана гээд байгаа юм. Өнөөдөр хэн ч авчирч зарж чадахгүй байхгүй юу. Яагаад гэвэл Монголын худалдааны сүлжээнд гаднын компани нэвтрэх аргагүй болчихсон.

Өнөөдөр манай АПУ компани шиг бүх үйлдвэрүүд рүү бараагаа тараадаг тийм худалдааны сүлжээний асуудал байхгүй юу даа. Манай сүлжээ рүү хүн нэвтрэх бол одоо барахгүй шүү дээ. Талх чихрийг хүн гүйцэхгүй. Тэр мах, махан бүтээгдэхүүнийг, хиамны компанийг хүн гүйцэхгүй. Тортны компанийн тэр сүлжээг хэн нэгэн хийж чадахгүй.

Түүнээс хөөрхий гадаад архи дарс юу байдаг юм Монголд худалдъя гээд л баахан амьтан контейнероор, ганзагаар зөндөө л юм авчирч байгаа шүү дээ. Бид нарт бүх бүртгэл нь байна шүү дээ. Зарж чадахгүй. Сүлжээ байхгүй. Яг түүн шиг бид гадаад улсад хэрхэн Японы сүлжээ рүү нэвтрэх вэ, сүлжээ угсрах вэ, хэрхэн Солонгосын сүлжээ рүү нэвтрэх вэ, сүлжээ угсрах вэ гэдэг зүйл дээрээ онцгой анхаарах хэрэгтэй.

Нөгөө талдаа ер нь Солонгостой хийж байгаа хэлэлцээрийг бас гишүүддээ нэг танилцуулах ёстой. Бид яг ямар сургамж аваад, хэрхэн хэлэлцээртээ анхаарч байгаа тухай мэдээллийг Та бүхэнд өргөн дэлгэр өгөх учиртай гэж ингэж ойлгож байгаа.

Барилгын салбар дээр бол их ойлгомжтой. Стандартаа шинэчилж чадахгүй байгаа. Хяналтыг монопол болгож байгаа. Авлигын нэг эх сурвалж болгочихсон. Үүнийг засах хэрэгтэй. Засах хэрэгтэй. Тусгай зөвшөөрөл дээр тэр архитектур болоод мэргэжлийн хүмүүст зөвшөөрөл өгдөг байх нь өөрөө хамгийн чухал. Барилгын компани гэхээс илүү тухайн хүний гарын үсгээр явдаг. Тэр хүн нь хариуцлагаа хүлээдэг гэдэг энэ Япон жишиг рүү шилжих учиртай.

Тэгэхгүй бол одоо баахан хуучин Оросын стандарт барьчхаад хөнгөн барилга барьж чадахаа больчихсон. Заавал үнэтэй, заавал хүнд даацын барилга руу бид явдаг. Түүнийхээ өртгийг дийлдэхгүй. Зах зээл нь. Тийм учраас үүнийг анхаарах хэрэгтэй.

Нөгөө талдаа үнэхээр орон сууцыг бид цөөхүүлээ юм чинь эдийн засгийн ямар нэгэн салбар, барилгын салбар гэж харалгүйгээр орон сууц бол бараг заавал шийдэх асуудал л даа. Бид бол.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Тийм.

Тэгэхээр Японд хийсэн үр дүн бол би тодорхой хэллээ шүү дээ. Бид Японы зах зээл рүү Засгийн газар манлайлж тэнд өөрийнхөө худалдааны төлөөлөгчийг ажиллуулах, тэдний сүлжээ рүү нэвтрэх ажил хийгээгүй юм билээ. Тэр ажлыг хэдүүлээ хийх хэрэгтэй.

Тийм учраас түрүүн Н.Батсүмбэрэл гишүүн хэлсэн үү, хэн нь хэлсэн. Гадаад худалдааны бодлогоо одоо шинэчил гэдэг зүйлийг хэлж байгаа юм. Тэнд бид хүч өгч байж экспортлогчдоо дэмжих юм байна лээ л дээ.

Нөгөө талдаа Солонгосын зах дээр ч адилхан. Бид олоод өглөө. Та нар яв гэхээр одоо манайхан чинь төрөөрөө дарамтлуулсаар байгаад нуруугаа авхуулсан морь шиг болчихоод байна шүү дээ. Үгүй ээ, одоо тэгээд танихгүй зах зээл дээр очоод ингэж үйлээ үзээд яалтай билээ гээд. Нэг.

Хоёр дахь нь, ер нь энэ бизнес эрхлэгчдийн үе шилжилт явж байна шүү. Үүнийг онцгой анхааръя хэдүүлээ. Энэ хүмүүс 20 жил, 30 жил зүтгээд одоо бол ер нь халширчихсан. Дараа үе нь гарч ирээгүй. Дунд нь баахан дээрэм явах гээд байгаа.

Тийм учраас энэ шилжилт, энэ Капитал.../минут дуусав/

Р.Сэддорж: Г.Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Тийм. Та их зөв чиг хандлага, алдаан дээрээ яг юуг хийх ёстой гэдэг дээр зөв шийдэл хэлж байна л даа.

Та бас сайн мэдэж байгаа байх. Япон чинь жишээ нь Америктай худалдааны гэрээ хийгээд машин экспортолно, цахилгаан бараа экспортолно уу гэхээр төр нь өөрөө очоод Ниссан, Тоёотагаас, Панасоникоос, Сонигоос очоод экспортол, ийм журам бид баталчихсан юм, ийм гэрээ хийчихсэн юм, үүнийг нь та нар ингэж давах юм шүү. Хэдүүлээ хамтраад үүнийгээ хийчихье гэсэн нэг тийм цэгийнх нь үйлчилгээ нь ерөөсөө байхгүй байгаа юм. Тийм болохоор бид 2016 оноос хойш Япондоо хийсэн худалдаа алдагдалтай гарч байна.

Та сая хэлж байна. Чанартай бараа аварч байгаа нь зөв. Зөв л дөө. Эсрэгээрээ Япон талд бас бид нараас худалдаж авъя гэсэн хэрэгцээ нь байгаад байгаа байхгүй юу. Танайд хөрөнгө оруулалт хийх гэсэн юм гэж нэг цэгийн үйлчилгээний байж байхад Японы худалдааны компаниуд хүрч ирээд танайхаас юм авъя гээд хэлэхээр тэрийг нь холбодог цэг нь бас байхгүй байгаа юм. Тэрийг нь хийгээсэй гэсэн санал байна.

Р.Сэддорж: Санал уу? Мэндбаярын Мандхай гишүүн асуулт.

М.Мандхай: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Гурван асуулт байна.

Нэгд нь, энэ танилцуулга дээр 2.2 дээр 2025 оны төлөвлөгөөний талаар хөдөө аж ахуйн томоохон үндэсний хөдөлгөөн, аяны хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн бодлогын төсөл, арга хэмжээнүүдийг тусгаж байгаа юм байна.

Тэгээд энэ материал хэзээ бэлэн болох вэ? Яагаад гэхээр парламент дээр байгуулагдсан хөдөө аж ахуйн үйлдвэржилтийг дэмжих бодлогын ажлын хэсгийн нэг чиг үүрэг бол эдгээр хөдөө аж ахуйтай холбоотой үндэсний хөдөлгөөнүүдийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах нэг ийм чиг үүрэг байгаа.

Тэгэхээр энэ чиг үүргийг одоо энэ 2025 оны төлөвлөгөөн дээр тусгагдсан байгаа Засгийн газрын энэ чиглэсэн бодлогын төсөл, арга хэмжээтэй яаж уяж дэмжиж ажиллах вэ гэдэг дээр асуумаар байна. Бид яаж энд хамтарч ажиллах боломжтой байна гэдэг дээр мэдээлэл өгнө үү?

Хоёрдугаарт, бид 14 мега төслийн тэргүүлэх ач холбогдолтой томоохон төслүүд хэрэгжих гэж байна. Өндөр дүнтэй. Тэгээд үүнийг бид хамгийн үр дүнтэй, дээрээс нь ил тод, хариуцлагатай, үр өгөөжтэй байлгахын тулд ерөөсөө л бидний хувьд Monitoring and Evaluation system-ийг зайлшгүй бүрдүүлэх хэрэгтэй байгаа.

Тэгэхээр энэ дээр хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлага зохицуулалтыг хангасан нэгдсэн ийм платформ dashboard-ыг хийхээр төлөвлөж байгаа юм байна.

Тэгэхээр энэ dashboard-ыг хэзээнээс хэрэгжүүлэхээр тооцож байгаа вэ? Төслүүд маань санхүүжилт нь гараад хэрэгжилт эхлээд явахад энэ платформ өөрөө бэлэн болчихсон хяналтаа хийгээд явж байх шаардлагатай байгаа.

Тэгэх юм бол одоо бид нарт ч гэсэн эндээс чинь тайлан мэдээлэл аваад эргээд хяналтынхаа системийг босоо удирдлагатай уялдаатай ажиллаад явах боломжтой болох юм.

Гуравдугаар асуулт нь, аялал жуулчлал дээр бид аялал жуулчлалыг хөгжүүлэх олон төсөл, хөтөлбөрүүдийг, барилга байгууламжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Сая өнгөрсөн зуны асуудал дээр ямар асуудал болсон гэхээр хамгийн том ложистик бид нарт нэг барьер байгаа. Энэ нь юу гэхээр дотоодын жуулчдыг аваачаад нислэг хийх гэхээр зөвхөн МИАТ нисдэг. Дотоодын бусад нислэгүүдийг нисүүлдэггүй. Тэгээд сая яасан бэ гэхээр МИАТ өөрөө ачааллаа дийлэхээ байж эхэлсэн. Жил ирэх тусам жуулчдын тоо өсөж байгаа. Дотоодын нислэг нь өөрөө МИАТ өөрөө ачааллаа дийлж чадахгүйгээс болоод хуваарьт заагдсан байсан нислэгүүд өөрөө цуцлагдаж эхэлсэн.

Тэгэхээр энэ дээр нэгэнт Эдийн засаг, хөгжлийн яам анхаарч ажиллах гэж байгаа бол бид салбарыг хөгжүүлэхийн тулд бусад ложистикийн асуудлыг зайлшгүй анхаарч авч явахгүй бол буцаад жуулчдын компаниудын жуулчид нь гомдол бухимдал.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут. М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр энэ дээр бид анхаарч ажиллахгүй бол эргээд ирэх жуулчдын тоогоо бууруулах эрсдэл байгаа.

Тэгэхээр Ховд, Мөрөн, Чойбалсан, Гурвансайхан, Дэглийцагаан, Өндөр нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд. Энэ нислэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ шинэ нисэх буудал байгуулах ажлыг үнэхээр анхаарч ажилламаар байна.

Хоёрдугаарт, бусад дотоодын нислэгүүдийг нээж өгмөөр байна. Энэ дээр анхаарч ажиллаач гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ аялал жуулчлалтай холбоотой. Жил болгон наадмын нээлтийн билетийн асуудал хөндөгддөг. Бид ч гэсэн өөрсдөө гэр бүлээрээ билет аваад үзье гэхээр билет нь олддоггүй ингээд шагд орчихсон ийм асуудлууд үүсдэг. Одоо яаж байна гэхээр ерөөсөө Улаанбаатар хотод ганц city tour-ын үзэх юм нь өөрөө наадам байдаг.

Тэгэхээр наадам дээр жуулчдын билет нь нээлттэй байдаг, ил тод, шударга билетээ авч чаддаг, захиалгаараа системд оруулаад авч чаддаг.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер. Л.Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Тийм.

Тэгэхээр ер нь бид энэ “Цагаан хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг бүрэн дэмжих учиртай юм билээ. Яагаад гэвэл энэ ноос, ноолуур, арьс ширээ боловсруулж үнэд хүргэхгүйгээс болоод манай хөдөө аж ахуйн салбар аягүй тийм хүнд бэрхшээлтэй байгаад байгаа юм.

Мөн мах, махан бүтээгдэхүүнийхээ био гарлынх нь гэрчилгээг гаргаж чадахгүйгээс болоод манай махны өрсөлдөх чадвар бас явахгүй байгаад байгаа юм.

Уг нь манайх шиг байгалийн шим тэжээлээс идэж байгаа малын мах гэдэг чинь дэлхий дээр хамгийн үнэтэй мах байхгүй юу. Тэгээд үүнийгээ бид нотолж чаддаггүй, эрүүл саруул гэдгийг нь нотолдог тийм системээ угсарч чадаагүйгээс болоод мах маань өрсөлдөх чадвар их сул байна.

Тийм учраас бид нарын яаралтай хийх ажил бол яг малаа нядлахын өмнөх 2 сарын хугацаанд мал нь эрүүл гэдгийг нотлох, дээр нь жоохон тарга тэвээргийг нь нэмэгдүүлэх гэдэг хоёр системийг л угсрахын төлөө бид ажиллана. Ингэж байж манай мах эрүүл.

Тэгээд дээр нь үнэхээр энэ бэлчээрийн мах өөр хаана ч байхгүй учраас асар үнэтэй зарах боломж байна. Монгол мах брэндийг бид гаргахыг зорих хэрэгтэй.

Ноос, ноолуурын тухайд одоо бид Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн учраас айхтар татвар тогтоомж тавиад Хятад руу экспортлох экспортыг зогсооно гээд бас болохгүй юм байна лээ.

Зүгээр нөгөө талдаа юу хийх вэ гэхээр үнэхээр хувийн худалдаагаар цаашаагаа дамжиж байгаагаас нь хэдүүлээ тэр НӨАТ гээд татварыг нь авмаар юм билээ.

Улсын үйлдвэрүүдэд самнаж байгаа, энэ улсын үйлдвэрүүдэд тушааж байгаа ноолуур, ноосоо хэдүүлээ тэр татварыг нь компаниуд нь төлдөг энэ байдлыг нь хадгалаад, ченжүүд рүү явж байгаа урсгал дээр татварын шинэ бодлого гаргаж ирнэ.

Ингэхийн тулд бид гарал үүслийн мөрдөлтийн загварыг гаргая, платформ хийе, dashboard хийе гээд байгаа нь тийм учиртай.

Энэ дээр бид өөрснөө засаг заавал хийхгүй юмаа гэхэд үүнийг хийчихсэн компаниуд байна. Ямар нэгэн барааг эхний оюуны өмчөөс нь эхлээд төгсгөлийн зарж байгаа цэг хүртэлх маршрутыг блокчэйн болгочихсон ийм компани Монголд байна шүү дээ.

Тэгэхээр энэ үйлчилгээг ч гэсэн бид авах тухайд бодох ёстой гэж бодож байгаа. Тэгээд энэ бодлогоо бид нэгдүгээр улиралд багтаагаад Засгийн газарт хүргэх төлөвлөгөөтэй байна.

Аялал жуулчлалын тухайд агаарын тээвэр таны хэлж байгаа үнэн. МИАТ компани өнгөрсөн жил бараг 60 тэрбумын алдагдалтай ажиллав уу, яав. Тэрнийх нь 10 тэрбум төгрөгийн алдагдал бол жишээлбэл хөдөөгийн шугам.

Агаарын тээвэрт хоёр юм байгаа. Бид хувийн хэвшлийг агаарын тээвэрт оруулж ирье гэвэл нэг бол тэр нислэгийнх нь шугамыг тэр улсуудад олон жилээр тогтвортой өгөх. Нэг.

Хоёр дахь нь, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд бид капиталыг хямдруулах. Яагаад гэвэл агаарын.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Бид үндэсний агаарын тээвэртэй байхыг зорих ёстой. Агаарын тээврийг дэмжих зүйл бол урт хугацаатай бага хүүтэй хөрөнгө оруулалт. Тэгэхгүй дэлхий дээр онгоц худалдаж авч байгаа том хөрөнгө оруулагчдын мөнгөний эх үүсвэр нь хасах хүүтэй байгаад байна. Манай эх үүсвэр болохоор 15, 16 хувийн хүүтэй байгаад байна.

Тийм учраас бид энэ агаарын тээвэр өөрөө олон улсын зах зээл гэдэг үндэсний аюулгүй байдалтай холбоотой мөртлөө дэлхийд өрсөлдөж байгааг мартаж болохгүй.

Жишээ нь, Кореа Эйр компанид олдож байгаа мөнгө бол хасах хүүтэй байна. Манай үндэсний агаарын тээврийн компаниудад олдож байгаа мөнгө хөрөнгө оруулалт нэмэх 15 хувийн хүүтэй байна. Энэ зөрүүн дээр энэ компаниуд өрсөлдөх ямар ч боломжгүй байна.

Тэгэхээр энэ дээр бид энэ капиталыг хямдруулах, хөрөнгө оруулалтыг нь хямдруулах дээр бодитой бодлогыг манай Засгийн газар заавал гаргамаар юм байна лээ. Нөгөө талдаа тодорхой шугамыг тодорхой компанид өгөхгүй бол дотоодын нислэгийг.../минут дуусав/

Р.Сэддорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт.

О.Батнайрамдал: Баярлалаа. Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Надад 3 асуулт байгаа юм.

Нэгдүгээрт, Оюу Толгойнтэй холбоотой. 3 долоо хоногийн өмнө та нар мэдээлэл авсан байх л даа. Нэг том шийдвэр гарсан. Entrée Resources. Тийм ээ. Нэг ёсондоо Оюу Толгой дээр Рио Тинтотой хамтран лиценз эзэмшдэг компани

арбитрын шүүх дээр ялсан мэдээ 2024 оны 12 сарын 19-нд олон нийтэд цацагдсан байна.

Тэгэхээр Оюу Толгойгоор дамжуулаад Монголын талын хөрөнгө оруулагчдад нэг ёсондоо материаллаг талаасаа маш ач холбогдолтой нэг тийм шийдвэр гарчихлаа л даа. Оюу Толгойн бүлэг ордыг аваад үзэх юм бол бараг нийт газрын доорх баялгийнх нь 20 хувь нь хамаардаг Оюу Толгой. Rio Tinto, тэгээд Entrée Resources гээд хоёр хамтарсан компанийн эзэмшилд нэг ёсондоо маргаантай байгаа хоёр лиценз дээр яригдаж байгаа.

Тэгэхээр энэ хоёр лиценз буцаад Оюу Толгой руу шилжих, Entrée Resources-той гэрээний харилцаанд орох ийм арбитрын шийдвэр гарчихлаа л даа.

Тэгэхээр Оюу Толгой өөрөө тэр хамтарсан компанийн маргаантай байгаа хоёр лиценз хамаагүй Оюу Толгойн бүлэг орд өөрөө стратегийн ач холбогдол бүхий орд.

Тэгэхээр Монголын тал 34 хувь эзэмшил нэг ёсондоо энэ 20 хувь дээр хэрхэн хаагдах юм? Энэ хоёр нэг ёсондоо арбитрын шүүхийн дагуу энэ шийдвэр хэрвээ Монголын талын оролцоогүйгээр явах юм бол Монголын талын 34 хувь тэр Оюу Толгойн бүлэг ордын 20 хувь хамаарах. Тийм ээ. Газрын доорх баялгийн 20 хувь хамаарах тал дээр Монголын талд яг ямар үр өгөөж тооцогдох нь аягүй ойлгомжгүй болох гээд байна л даа.

Тэгэхээр энэ дээр цаг хугацаа алдалгүй ер нь Монголын тал уг нь Entrée Resources-тэй шууд гэрээнд орох ёстой юм л даа. Нэгэнтээ стратегийн ач холбогдол бүхий орд юм чинь Монголын талд хэрхэн нөлөөлөх вэ?

Хоёрдугаарт, дарга аа, цагаа шууд сунгаад авчихъя. Тийм ээ.

Хоёрдугаарт, таны тайлан дээр нэлээн дурдагдсан байна л даа. Бид олон жил ярилаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бид хэрхэн татах вэ гээд. Тийм ээ.

Тэгэхээр ер нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бид өөрсдөө яваад л энд тэнд форумд оролцож татах гэхээсээ илүүтэйгээр ер нь гадаадын хөрөнгө оруулагчдаар нь өөрсдөөр нь хийлгүүлэх ёстой. Тэгэхийн тулд нэг ёсондоо хоёр арга байгаа юм л даа. Ялангуяа хөрөнгө оруулалтын томоохон сангууд байгаа. Баялгийн сангууд орно. Олон нийтийн эзэмшил, эсвэл хувийн томоохон сангууд орно.

Тэгэхээр тэр сангуудын хөрөнгө оруулалтыг Монголд оруулж ирэх, эсвэл Монголын компаниуд гадаадын хөрөнгийн бирж дээр гарснаараа өөрөө энд далд утгаараа шууд бусаар Монголын хөрөнгө оруулагчдын анхааралд авчрах өөрөө маш том эх сурвалж болдог.

Тэгэхээр ер нь үүнийг өөрөө бараг Засгийн газар хийх нь нэг ёсондоо гадагшаагаа энд тэнд форумд очоод гадаадын хөрөнгө оруулалт татах гэж байна гээд л Засгийн газартай уулзаад явахаас илүү үр дүнтэй байхгүй юу.

Тэгэхээр үүнийг уг нь яг Эрдэнэс Монголын малгай доор гадаадын хөрөнгө оруулалтын банкирууд авчраад стратеги гаргаж байгаад л ер нь 2, 3 орд дээр ч юм уу, эсвэл 2, 3 прожект дээр бид амжилттай хийх юм бол яг Оюу Толгойгоор дамжуулаад Рио Тинто Монголын хөрөнгө оруулалтыг татахад шууд бусаар бол мэдээж томоохон хөрөнгө оруулагчдын анхааралд авчирч чадаж байгаа шүү дээ. Яг л үүнийг л хийх ёстой юм л даа.

Хэрвээ тэгж чадах юм бол бид дахиад гадаадын хөрөнгө оруулагчдын анхааралд Монгол Улс бас нэг ийм алтернатив хөрөнгө оруулах орон байгаа шүү гэдэг анхаарлын төвд авчрах боломж нь нээгдэх байгаа юм.

Тэгэхээр үүнийг л Эрдэнэс Монголын малгай доор хоёр, гуравхан төсөл дээр ч юм уу, эсвэл гадаадын хөрөнгийн бирж дээр Монголоос ямар компаниудыг бид гаргаж болох юм. МИАТ ч юм уу, эсвэл цаашдаа Оюу Толгой ч юм уу. Одоо нүүрсний компани гарахад хүнд байх л даа.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Тэгэхээр бид нарын дараагийн шийдлийг хүлээж байгаа асуудал бол энэ газрын тосны CNPC /China National Petroleum Corporation/ буюу “Петро Чайна”-тай хийх маргааныг шийдэх шийдэл байгаа.

Нөгөөдөх нь Оюу Толгойн татварын маргаан байгаа. Энэ хоёрыг бид заавал шийдэх хэрэгтэй.

Яагаад гэвэл хоёуланг нь бид хулхидчихсан юм билээ л дээ. Гэрээ хийж байх үеийнх нь хууль эрх зүйн орчныг хадгалахгүйгээр гэрээ хийсний дараа хууль эрх зүйгээ өөрсдөө сольчихсон. Тэгээд гэрээ хийснийхээ дараа бид өөр байдлаар асуудалд хандана гээд шийдчихээд. Одоо манай хуулийг дагах гэхээр энэ монгол хүний нэг тийм хулхи, төрөлхийн нэг тийм хулхи хүмүүс байна гэдэг ийм мессеж ингээд дэлхий даяар хөрөнгө оруулагч нарт хавтгаад явчихсан. Үүнийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тийм учраас бид гадаадын хөрөнгө оруулалтын хуультай цуг энэ хоёрын асуудлыг оруулж ирнэ ээ.

Гэхдээ бид хоёр тодорхой шийдэлтэй байгаа юм. Хууль эргэж үйлчилдэггүй байх. Нөгөө талдаа Монголын заавал андгай буй за. Тийм. Өнөөдөр яг ямар хууль эрх зүйн орчинд гэрээ хийсэн, үүнийг тухайн бизнесийг тэр хэмжээнд нь мөрддөг байхаар бид зааж өгөхгүй бол болохгүй юм билээ. Тэгэхгүй бол хуулиа солиод татварын байцаагчдыг байдалд оруулдаг. Хуулиа солиод компаниудыг өрөнд оруулдаг. Ийм л зүйл энэ хоёр дээр байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хүрээнд тэр Entrée-гийн лиценз бүх юм нь цаашаа шийдэгдэнэ ээ. Rio гэдэг компанитай бид цаашдаа сайн түнш байх уу, яах вэ гэдгээс Монголын хөрөнгө оруулалт хамаарна шүү дээ. Нэг асуудлаа бүрэн шийдээгүй байж дараагийн юм ярихад их төвөгтэй байгаад байгаа юм.

О.Батнайрамдал гишүүнтэй санал нэг байна. Дараагийн төсөл рүүгээ ор, хөрөнгө оруулалт тат, эсвэл олон улсын зах дээр гарга гэж.

Бид 2025 онд гаднын зах дээрээс мөнгө бол босгочихно. Түүнд санаа зовох юм алга. Ялангуяа бид одоо энэ кокс химийн үйлдвэр, нүүрс химийн үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэр дээрээ хөрөнгөө босгочихъё. Асгатын мөнгөний ордын хайгуул ч гэдэг юм уу. Тийм ээ.

Нөгөө талдаа яг бодитойгоор гаднын зах дээр гараад амжилтад хүрэх компани алга байна. Жишээлбэл, Хармагтай гэхэд өөрөө хөрөнгө оруулагчаа гаднын зах дээрээс биш тодорхой компанийн хөрөнгө оруулалтыг шууд татахаар төлөвлөлт хийгээд явж байна л даа.

Тийм учраас Оюу Толгойн асуудал хэрхэн шийдэгдэх вэ гэдгээс ер нь ирээдүйд их олон юм шийдэгдэнэ. Олон юм шийдэгдэнэ.

Өнөөдөр бид ураны ордоо олборлох шийдвэр олон улсад маш сайн дохио өгч байгаа. Эд нар хөдлөх юм байна. Ямар ч байсан энэ хүмүүс дэлхийтэй хамтарч ажиллах бэлтгэлээ базаачихсан юм байна. Урагшаа алхах юм байна гэсэн ийм дохио өгч байгаа учраас бид дараа дараагийн уурхайн төслүүд дээрээ санаа зовохгүй байна.

Оюу Толгойг хэдүүлээ багцаар нь ярья л гэж хэлмээр байна.

Р.Сэддорж: Тодруулах уу? Нэмж хариулах шаардлагатай учраас 1 минут.

О.Батнайрамдал: Л.Гантөмөр сайд аа,

Ер нь бид асуудлаа шийдчихээд гадагшаагаа гарья ч юм уу, дараагийн төслөө ярья, Оюу Толгойгоо шийдчихээд гэх юм бол хэзээ ч дуусахгүй шүү дээ.

Тэгэхээр зөвхөн Оюу Толгой шийдчих юм бол гадаадын хөрөнгө оруулалт орно гэдэг гэж ойлгох юм бол дэндүү явцуу л даа. Энэ дандаа л байнга үргэлжилж байх ёстой процесс. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулалт татахыг яг үнэнийг хэлэхэд бид одоо шал ондоо өнцгөөс хармаар байна гэж хэлэх гээд байгаа юм.

Хуулиа өөрчлөх юм бол, эсвэл Оюу Толгойгоо шийдэх юм бол, ингэх юм бол гадаадын хөрөнгө оруулалт орж ирнэ гэж.

Яг үнэнийг хэлэхэд гадаадад очих юм бол Монгол Улс хөрөнгө оруулагчдын толгойд нь ч юм уу, эксел дээр нь ч юм уу, байгаа орнуудын тоонд байдаггүй байхгүй юу. Байхгүй. Монголыг сайн мэдэхгүй шүү дээ.

Тэгэхээр тэрийг таниулах нь бараг Засгийн газар энд тэнд очиж ингэж нэг ёсондоо форумд оролцохоосоо илүүтэйгээр хөрөнгө оруулагч өөрсдөө тэрийг нь хийж өгдөг байхгүй юу.

Тэгэхээр үүнийг л бид нээж өгөхийн тулд яг тэр хөрөнгө оруулагчдаа нэг юм уу, хоёр.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер хариулъя.

Л.Гантөмөр: О.Батнайрамдал чиний ярьж байгааг ойлгож байгаа шүү дээ. Чи бол стратегийн хөрөнгө оруулалт ярьж байгаа байхгүй юу. Би ойлгож байна.

Стратегийн хөрөнгө оруулалт руу хөрөнгө оруулагчид шилжиж байгаа. Тэр том хөрөнгө оруулалт яриад байхгүй юу. Гэхдээ бид нарын хувьд юу ярьж байна вэ гэхээр Монгол Улсад ер нь гадаад хүн ирж бизнес хийж болох уу, амьдарч болох уу, хэдүүлхнээ ингээд нэг энэ жалган дотор амьдарч байгаа амьдралдаа гаднын хүнгүйгээр амьдардаг ийм бараг хууль эрх зүйтэй байгаад байна шүү дээ. Үүнийг яаж өөрчлөх юм бэ гэдэг асуудал.

Энэ хоёр цаагуураа нэг мөртлөө яг амьдрал дээр болохоор зэрэг энгийн бизнес эрхлэгчид байгаа байхгүй юу. Монголд очоод нэг дэлгүүр нээчихье. Байгаа шүү дээ. Нэг гуанз хийчихье, нэг аялал жуулчлалын нэг жижигхэн зочид буудал барьчихъя. Хар мянгаараа байгаа шүү дээ.

Тэр улсууд Монголд ирж ажиллаж амьдрах хөрөнгө.../минут дуусав/

Р.Сэддорж: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна.

П.Батчимэг: Надад гурван асуулт байна.

Өнөөдөр Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлсэн асуудлын нэг нь “Орано Майнинг” компани Монгол Улсын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх Улсын Их Хурлын тогтоол орж ирсэн. Тэгээд Н.Учрал сайдад танилцууллаа.

Миний нэг сонирхсон асуудал Эдийн засаг, хөгжлийн яам Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол гол энэ том том мега төслүүдийг хөдөлгөх ганц яам. Тэр утгаараа өнөөдрийн “Орано майнинг” компанийн оруулж ирж байгаа гэрээний төсөл дээр танай яам яг ямар үүрэг рольтой оролцсон бэ?

Яагаад гэвэл би үүнийг сая уншиж судлах явцдаа хэд хэдэн зүйлийг анхаарч үзсэн.

Нэгдүгээрт, ер нь цацраг идэвхт бодис, түүнтэй холбоотой ашигт малтмалын хайгуул, одоо тэр олборлох, хадгалах, борлуулах энэ үйл явцад үүсэх, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын талаас үүсэх эрсдэл, байгалийн эрсдэл, байгаль орчинд сүйтгэгдэх, хүн, мал түүний эрүүл мэндэд учрах хор хөнөөл гээд л олон олон хүчин зүйлсүүдийг хамруулж даатгалын систем үйлчилдэг тийм гадаад орнуудын маш сайн туршлагауд байгаа юм.

Тэгвэл өнөөдрийн хөрөнгө оруулалтын гэрээн дээр ер нь энэ даатгалын асуудлыг танай яамнаас ер нь харсан зүйл байна уу, олон улсын жишиг туршлагыг харж үзсэн үү. Ер нь даатгагддаг тийм сайн туршлагауд байна л даа. Тийм ээ.

Дараагийн асуудал нь, төсөл хэрэгжүүлэгч талаас 10 гишүүн гэж байгаа юм. Компанийн тухай хуулиар чинь төлөөлөн удирдах зөвлөл 9 буюу түүнээс дээш гишүүнчлэл. Түүнийг дагаад өнөөдөр энэ гэрээний төсөл дээр 10 гишүүнтэй. Түүнийг ганцхан төсөл хэрэгжүүлэгч тал нь нэгхэн төлөөлөлтэй байна гэсэн байгаа юм. Энэ бол миний хувьд үнэхээр ядмаг, маш бага тоо гэж үзэж байгаа.

Энд улс эх орны эрх ашиг нэгдүгээрт байх ёстой. Ядаж доор хаяж 3 гишүүнтэй байж түүнийг дагасан Компанийн тухай хуулиар хараат бус гишүүд хүртэл орж ирэх ёстой. 3-д 1 гээд. Тийм ээ.

Тэгэхээр үүнийг манайх яагаад нэг гэдэг ийм төлөөллийг заавал тэнд байлцуулсан бэ? Үүнийг дагасан муу үр дагаврууд энд хяналт үйл ажиллагааг хянах хяналт сул болно. Дээр нь тэр хэрэгжүүлэгч талын, төслийн талын удирдлагыг хянахад хүртэл тэр сул талууд үүсэж ирнэ. Бид ямар ч хяналтгүй. Нэгхэн төлөөлөлтэй гэдэг утгаар нь. Би тэгж харж байгаа юм.

Тэгэхээр үүнийг өөрчлөх. Дараа нь.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут. П.Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Байнгын хороогоор орох байх. Маргааш. Тэгээд Их Хурлаар оруулж ирэх байх.

Маш яаравчилсан, түргэвчилсэн ийм байдлаар энэ хөрөнгө оруулалтын гэрээг оруулж ирнэ гэдэг нь Монгол Улсын төр, Засгийн газар маш хариуцлагагүй байна гэж үзэх тийм нэг талтай байгаа. Төр нь өөрөө ийм сул, ийм хариуцлагагүй энэ гэрээн дээр хандах юм бол энэ цаашдаа дахиад л Оюу Толгойн үргэлжлэл болж хувирна л гэсэн үг. Ийм л утга агуулагдаж байгаа.

Тийм учраас би өнөөдөр хоёр, гурван асуудал, зарчмын зөрүүтэй санал оруулж ирлээ. Тэгэхдээ манай өнөөдөр Байнгын хорооны эрхлэх ажлын хүрээнд яг тухайн асуудал орж ирээгүй. Маргааш Аюулгүй байдлын байнгын хороогоор оруулж Та энэ дээрээс санал аваарай л гэж хэлсэн.

Гэхдээ би энэ асуудлынх нь талаар Та бүхнээс бас хөндье гэж бодлоо.

Дараагийн асуудал нь, ер нь төр, хувийн хэвшлийг дэмжинэ. Төрийн бүтэц өнөөдөр ийм данхар болсон нөхцөлд, төр томорчихсон нөхцөлд хувийн хэвшилд.../минут дуусав/

Р.Сэддорж: П.Батчимэг гишүүн хариултаа авчхаад дараа нь. Хариулт Л.Гантөмөр сайд. 3 номер.

Л.Гантөмөр: Тийм. Эдийн засаг, хөгжлийн яам уул уурхайн бүтээгдэхүүний өгөөжийн 51 хувь нь Монгол Улсад оногдоно гэдэг энэ тооцоолол дээр сууж байгаа юм. Ямар ч байсан энэ төслийн өгөөжийн 51 хувь Монгол Улсад ирэх юм.

Тэгэхгүй бол одоо жишээлбэл нэг сүү үйлдвэрлэдэг компанийн өгөөжийн 51 хувь Монголд ирэхгүй шүү дээ. Хувцас хийдэг компанийн өгөөж ч ирэхгүй. Энэ бол Үндсэн хуулиараа өгөөжийнхөө 51 хувийг Монгол Улсад өгч байгаа юм. Энэ тооцоолол дээр манайхан суусан. Энэ тооцоололдоо эзэн болж байгаа. Нэг үгээр хэлбэл бидэнд ашигтай гэсэн үг.

Оюу Толгойг өнөөдөр муугийн жишээ болгож их олон хүн ярьсан.

Ер нь Оюу Толгой яваагүй бол Монголын эдийн засаг гэж байхгүй шүү дээ. Хэн байх юм, юу байх юм. Тавантолгойг их муу гэж ярьдаг. Тавантолгой яваагүй бол Монголын эдийн засаг гэж байхгүй. Ядуу.

Тийм учраас Оюу Толгойг юм болгоны муугийн жишээ болгож болохгүй. Оюу Толгой дээр яагаад 3 ТУЗ-ийн гишүүнтэй вэ гэхээр бид 34 хувьтай. Энэ төсөл дээр яагаад нэг ТУЗ-ийн гишүүнтэй вэ гэхээр бид 10 хувьтай. Ялгаа нь нэг ТУЗ-ийн гишүүн өөрөө хориг тавих эрхтэй. Гарч байгаа шийдвэр дээр хориг тавих бүрэн эрхтэй. Алтан хувьцаатай гэсэн үг.

Тийм учраас компанийн ТУЗ-ийн шийдвэр Монголын Засгийн газрын оролцоотой гарна. Энд эргэлзэж тээнэгэлзэх зүйл байхгүй.

Нөгөө талаасаа бид энэ төслийг заавал явуулна. Үүнийг явуулах гэж хамтарсан Засгийн газар байгуулсан юм. Өмнө нь гадна, дотнын бүтэн явуулгатайгаар энэ төслийг байнга унагаж байсан. Айдсаар тоглодог. Мал, амьтан, байгаль орчинд хортой. Тэгээд бусад улсууд яаж ашиглаж болоод байгаа юм. Монголчууд тийм ядуу юм уу, тийм ухаан муутай юм уу, тийм дорой юм уу, тийм боловсролгүй болчихоод байгаа юм уу. Монголчууд Казахстанас юугаараа ялгаатай юм. Яагаад Казахстанд ашиглаж болоод Монголд ашиглаж болдоггүй юм бэ.

Тийм учраас энэ ажил явна. Энэ ажлыг явах хугацаанд Монголын шинжлэх ухаан ч гэсэн илүү хөл дээрээ зогсоно. Одоо энэ Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч хажууд сууж байна. Энэ хүмүүс итгэлтэй байгаа. Физик, технологийн

хүрээлэнгийнхэн итгэлтэй байгаа. Цөмийн физикчид Монголд зөндөө байна. Уран гэдэг юмны учрыг олдог хүмүүс байна. Бид монголчууд тэр хүмүүст үл итгэдэг. Гаднынханд итгэдэг. Казак хөгжилтэй учраас чадаж байна. Монгол ядуу болохоороо чадахгүй. Тийм юм байхгүй. Хийнэ.

Зогсооно гэж байгаа нь өөрөө ураныг их айхтар муухайгаар харагдуулж, засаг төрийг хямраадаг л бодлого.

Р.Сэддорж: П.Батчимэг гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж байна. 1 минут.

П.Батчимэг: Хариулт бол авлаа. Тийм.

Гэхдээ ер нь би сая хэлээд байгаа. Тэр даатгалын тогтолцоо гэдэг тэр нэг зүйл, заалт оруулж өгч болохгүй юм уу л гээд байгаа байхгүй юу. Одоо энэ цацраг идэвхт бодис, түүнийг олборлох, ашиглах, боловсруулах, зөөх, тээвэрлэх гээд л өчнөөн олон деталь ажлууд байгаа. Түүний үр дагавар нь, учирч болох тэр эрсдэлүүдийг яаж бид тэр төсөл хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч компаниас татаж авах юм бэ гэдэг асуудал сүүлдээ ямар нэгэн эрсдэл үүсэхэд энэ даатгалын тогтолцоо гэдэг юмыг бас оруулж өгвөл зүгээр юм л гэдэг л санал хэлээд байгаа юм л даа.

Өөр юмгүй дээ. Асуудал боллоо.

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд. 3 номер.

Л.Гантөмөр: Даатгалтай холбоотой П.Батчимэг гишүүний саналыг дэмжиж байна.

Бид хүнээ ч даатгана, малаа ч даатгана. Байгаль орчноо ч даатгах ёстой. Жишээлбэл, одоо нөхөн сэргээлтийн зардлыг бид урьдчилаад дансандаа авчхаж байгаа юм. Энэ бол байгаль орчны байгаль хамгаалалтын даатгал гэж ойлгох хэрэгтэй. Энэ дансанд авсан мөнгөө бид тодорхой хэмжээгээр арвижуулаад арвижуулсан хувьдаа таарсан байгаль орчны олон улсын хэмжээний даатгалд орж бас болно. Асуудал байхгүй.

Тэгэхээр манай Засгийн газар өөрөө, бид өөрөө юу хүсэж байна тэрийгээ хийгээд явах бүрэн бүрэн боломжтой шүү. Гишүүн ээ.

Тэгэхээр би таны саналыг ажил хэрэгчээр цаашаага ажил болгохын төлөө ажиллана. Баярлалаа.

Р.Сэддорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Ингээд танилцуулга хийсэн Эдийн засаг, хөгжлийн яамныхандаа баярлалаа.

Монгол Улсын хөгжлийн бодлого, тэр дундаа эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогыг танилцуулж байна. Тэгээд эрчим хүчний дутагдлаас гаргана, ногооруулна, эрчим хүч экспортлог болно гээд маш сайхан тийм уриа лоозонгуудыг ярьж байна гэж харж байна.

Тэгэхээр хамгийн гол нь энэ уриа лоозон, энэ одоо зорилго зорилтод хүрэхийн тулд яг ямар нарийвчилсан төлөвлөгөө гаргасан юм бэ? Ямар ажлуудыг хийж байж энэ хэлээд байгаа, яриад байгаа энэ лоознууддаа, зорилгууддаа хүрэх гээд байгаа юм бэ? Тэрийгээ ямар хэмжүүрээр хэмжих гээд байгаа юм. Та бүхэн. Ямар хэмжүүрээр хэмжээд тэр зорилгодоо хүрчээ гэж өөрсдийгөө дүгнэх гээд байгаа юм бэ?

Хэдэн жил өмнө нь хэрэгжүүлж эхлүүлсэн жишээ нь Эрдэнэбүрэн, 10 аймгийн дулааны станц гээд бүр аль хэдэн жилийн өмнө эхлүүлсэн төслүүдээ ярьчихаад л эрчим хүчний салбарт ийм юм хийж байгаа гээд л ингээд яриад байдаг.

Тэгэхээр энэ чинь та бүхний тэр зорилго чинь хүргэх юм уу?

Тэгэхээр эрчим хүчтэй холбоотой нэг ийм тодорхой гурван асуултыг асууя. Тэгээд та бүхэн маш анхааралтай сонсож байгаад тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсье.

Нэгдүгээр асуудал нь, 2025 оны Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрт эрчим хүчний салбарыг хөгжүүлэх нийтдээ 35 төрлийн ажил суусан. Энэ ажлаас ердөө 10 ажил л улсын төсөвт суусан. Ингээд нийлээд бусад гаднын зээл, тусламжаар гээд 17 ажил нь буюу 49 хувийн ажил нь хөрөнгө оруулалт нь тодорхой байгаа. Гэтэл 18 ажил нь хөрөнгө оруулалт нь тодорхойгүй. Хэзээ яаж хэрэгжүүлэх гээд байгаа юм? 2025 онд.

Тэгээд 2025 оныхоо хөгжлийн төлөвлөгөө дээр суулгасан хөтөлбөрүүдийнхээ санхүүжилтийг олоогүй, нарийвчилсан төлөвлөгөө байхгүй байж яаж энэ бүх ажлуудыг бид хийнэ, хэрэгжүүлнэ, итгээрэй гэж хэлээд байгааг би ойлгохгүй байна л даа.

Жишээ нь, Дулааны цахилгаан станц-4-ийг 500 тонн цагаар өргөтгөх гээд л төсөл байж байгаа. Байдрагийн усан цахилгаан станц гээд л байж байгаа. Төвийн бүс 100 мегаваттын ус хуримтлуурын усан цахилгаан станц гээд л. Тэгээд маш олон шугамуудыг барина гэсэн юм 2025 оны хөгжлийн хөтөлбөрт байгаа. Гэхдээ одоогоор санхүүжилт байхгүй.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн хариу өгөөч ээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр мөн эрчим хүчтэй холбоотой маш олон ажлууд суусан.

Тэгэхээр энэ суусан ажлууд дээр Та бүхэн ямар санхүүжилтээр хэзээ хэрэгжүүлэх гээд байгаа юм, ямар нарийвчилсан төлөвлөгөө гаргачихсан ажиллаж байгаа юм бэ?

Тухайлбал, 10 мянган айлын нарны дээврийн төсөл гээд л байж байгаа. Эрчим хүч экспортолно. 3 мянган мегаваттын эх үүсвэр барина, нар салхины эх үүсвэр барина л гэж байгаа.

Тэгээд 14 мега төслийн хүрээнд баахан тархмал эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүч гээд биччихсэн байгаа. Тэгвэл яг энэ хүрээнд яг ямар тодорхой ажлуудыг хэрэгжүүлэхээр Та бүхэн төлөвлөгөөндөө тусгаад яваад байгаа юм.

Мөн Мөрөн, Даланзадгад.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут М.Энхцэцэг гишүүнд.

М.Энхцэцэг: Мөн аймгийн төвүүдэд дулааны цахилгаан станцуудыг дунд оврын, одоо 50-иас 70 мегаваттын дулааны цахилгаан станцуудыг барьж байгуулна гээд бас хөтөлбөрт суулгасан. Мөрөн дээр байж байна. Даланзадгад, Сэлэнгэ, Сүхбаатар гээд.

Тэгэхээр үүнийг Та бүхэн яг ямар санхүүжилтээр хэзээ хэрэгжүүлэх гэж байгаа юм бэ? Тэр нарийвчилсан төлөвлөгөөг чинь сонсмоор байна.

Дараагийн нэг чухал юм Тавантолгойн дулааны цахилгаан станцтай холбоотой.

Тэгэхээр энэ тендерийн материалыг хэзээ бэлэн болгох гэж байгаа юм. Санхүүжилтийн хувилбаруудыг боловсруулаад танилцуулна гэж байна.

Тэгэхээр яг хэзээ танилцуулах юм? Манай Байнгын хороо танилцуулах юм уу? Өмнөх тендерийн хувьд санхүүжилтийн загвар нь буруу байсан. EPC_[Energy Performance Certificate] дээр нэмэх нь “А”_[хамгийн үр ашигтай] /**EPC ratings of A**/ гэсэн хэлбэрээр энэ төслөө зарласан.

Тэгэхээр Та бүхэн мэдэж байгаа. Дэлхий дээр нүүрсний станцад санхүүжилт олоход тун хүнд.

Тэгэхээр энэ нөхцөлөөр зарлахаар чинь орж ирэх хүмүүсийн тоо цөөхөн болно, өрсөлдөөн байхгүй болно. Эцсийн дүндээ хөрөнгө оруулалтыг өсгөж байгаа.

Тэгэхээр энэ хувилбарууд чинь хэзээ орж ирээд хэзээ тендерээ зарлах юм бэ? Үүнийг бас яг тодорхой хариулт өгөөч гэж ингэж хүсэж байна.

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд хариулъя. 3 номер.

Л.Гантөмөр: Бид янз бүрээр чичлэгдэж байгаад гадаад зээлийнхээ хэмжээг нэмэгдүүлсэн шүү дээ. М.Энхцэцэг гишүүн ээ.

Тэгээд тэр гаднаас авч байгаа зээл, тусламжийн ихэнхийг нь эрчим хүчний салбарт өгснийг Та мэдэж байгаа.

Тэгээд тэр байгаа жоохон мөнгийг бүгдийг нь авчихсан хүмүүс чамлаад суугаад байхаар бусад салбар одоо яах вэ. Өнөөдөр 149 төсөл дотор 44 төсөл нь эрчим хүчний төсөл байна гэж байгаа. 4 жилд хэрэгжүүлэх юм. Үүний өнөөдөр 25 нь шийдэгдээд явж байна. Одоо бид бас нэг хийсэн ажилдаа сэтгэл ханах хэрэгтэй шүү дээ.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг 10 жил ярьсан. Бид мэдэж байгаа. Гэхдээ Хятадын Засгийн газар мөнгийг нь өгөхөө больчихсон байсан шүү дээ. Өгөхгүй байсан шүү дээ. Шанхайд Ерөнхий сайд бид хамт очиж уулзаж байж, улс төрийн шийдэлд хүрч байж авсан шүү дээ. Тэгээд үүнийг одоо юу гэх юм. Бид ажил хийсэн гэхгүй юм уу.

Бид нэг урагшаа алхчхаад алхсан алхалтдаа ингээд зөв байна. Эрчим хүчний үнийг нэмлээ шүү дээ. Хараалгаж байгаад. 8 жил хөдөлгөөгүй шүү дээ. Тэгээд энэ алхам биш юм уу.

Улаанбаатар хотод дулааны станцууд баригдана. Ашигтай ажиллах боломжийг нь бүрдүүлээд өгчихлөө шүү дээ. Тэгээд энэ ажил биш юм уу. Одоо жишээлбэл дулааны станцыг бид барина. Итгэ гэж байгаа нь дулааны эх үүсвэрийг хийдэг компаниуд ашигтай ажиллах боломж бүрдсэн учраас бид гаднын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулагчдын хамтарсан хөрөнгө оруулалтаар энэ асуудлуудыг шийдэх гэж байгаа юм. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийднэ.

Бүх эрчим хүчний эх үүсвэрийг төр ганцаараа хийнэ гэдэг үзэл санаанаас холдож байгаа. Реформ гэж үүнийг хэлж байгаа. Эрчим хүчээ үйлдвэрлэдэг хүмүүс нь олон хөрөнгийн эх үүсвэртэй байя. Ийм шийдвэр гарчихсан шүү дээ.

Тийм учраас энэ хүрээнд таны хүсээд байгаа тодорхойгүй гэж байгаа 18 төсөл ажил хэрэг болоод явчихна. Түүнд би санаа зовохгүй байгаа. Яагаад гэвэл Б.Чойжилсүрэнд энэ чиглэлээр чиглэлийг нь өгчихсөн, даалгавар өгчихсөн. Жишээлбэл, 400 мегаваттыг эхний улиралдаа багтаагаад урагшаа явуул гээд Б.Чойжилсүрэнд үүрэг өгчихсөн. Юунаас болоод дампууруулснаа мэдэж байгаа. Тэр сайд. Өнөөдөр үүнийг хэрхэн ажил хэрэг болгохоо бас мэдэж байгаа.

Тийм учраас бид цаг хугацаатай уралдаад хийнэ. 10 мянган айлын сэргээгдэх эрчим хүчээр хангах эх үүсвэр шийдэгдчихсэн байгаа.

Бид Хөгжлийн банкныхаа дэргэд Ногоон санхүүжилтийн корпорац байгуулсан. Энэ корпорацын санхүүжилтийн ихэнх нь айлуудын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих санхүүжилт, хөрөнгө оруулалт нь.../минут дуусав/

Р.Сэддорж: Л.Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Аймгуудын дулааны станцуудыг ч гэсэн бид дандаа хувийн хөрөнгө оруулалтаар шийднэ. Жишээлбэл, Даланзадгад.

Өмнөговь аймгийнхан бид орон нутгийн төсвөөрөө эхлүүлье гээд байгаа. Бидний өгч байгаа зөвлөмж та нар төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийчих. Ямар ч асуудал гарахгүй болох юм билээ. Гэх мэтчилэн бид ингээд хийгээд явна.

Тэгэхгүй бол зүгээр мөнгө нь бэлэн, тендер гэхээр нэг арын хаалганы компаниуд орж ирээд.

Одоо тэр Солонгосын зээлээр хэрэгжиж байгаа төслүүд чинь ихэнх нь уначихсан. Одоо баахан тийм ажил хийж чаддаггүй нөхдүүд шалгаруулчихсан. Тэд нар нь ажлаа хийдэггүй. Төслийн үнэ өсдөг ийм зарчимгүй юм их байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг арилгаад аль болохоор эх үүсвэр талаа хувийн хэвшлийн хөрөнгийг дайчилъя хэдүүлээ гэж байгаа юм. Гишүүн ээ. Таны барьж байгаа зарчим.

Нөгөө талдаа түгээхээ ч гэсэн бид хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дайчилж хийх учиртай юм билээ. Ингэж байж бид яг энэ эрчим хүчний цогц шинэчлэл.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж 1 минут М.Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам яг ийм байр суурь барьж байгаа нөхцөлд бол эрчим хүчний салбар дутагдлаас гарах, дамжуулах, түгээх сүлжээ хэт ачаалагдсан байдлаасаа гарах гэдэг ойлголт байхгүй юм байна гэж харж байна л даа.

Яагаад вэ гэхээр би тодорхой юм асуусан шүү дээ. Энэ олон төслүүдээс хөрөнгө оруулалт нь ихэнх нь шийдэгдээгүй байна. Төр, хувийн хэвшил гаднын зээл, тусламж гэхээр ер нь бүтэх магадлал маш удаан байдаг.

Тэгэхээр ийм удаан байгаа нөхцөлд яаж бид шугамаа барьж чадах юм, яаж эх үүсвэрүүдээ барьж чадах юм. Одоо тэр Тавантолгойн дулааны цахилгаан станцын тендер зарлахдаа бас л яг тэр шүү дээ. Чи дэлхийн зах зээлээс хөрөнгөө оруулж ир ээ. Хувийн хүмүүсийг тэгж байгаа шүү дээ.

Тэгэхээр олж ирэх хүмүүс цөөхөн учраас хэдхэн хүн орж байгаа. Өрсөлдөөн байхгүй болчхож байгаа. Хөрөнгө оруулалт өсчөж байгаа.

Тийм учраас эхний ээлжүүдэд боломжоороо Монгол Улс тэр бондоо гаргана уу, тэр баялгийн сангаасаа санхүүжүүлнэ үү, тодорхой хэмжээний эх үүсвэрүүдээ.../минут дуусав/

Р.Сэддорж: Тэргүүн Шадар сайд 3 номер.

Л.Гантөмөр: Жишээлбэл, ингэж байгаа юм. Хот надад юу танилцуулж байгаа вэ гэхээр II станцын суурин дээр 300 мегаваттын дулааны станц хийж болж байна. Энэ 900 сая доллар болох юм байна. Үүний 80 хувийг санхүүжүүлэх Хятадын хөрөнгө оруулагч бэлэн байна. 20 хувийг нь би санхүүжүүлэе. 200 сая доллар. Энд зориулсан мөнгийг бэлдэж өгөөч ээ гэж байгаа юм. Гэх мэтчилэн бид хувийн хэвшилд мөнгө дайчилж болж байгаа. Гишүүн ээ.

Та төсвөө баталчихсан. Одоо бид нар яг ингээд төсөв баталчхаад тэгээд ажил явахгүй юм байна. Одоо хэдүүлээ. Үгүй тэгээд бид нарын баталсан төсвийн хүрээнд л ажлаа хийнэ шүү дээ. Дээр нь хувийн хөрөнгө л дайчилна шүү дээ. Одоо өөр ямар гарц байх юм.

Тийм учраас жишээ нь Тавантолгойн цахилгаан станц бол 2 компани өрсөлдсөн. Хоорондоо маргалдсаар байгаад л ажил нь явахгүй байгаа шүү дээ. Түүнээс нэг хийхгүй хүн олддохгүйдээ биш. Хийх хүн олдсон. 2 болчхоод байгаа байхгүй юу. 2 компани хийе гээд байна. Тэгээд хоорондоо шүүхдээд байна. Гишүүн ээ.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээлэлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд нэрээ өгье. М.Энхцэцэг гишүүнээр тасаллаа. М.Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Тэгэхээр 2025 оны хөгжлийн хөтөлбөр, дээрээс нь хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр байгаа ажлууд гэдэг бол яг бодит бид ард түмэндээ энэ ажлыг би хийж өгнө гээд амлалчихсан ажлууд.

Тэгэхээр би энэ 2 хөтөлбөрийг хариуцдаг яамны хувьд би Та бүхнээс юу хүсэж байгаа вэ гэхээр бид бүхэн, ер нь ард түмэн ч хүсэж байгаа байх.

Тэгэхээр яг тэр ажлуудыг хэрэгжүүлэхийн тулд Та бүхэн ямар нарийвчилсан төлөвлөгөө. Энэ ажлыг хийхийн тулд бид ийм ийм ажлууд хийж байж энэ ажил одоо ажил хэрэг болгоно гэсэн тийм нарийвчилсан төлөвлөгөөгөө гаргаж харуулаач ээ гэж хүсэж байгаа юм.

Тэр нарийвчилсан төлөвлөгөө дээрээ ямар санхүүжилтээр, яг хэзээ, ямар хугацаанд хэрэгжүүлэх юм. Дээрээс нь яг энэ ажил хэрэгжүүлснээрээ бид одоо байгаа үзүүлэлт маань ямар хэмжээгээр өсчих юм. Яагаад гэвэл бид ингээд нэг ийм уриа лоозон яриад байгаа байхгүй юу. Өө эх үүсвэрийн дутагдлаас гаргана. Одоо ингээд ногоон болгоно. Эрчим хүч экспортолно гээд. Тэгвэл одоо эрчим хүч экспортлохын тулд нэг ийм лоозон хэлчхэж байгаа байхгүй юу. Тэгвэл энэ лоозонгийн хүрээнд бид яг ямар ямар ажлуудыг хэзээ, хэзээ хийх юм гэдэг ийм нарийвчилсан төлөвлөгөө гаргаж байж өнөөдөр тэр чинь ажил хэрэг болдоггүй юм уу л гэж хэлээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр тийм юм хийгээд тэгээд тэрийгээ танилцуулаад яваач ээ. Одоо энэ дээр ингээд санхүүжилт олчихсон, эсвэл олоогүй, үүнийг олохын тулд бид 6 сар гэхэд олох юм байгаа юм. Тавантолгойн тендер гэдэг чинь юу гэдэг юм тэр тендерийн материал шинэчилж боловсруулна л гэж байна. Тэгэх юм бол тэрийг бид одоо 1 сарын төгсгөл гэхэд боловсруулчихна. Тэр санхүүгийн загварыг одоо 2 сарын 15 гэхэд загвараа ингээд эцэслэчихнэ ч гэдэг юм уу. Яг ийм хугацаатай ийм төлөвлөгөө, бодитой төлөвлөгөө бид нарт харуулаач ээ л гэж хэлээд байгаа байхгүй юу.

Түүнээс биш одоо ингээд нэг хэдэн баахан лоозон. Угаасаа хэн ч итгэхийн аргагүй шүү дээ. 38 төслийг 2025 оны төлөвлөгөө дээрээ, хөгжлийн төлөвлөгөө дээрээ 38 төслийг эрчим хүчний салбарт хэрэгжүүлнэ.

Өнөөдөр чинь 2025 он чинь аль хэдийн эхэлчихсэн шүү дээ. Гэтэл эхэлчихсэн юман дээр яг тэр дээр үсрээд л 17 төсөл нь л нэг санхүүжилт нь шийдэгдсэн байгаа юм. 18 нь бүүр сураг ч үгүй. Тэгээд тэр 18 дээр л та бүхэн бид нарт ингээд бодит юм хэлээч ээ л гэж байгаа байхгүй юу.

Тэгвэл одоо ТЭЦ-IV-ийг 500 тонн цагаар өргөтгөх төсөл бол үүнийг чинь бид одоо 2026 оны төсөв дээр суулгана. Эсвэл үүнийг чинь бид ингэж зээлээр хэрэгжүүлэх гэж байгаа ийм ийм юутай гээд. Тэр болгонд, ажил болгон дээр л тэр төлөвлөгөөгөө бид танилцуулаач ээ гэж хэлж байгаа юм.

Хоёрдугаар асуудал нь, яг энэ ажлуудыг үндсэн гүйцэтгэгч нь, үндсэн хариуцагч нь Эрчим хүчний яам гээд тавьчихсан. Тэгээд яс юман дээрээ болохоор яг Эрчим хүчний яам бол ямар ч эрх мэдэл байхгүй. Тэр гол санхүүжилтийг нь олдог нь танай яам байгаа юм.

Тийм учраас энэ төслүүдийг хэрэгжүүлэгч үндсэн хариуцагч нь танай Эдийн засаг, хөгжлийн яам гэж тавиач ээ.

Яагаад гээд тэгэхээр Эрчим хүчний яам нь ийм төслүүдийг хэрэгжүүлэе гээд л явуулдаг. Санхүүжилт нь ч байхгүй. Тэгээд л хасагддаг.

Тэгэхээр техникийн хувьд л Эрчим хүчний яам дэмжлэг үзүүлж ажиллахаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ төслүүд хэрэгжих үү, хэрэгжихгүй юу. Одоо энэ 38 төсөл зөвхөн 2025 оны төсөв дээр байж байгаа байхгүй юу. Хөгжлийн төлөвлөгөө дээр. 38 төсөл, 35 төсөл.

Тэгтэл 4 жилийн төлөвлөгөө дээр чинь эндээс чинь маш их төслүүд байгаа. Тэгээд тэр болгон дээр л нарийвчилсан юм хийгээд бид бүхэнд харуулаач ээ л гэж ингэж хүсээд байгаа байхгүй юу. Тийм. Ийм л саналтай байна. Тэгвэл та бүхний ажил чинь арай жаахан бодитой, ард түмэн ч та бүхний яриад байгаа уриа лоозонд жоохон ч гэсэн итгэлтэй болно шүү дээ.

Р.Сэддорж: М.Энхцэцэг гишүүн үг хэллээ.

Эдийн засаг, хөгжлийн яам хамтарсан Засгийн газрын хамгийн чухал яамны нэг. Тэгээд өнөөдөр анхны яамдуудын нэг болж манай Эдийн засгийн байнгын хороон дээр мэдээллээ хийсэн Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр сайд болон яамны хамт олон харьяа байгууллагын хүмүүстээ баярлалаа.

Тэгээд гишүүдээс гарч байгаа чухал чухал санаанууд байна. Тэгээд энэ 14 мега төслийнхөө бид 2 дээр нь одоо яг ойрын өдрүүдэд ажиллаж байна. Монгол Улсын Их Хурал.

Тэгээд бусад юмнуудаа эрэмбэлээд Засгийн газраас яаралтай оруулж ирэх байх гэж хүлээж байгаа. Тэгээд боломж бол байгаа. Тэгээд боломжийг эмх цэгцтэй энэ аймаг орон нутагтайгаа хамтраад төр, хувийн хэвшлийн түншлэлээрээ хийгээд явахад бидэнд огт боломжгүй орон биш ээ.

Тэгээд манай М.Бадамсүрэн гишүүний хэлсэн тэр жишээ бол том жишээ. Тэгээд Чойбалсан хот 600 гаруй километрийн зайтай. Тэр олон хүн ам суурьшдаг зүүн бүсийн тулгуур аймгуудын нэг. Онгоц буух боломжгүй байна гэдэг бол бид энэ дээрээ хамгийн сайн анхаарах ёстой ийм зүйл ээ.

Тэгэхээр энэ 21 аймгийнхаа төвийг ядаж онгоцны буудал эд нарыг нь сэргээж, энэ өрсөлдөөнд хэдүүлээ аваачих хэрэгтэй байх гэж үзэж байна.

Тэгээд энэ бол аялал жуулчлал, энэ бол гадаад харилцаа, маш олон төрийн бодлогууд зөвхөн онгоцны буудлаар жишээ авахад байгаа учраас яамны бодлого чиглэлд нэлээн чухал зүйл болж энд яригдаж байна гэдгийг хэлье.

Тэгээд яамны хамт олонд амжилт хүсье. Та бүгд маань энэ цаг үеийн Монголын толгой эдийн засагчид цугларчихсан байгаа гэдгийг бид мэдэж байгаа. Тэгээд та бүхнийхээ ажилд амжилт хүсье. Баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Тав.Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад, дотоод өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох

Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад дотоод өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Сангийн яамны мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат мэдээллийг танилцуулна.

Сангийн сайд чухал ажлаар явж байгаа учраас өнөөдөр энэ хуралд бас хараахан амжаагүй. Ийм учраас Төрийн нарийн бичгийн дарга мэдээлэл хийнэ.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат. 4 номерын микрофоныг нээе.

Ж.Ганбат: Улсын Их Хурлын гишүүдийн оройн амар амгаланг айлтгая.

Сангийн яамны хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөгөөний удирдлагын тухай хуульд зааснаар Сангийн яамтай яг хамаарах асуудлуудыг 2024 оны хэрэгжилтийн талаар товч танилцуулъя.

Энд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны хөгжлийн бодлого, богино хугацааны хөгжлийн бодлого гээд гол нь богино хугацааны хөгжлийн бодлого бол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нэгдсэн төсвөөр тухайн жилийнхээ арга хэмжээг хэрэгжүүлж байгаа. Дунд хугацаанд “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гээд, тэгээд урт хугацааны хөгжлийн бодлого нь “Алсын хараа-2050” гэдэг энэ хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсын хөгжлийн бодлого баримт бичгүүдийг ингэж бид гурав хувааж авч үзэж байгаа.

Нийтдээ Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөн дээр 8 тэргүүлэх чиглэл, 53 зорилт, 194 арга хэмжээтэйгээр Улсын Их Хурлаар батлагдсан байгаа.

Энэ дээр экспортыг нэмэгдүүлэх зорилт бол экспортыг 13.7 тэрбум ам.долларт хүргэнэ гэж тооцсон. Хөрөнгө оруулалтыг 4 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьсан. Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах нь 92 дугаар эрэмбэлнэ гээд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт нь 1.3 сая жуулчдыг хүлээж авна.

Хүнсний хангамж аюулгүй байдлыг сайжруулах хүнсний хангамж аюулгүй байдлын индексийг 57.6 хувь дээр өгнө. Улаанбаатар хотын түгжрэл агаарын бохирдлыг бууруулахад хотын хөгжлийн үзүүлэлт 0.6 оноо байхаар, засаглалын үзүүлэлтийг сайжруулах дээр Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт нь 100 дугаар эрэмбэлэгдэнэ.

Ногоон хөгжлийг дэмжих зорилт нь байгаль орчны гүйцэтгэлийн индекс 130 дугаарт эрэмбэлэгдэнэ гэдэг ийм зорилтууд тавьсан байгаа.

Бид сая 2024 оны Монгол Улсын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд урьдчилсан гүйцэтгэлээр ямархуу үр дүнтэй гарсан бэ гэдэг дээр ярья. Энэ яах вэ дараа нэг гүйцэтгэл эцэслэгээ гарахаар тоо хөдөлнө.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 82.4 их наяд төгрөг, эдийн засгийн өсөлт 5 хувьтай, инфляц 6.7 хувьтай. Нийт экспорт 15.8 тэрбум ам.доллар, нийт импорт 11.6 тэрбум ам.доллар гэдэг ийм үр дүнтэйгээр гарсан байгаа.

Нүүрс биет хэмжээгээрээ 83.9 сая тонн нүүрсийг Монгол Улс экспортолсон байна.

Зэс 1 сая 720 мянган тонн зэс экспортолсон. Газрын тос 4 сая тонныг экспортолсон. Төмрийн хүдэр 7.5 сая тонныг 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр экспортод гарсан ийм үзүүлэлттэйгээр 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр гарсан.

Гол экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тэргүүлэх чиглэлийн хамгийн эхний номерт экспортыг нэмэгдүүлэх чиглэлийн 2024 онд саяын хэлдэг 84 сая тонн гээд хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байгаа.

Зорилт дээр нүүрсний экспортын биет хэмжээ 50 сая тоннд хүргэнэ гэснийг бол 84 сая тоннд хүргэсэн.

Экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдийг хэрэгжүүлж, тээврийн салбарын ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ гэсэн. Энэ дээр боомтуудыг холбосон авто зүйн бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилтийн хувь нь 31 хувьтай.

Энэ дээр Баян-Овоо сумаас Ульхан боомт хүртэл хатуу хучилттай 50 километр авто замын төсөл нь дотроо 2 багцтай. 2024 онд 20.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон ийм гүйцэтгэлтэй байна.

Мөн Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавирга боомт хүртэл хажуучлалтай 124.5 километр авто замын төсөл нь дотроо 4 багцтай. 2024 онд бол 27.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гүйцэтгэл нь 24 хувьтай гарсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны талаар товч мэдээлэл өгье. 2024 онд уул уурхайн бүтээгдэхүүн нүүрсийг 22.4 сая тонныг биржээр арилжсан байна. Төмрийн хүдрийн баяжмалын 2.4 сая тонн, жоншийг 17.6 мянган тонн, зэсийн баяжмалын 5.4 мянган тонн тус тус арилжааг биржээр арилжсан ийм үр дүнтэй гарсан байна.

Дараагийн тэргүүлэх чиглэлийн хоёр дахь нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ийм зорилт байгаа. Энэ хүрээнд хөрөнгө оруулагчдад дэмжлэг үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг бизнесийн үйл ажиллагааг эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ гэж ийм зорилт тавьсан.

Энэ хүрээнд татварын бодлогоор хөрөнгө оруулалтыг дэмжих цогц арга хэмжээнүүдийг авч ирсэн. Энэ дээр хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдох орлогын албан татварыг 2027 он хүртэл 90 хувь, 2029 он хүртэл 50 хувь тус тус хөнгөлөх. Үүнийг хэрэгжүүлсэн. Мөн нээлттэй компанийн хувьцааны ногдол ашгийн татварыг дотооддоо 10 хувь, гадаадад 20 хувь байсныг нийтлэгдэд 5 хувь болгон бууруулагдах байдлаар. Энд уул уурхайн салбар хамаарахгүй. Уул уурхайн салбараас бусад нийтлэг 5 хувь байдлаар хөрөнгө оруулалтыг дэмжсэн ийм бодлого хэрэгжүүлсэн.

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогын албан татвараас чөлөөлж байна.

Мөн гарааны компаниудын орлогод ногдох албан татварыг байгуулагдсанаас хойш 3 жилийн хугацаанд хөнгөлдөг зохицуулалтыг 5 жил болгон нэмэгдүүлсэн. IT компаниудын гадаадад шилжүүлэх гүйлгээний суутган татварын хувь хэмжээг 20 хувь байсныг 5 хувь болгож бууруулсан. Ийм байгаа.

Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнийг дагаж өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар 2024 оны 5 сард эцэслэн батлуулсан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Улсын Их Хурлын 2024 оны 4 сарын 19-ний өдөр хуралдаанаар батлуулсан. Уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сан нь Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангаас бүрдэхээр ингэж зохицуулалтыг нь хийж үүнийг хэрэгжүүлж эхэлсэн.

Дараагийн хөрөнгө оруулалт нэмэгдэх чиглэл дээр эрчим хүчний салбарт шинэчлэлт хийх шилжилтийн үеийн зардал 131.1 тэрбум төгрөг 2024 онд төсвийн тодотголоор шийдвэрлэсэн.

Мөн 2024 оны батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон дараах арга хэмжээнүүд байна. Үүнд, Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийг 2022-2025 онд гэдэг. Энэ дээр санхүүжилтийг 48.3 хувь, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Замын-Үүд чөлөөт бүсийн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор хатуу хог хаяглахад дахин боловсруулахад төвийг барьж байгуулах болон чөлөөт бүсийн тогтвортой менежментийн тогтолцоог бүрдүүлж, боомтын нэвтрэх системийг хөгжүүлэхэд ийм арга хэмжээг 2020-2026 онд хэрэгжүүлсэн. Энэ дээр 8 хувийн гүйцэтгэлтэй.

Барилгын ажлыг нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах болон хилийн нэгдсэн удирдлага, модулийн өргөтгөл, гадаад иргэний мэдээллийн нэгдсэн сан хөгжүүлэх зэрэг ажлуудын санхүүжилтийг олгосон ийм байдалтайгаар дүгнэж байна.

Даатгалын салбарын шинэчлэл дээр зорилт бол урт хугацааны даатгалын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэдэг ийм зорилт байгаа. Энэ хүрээнд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2024 оны 12 сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.

Гол өөрчлөлт даатгалын нөхөн төлбөр олгох босгох үзүүлэлтийг малын хорогдолтой уялдуулж уян хатан тогтоох, даатгалын нөхөн төлбөрийг гэрээний хугацаанд нэг удаа хэсэгчилсэн урьдчилгаа олгох зэрэг ийм гол өөрчлөлтийг оруулж байгаа.

Мөн Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж 2025 оны эхний хагас жилд багтаан Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Даатгалын үйл ажиллагааг цахимжуулах, даатгалын үнэлгээ, хураамж тооцох, итгэлцүүр хэрэглэх аргачлалыг шинэчлэх, албан журмын даатгагчтай холбоог өөрчлөн зохион байгуулах зэрэг шинэлэг зорилтуудыг тусган энэ хуулийн төслүүдийг боловсруулаад байна.

Тэргүүлэх чиглэлийн гуравдугаарт Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна гэсэн байгаа.

Энэ дээр гол зорилт нь нийгмийн хамгааллын салбарт нийгмийн даатгалын оновчтой тогтолцоог бий болгож, төрийн албан хаагчийн цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн зорилтот бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг

сайжруулна гэдэг энэ зорилт байгаа. Энэ зорилтын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэх, хот тохижилтын ажилчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн. Бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлсэн.

Орон нутгийн нэмэгдэл хөдөө орон нутаг дээр хөдөөгийн сумдад ажиллаж байгаа бол сар бүр үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвийн сум, нийслэл, алслагдсан 3 дүүрэгт сар бүр үндсэн цалин дээр нь 20 хувийн нэмэгдэл олгож ажилласан.

Энэ хүрээнд жишээ нь тэр төрийн албан хаагчдын хот тохижилт болон бусад төрийн албан хаагчдын нэмэгдэлийн хүрээнд төрийн албан хаагчдын дундаж цалин сая 880 мянгаас 264 мянгаар нэмэгдээд 2 сая 144 мянга болсон байгаа.

Тэр орон нутгийн нэмэгдлийг сумын Засаг даргын Тамгын газар болон мэргэжилтэн ТЗ-9-ийн ангилал дээр ирсэн. Сая 705 мянган төгрөгийн цалин авдаг байсан бол 352 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2 сая 57 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн.

Өндөр настны тэтгэврийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн. Энэ хүрээндээ өндөр настны дундаж тэтгэвэр 685.6 мянган төгрөг байсныг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 785.6 мянган төгрөг болгосон.

Мөн түүнчлэн дараах тэтгэмжийг нэмэгдүүлсэн. Нийгмийн халамжийн тэтгэврийг 15 хувиар, асаргааны тэтгэмжийг 10 хувиар, амьжиргаа дэмжих тэтгэмжийг 15 хувиар нэмэгдсэн. Асаргааны тэтгэмж 275 мянган төгрөг байсныг 27.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлээд 302.5 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн байгаа.

Мөн эрүүл мэндийн салбарт 3.1 сая төгрөгийг зарцуулсан ийм байдалтай байна. Эрүүл мэнд дээр эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж өвчлөлт нас баралтыг бууруулна гэсэн. Энэ хүрээнд бид 3.1 их наяд төгрөгийг зарцуулсан ийм үр дүнтэй байна.

Дараагийн тэргүүлэх салбар хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна гэсэн. Хүнсний хангамж хүн амын хүнсний хэрэгцээний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн импортын хамаарлаа бууруулж нийлүүлэлтийн сүлжээ аюулгүй байдлыг хангана гэдэг ийм зорилт тавьсан. Хэрэгжилт нь нэмэгдсэн өртгийн албан татвараас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж болон бордоог чөлөөлсөн.

Мөн хүн амын зайлшгүй хэрэгцээний мах, сүү, хүнсний ногоо, жимс зэрэг 28 төрлийн хүнсний бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Эрүүл мэнд боловсрол зэрэг 19 нийтийн үйлчилгээг мөн чөлөөлөх ийм арга хэмжээг авч үзсэн. Нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 онд нийтдээ 151.6 тэрбум төгрөгийг, чөлөөлөлтийн 11 мянга 106 татвар төлөгчид хамруулж олгосон байна.

Мөн тоног төхөөрөмжийн чөлөөлөлтийнх 20.4 тэрбум төгрөгийг 357 аж ахуйн нэгж иргэнд олгосон байна. Хүнсний бүтээгдэхүүн дээр 131.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг 10 мянга 749 татвар төлөгчид эдлүүлсэн ийм байдалтайгаар нөөцөд чөлөөлж.

Гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлж байгаа. Үүнд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж. Энд 59 аж ахуйн нэгжид 2.1 тэрбум төгрөгийн гаалийн албан татварын хөнгөлөлтийг эдлүүлсэн байна.

Мөн борлуулалтын орлогын татварыг 50 хувиар хөнгөлсөн. Үйлдвэрлэсэн буюу тариалсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг 50 хувиар хөнгөлөх хүрээнд 59 аж ахуйн нэгжид 3.1 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлтийг эдлүүлсэн байна.

Дараагийнх нь, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд хөдөө аж ахуйн салбарт урамшуулал олгож байгаа. Үүнийг Та бүгд мэдэж байгаа. Бид урамшуулал олгох хүрээнд улаан улаан буудайн урамшуулалд 643 тариалан эрхлэгч аж ахуйн нэгжид 20.4 тэрбум төгрөг, хүнсний ногооны урамшууллын 2071 тариалан эрхлэгчид 20.3 тэрбум төгрөг, сүүний урамшууллын 10 мянга 370 малчин эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч давхардсан тоогоор 16.3 тэрбум төгрөгийн урамшууллыг олгож эдлүүлсэн байна.

Мөн түүнчлэн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Хоршооны гишүүд малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгосон. Энэ хүрээнд зээлийн хүүгийн хөнгөлөлтийг 3124 зээлдэгчид 120.9 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийг эдлүүлсэн.

Шинэ хоршоо чинээлэг малчин арга хэмжээний хүрээнд 2024 онд 680 доллар нэр төрлийн зээлийг олгосон.

Тэгээд зээлийн хүүгийн хөнгөлөлтийг 2324 хоршооны гишүүн малчинд 25.1 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийг эдлүүлсэн ийм үр дүнтэй ажиллажээ.

Дараагийн тэргүүлэгч чиглэл нь засаглалын үзүүлэлтийг сайжруулна гэдэг ийм зорилт тавьсан. Энэ хүрээнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр хадгалж сайжруулна гэдэг гол зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээндээ 2020 онд Fitch болон S&P агентуудаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 10 жилийн дараа B+ тогтвортой түвшинд хүргэж ахиулсан ийм үзүүлэлттэй ажилласан.

Энэ хүрээнд үндэстэн дамнасан компаниуд татвараас зайлсхаас урьдчилан сэргийлэх холбогдох олон улсын стандартад нэвтрүүлсэн гадаадын хөрөнгө

оруулалтыг нэмэгдүүлэх, зээлийн нөхцөлийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой байдлыг бататгах боломжийг бүрдүүлсэн Fitch агентлаг Монгол Улсын Хөгжлийн банк, ХААН банк болон Хас банкны урт хугацааны зээлжих зэрэглэлийг ахиулах В+ тогтвортой хэмээн үнэлсэн. Moody's агентлаг Голомт банкны зээлжих зэрэглэлийг В2 болгож нэмэгдүүлсэн гэдэг ийм үр дүнтэй ажилласан. Бид дэвшүүлсэн зорилтоо бүрэн хангаж ажилласан.

Тэгээд 10 жилийн дараа зээлжих зэрэглэлийг В1 тогтвортой түвшинд хүргэж ахиулж ажиллаж ингэж чадсан.

Дараагийн зорилт бол ногоон хөгжлийг дэмжинэ гэдэг ийм зорилт байгаа. Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгална гээд.

Энэ хүрээндээ Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Төрийн банкны ногоон хөгжлийг дэмжигч банк болгож өөрчлөн зохион байгуулсан байгаа. Энэ хүрээндээ ногоон ирээдүй, ногоон бондыг гаргаж 10 тэрбум төгрөгийг татан төвлөрөлт яг энэ зорилтын хүрээнд татан төвлөрүүлсэн байгаа.

Мөн Монголын ногоон санхүүгийн корпорац төр, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад суурилсан 50 сая ам.долларын гарааны хөрөнгөтэй үүсгэн байгуулах асуудлыг шийдвэрлэн энэ хүрээнд Засгийн газрын тогтоолоор Засгийн газраас хариуцах 13 сая ам.долларын санхүүжилтийг олгоод байна.

Мөн түүнчлэн тэрбум үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд 2024 онд улсын төсвөөс 45.1 тэрбум төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газруудад 63 тэрбум төгрөг зарцуулсан ийм үр дүнтэй ногоон хөгжлийг дэмжиж ажиллажээ.

Дараагийнх нь, Монгол Улсын 2024 оны төсөв байгаа. Төсөв Улсын Их Хурал батлагдаад хэрэгжүүлсэн. 2024 оны батлагдсан нийт орлого 30.6 тэрбум байсан. 2025 онд 36.4 их наяд гээд 5.8 их наядаар нэмэгдүүлж баталсан. Өмнөх оноос. 2025 онд. Тэнцвэржүүлсэн орлого 2024 онд 28.9 тэрбум их наяд төгрөг байсан бол 2025 онд 33.5 их наядаар 4.6 их наядаар нэмэгдүүлсэн. Нийт зарлагаа 2.9 их наядаар нэмэгдүүлж, төсвийн суурь тэнцэл 1.6 хувь байсан энэ ингээд энэ хэмжээнд алдагдлыг яг батлагдсан. Төсвийн тогтвортой байдлын шаардлага гэсэн. 2025 оны төсвийг алдагдалгүй баталсан ийм үр дүнтэй төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3 их наяд 100 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж ажиллаж. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нь 1.3 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжиж. Үүнээс зам гүүрийн 107 төслийг хэрэгжүүлэхэд 502.6 тэрбум төгрөг, 156 сургуульд зориулж 280 тэрбум төгрөг, цахилгаан дулаан хангамжийн 55 төсөлд 215.2 тэрбум

төгрөг, 77 эмнэлгийн барилгын санхүүжилт 136.2 тэрбум төгрөгийг ингэж санхүүжүүлж.

Мөн улсын хэмжээнд 149 цэцэрлэгт 114.5 тэрбум төгрөг, 64 соёлын төв, музей, театрт 91.6 тэрбум төгрөг, инженерийн дэд бүтцийн 73 төсөлд 278.3 тэрбум төгрөг, дотуур байрны 46 барилга 45.6 тэрбум төгрөг, 63 спорт заалны цогцолборт 64.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлж ажиллажээ.

Гадаад зээл, тусламжаар 2024 онд 98 зээл, нийт төслийн тоо нь 98 төслийг зээлээр, 47 төслийг тусламжаар, нийт 135 төслийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн. 2024 оны гадаад зээлээр хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэл 93 хувьтай, тусламжийн гүйцэтгэл 78 хувьтай, нийт 90 хувийн гүйцэтгэлтэй гадаад зээл, тусламжийн хэрэгжүүлэлт хийсэн. Үүнээс томоохон гадаад зээл, тусламжаа хэрэгжүүлж байгаа. Төслүүдийн гүйцэтгэлийн хувьд Бүгд Найрамдах Солонгос Улсын хөгжлийн түншийн зээлээр Солонго-1, 2 орон сууц барих төсөл, Улаанбаатар хотын усан хангамжийг нэмэгдүүлэх төсөл, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл: Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл, эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуулах төсөл, Улаанбаатарт, Дархан чиглэлд нэмэлт хоёр эгнээ зам барих төсөл гээд энэ төслүүдийн санхүүжилтийг ер нь 100 хувь санхүүжүүлж ажилласан.

Дараагийн асуулт нь, Засгийн газрын өр байгаа. Засгийн газрын өрийн дарамтыг 2024 онд бууруулж ажилласан. Засгийн газрын өрийн үлдэгдлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 2016 онд 93.1 хувьтай тэнцэж байсан бол 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 42.3 хувь болгож бууруулсан байна.

Өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд Хуралдай бондын 169 сая ам.долларын хуваарьт төлбөрийг 2024 оны 3 дугаар сард төлж барагдуулсан бөгөөд 2026-2027 онд төлөгдөх хуваарьтай Номад Сенчерийн нэг бондын төлбөрөөс 98 сая ам.долларыг Беларус Улсад төлөх төлбөр болох 11 сая еврог хугацаанаас нь өмнө бүрэн төлж барагдуулсан.

Дараагийн асуудал нь өр хөрвүүлэх хэлэлцээр байгуулж ажилласан. Энэ хүрээнд Германы KfW банк глобал сантай хамтран хамтран өр хөрвүүлэх арга хэмжээний хэлэлцээрийг хийж, гадаад зээлийн төлбөрийг Монгол Улсад эрүүл мэндийн төсөл хэрэгжүүлэх буцалтгүй тусламж болгох 29 сая еврогийн гэрээг 2024 оны 12 сарын 09-ний өдөр байгуулж ажилласан байгаа.

Тэгээд 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийтлэлийн 42.3 хувь болгож бууруулсан. Ийм үр дүнтэй ажилласан. Анхаарал хандуулсанд баярлалаа. Товчхон мэдээлэл өгөхөд ийм байна.

Р.Сэддорж: Ж.Ганбат даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга.

Сангийн сайдын хийх ёстой Сангийн яамны мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Д.Энхтүвшин гишүүнээр тасалж байна. М.Энхцэцэг гишүүнээр тасалж байна.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Тайлантай танилцлаа. Их ойлгомжтой сайн тайлан бэлдсэн байна.

Нэг ийм асуулт байгаа юм. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дээр ихэнх тендерийн ажлыг ерөнхийдөө Сангийн яам хуваарилахдаа 3 жилээр хуваарилаад байх шиг байгаа юм.

Тэгэхээр 2 жилийн дотор дуусах боломжтой ажил 3 жил болчхоор гүйцэтгэгч талдаа нэлээн хүндрэлтэй ийм байдал. Ялангуяа одоо жишээлбэл манай Дорнод аймгийн тэр Чойбалсан-Хавирганы чиглэлийн зам 3 жилээр хийгдчихсэн байдаг. Жишээлбэл, 2025 онд Булганы тэр нэг замын засвар гэхэд чинь 3 жил. 30 километр замыг.

Тэгэхээр энэ дээр ер нь цаашдаа Сангийн яам энэ хугацаан дээр тухайн ажлын онцлогоос хамаараад үүнийг багасгах тийм бодлого баримтлах уу? Энэ дээр ер нь яагаад дандаа 3 жилээр явдаг юм бэ гэдэг нэг ийм асуулт байгаа юм.

Р.Сэддорж: 4 номер. Ж.Ганбат дарга.

Ж.Ганбат: Хөрөнгө оруулалтын ажлыг жигд хуваарь. Мэдээж төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгө хомс. Яг тэгж шаардсан хэмжээ учраас төсвийн хуульд өөрчлөлт оруулаад сүүлийн хоёр, гурван жил тэнцүү хэмжээгээр хуваарилна гээд хуульд өөрчлөлт. Энэ дагуу хуваарилж байгаа юм.

Гэхдээ яах вэ бид яг төсвийн гүйцэтгэл. Дараагийн нэг төсвийн хууль дээр тэр зохицуулалт бол Засгийн газарт нэг ийм эрх байгаа. Төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүйгээр аль сайн гүйцэтгэлтэй явж байгаа хөрөнгө оруулалтын санхүүжилтийг тааруу явж байгаа гүйцэтгэлийг нь шилжүүлэх байдлаар зохицуулдаг нэг ийм заалт байгаа юм.

Яах вэ энэ хүрээндээ бид одоо зохицуулаад явж байгаа юм. Аль болох илүү сайн түлхүү явж байгаа гүйцэтгэлтэйг нь бид илүү түлхүү санхүүжүүлээд зохицуулдаг. Тэгэхдээ төсөвт өртгийг нь нэмэгдүүлэхгүйгээр.

Дараагийн нэг асуудал нь л яах вэ бидний зорилго бол яах вэ, ер нь яг үнэхээр тухайн төслийг гүйцэтгэж байгаа компаниудын чадамж, олон хүчин зүйлээс хамаарч байгаа юм. Үнэхээр яг нэг компанийн. Одоо жишээ нь 2025 онд бүрэн дуусна гээд 100 хувь тавьчихдаг. Тэр дуусаж чадахгүй бол дараа жил рүүгээ шилжих гээд ийм хүндрэлтэй байгаа учраас бид үүнийг аль болох тэр тендерийн явцтай нь уялдуулж байгаад төлөвлөхдөө үнэхээр хэрэгжилт нь сайн явж байгаа газруудыг 100 хувь дуусахаар байна. Аль болох л удаан олон жил сунжруулахгүйгээр богино хугацаанд дуусгах гэдэг ийм байдлаар бодлого барьж байгаа. Цаашдаа ч үүнийгээ яг энэ тухайн худалдан авалт зарласан төслийн хэрэгжилттэй уялдуулан энэ хугацааг тооцож байгаа нь зүйтэй юм гэдэг ийм л байр суурийг барьж байгаа.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: 2024 оны гүйцэтгэл жишээлбэл 3.5 их наяд байж байгаад 3.1-тэй гарч байгаа юм байна шүү дээ.

Тэгэхээр тэр хэмнэж байгаа 400 тэрбум байна шүү дээ. Түүн дээр тухайн тендерийн ажлын гүйцэтгэл нь хэрвээ гайгүй байх юм бол тухайн жилийн төсөвлөсөн мөнгөнөөс илүүг хуваарилж болно гэж ойлгож болох уу?

Р.Сэддорж: Хариулт 4 номер. Ж.Ганбат дарга.

Ж.Ганбат: Яах вэ, төсөвт өртөг нь Улсын Их Хурлаар батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүйгээр, тэр дүн хэтрүүлэхгүйгээр санхүүжих дүнг нь нэмэгдүүлээд явах бүрэн бололцоотой байгаа. Тэр зохицуулалт гэж миний хэлээд байгаа нь.

Түүнээс биш яг төсөвт өртгийг нь нэмэгдүүлэх эрх зөвхөн бол Улсын Их Хурал дээр л байгаа учраас бид тэрийг авч үздэггүй. Зүгээр санхүүжих дүнг бид зохицуулаад яваад шийдвэрлээд байдаг ийм хуулийн зохицуулалт байгаа.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Энэ төрийн ачааллыг жоохон хөнгөлөх хүрээнд орон нутгуудыг дэмжих асуудлын талаар л бид л ярих гээд байна л даа.

Тэгээд энэ хүрээндээ энэ уурхайн салбарт Үндэсний баялгийн сангийн хууль хэрэгжиж байна. Ер нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг илүү төрийн эзэмшлийн 34 хувьд ногдуулах шилжилт эхэлж байна.

Тэгээд энэ хүрээндээ орон нутгийг жоохон бие даалгах бодлогын хүрээнд

▶ Нэгдүгээрт, томилгооны эрх мэдэл.

- ▶ Хоёрдугаарт нь, өмчийн эрх мэдэл.
- ▶ Гуравдугаарт нь, хамгийн гол нь санхүүгийн эрх мэдэл л хэрэгтэй байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр яах вэ, тодорхой өөрчлөлтүүд, эерэг зүйлүүд хийгдэж байгаа. Үүнийг үгүйсгэхгүй. АМНАТ-ын төлбөрөөс тусгай зөвшөөрлийн орлогын төлбөрөөс хуваарилдаг зүйл бол бас эрс өөрчлөлтүүд хийгдсэн. Гэхдээ л орон нутгийн удирдлагаар ажиллаж байсан хувьд миний хэлж байгаа зүйл нь энэ улсын төсвөөс хэт хараат байдлаасаа 100 хувь ерөөсөө салж чадахгүй байгаад байна.

Тэгээд үүнийг шийдэж чадахгүй болохоор бүх ачааг нуруун дээрээ үүрээд л төр бүгдийг өөрөө зохицуулах гээд л. Тэгээд л үүнийгээ чадахгүй үүндээ түүртээд л.

Тэгэхээр үүнийг орон нутгуудад үүнийг оновчтойгоор төсвийн эрх мэдлийг өгөх. Тэгэхдээ эргээд нөгөө талд нь үүнийгээ сайжруулах, хяналтаа сайн тавих энэ зүйл рүү ер нь шилжилт хийхэд ер нь цаашдаа ямар бодлого барих вэ? Бусад олон орлогууд орон нутгийн орлогод шилжчихсэн л дээ. Энэ бол дэвшилттэй. Гэхдээ үүнийг цаашдаа дараагийн түвшний шинэчлэлт нь юу байх вэ. Энэ дээр Сангийн яам маань ямар бодлого барьж байгаа болоо. Нэг.

Хоёрдугаарт нь, тохируулгуудыг заавал хийх шаардлагатай нь л харагдаад байна л даа. Амьдрал дээр. Жишээлбэл, өнгөрсөн онд өвс, тэжээлийн үнэ тэнгэрт хадсан. Гэтэл энэ жил өнөтэй сайхан өвөл болж байгаа учраас, дээр нь “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд олон хоршоонд зээл олгогдож, хадлан тэжээл их хэмжээгээр бэлдсэнтэй холбогдуулаад өвс, тэжээлийн үнэ маш бага байгаа энэ цаг үед нь төр авч нөөцөлж дараагийн ээлжид ийм үнийн тохируулга хийж, хямд үнэтэй байхад нь худалдаж аваад буцаагаад ирэх жилүүдэд өвөлжилтийн бэлтгэл хангах үед нь нийлүүлэлт хийх бодлогыг төрөөс хэрэгжүүлэхгүй бол энэ жил ганцхан үнэтэй байгаа юм шиг бодоод байж болохгүй.

Хоёрт, олон зээл аваад хадлан бэлдчихсэн иргэд, тэгээд зах зээлд борлогдохгүй байгаа иргэд маань дахиад л ийм хямралт байдал руу орох вий.

Тийм учраас энэ дээр ийм зохицуулалт хийх ямар бодлого ер нь барьж байгаа вэ?

Гуравдугаарт нь, экспорттой холбоотой өндөр ургацтай жил нь экспортолдог энэ зохицуулалтуудыг хийх. Өвсөө экспортлох. Жишээлбэл. Тэгээд орлого олоод эргээд үүгээрээ дахиад нөөцөө бүрдүүлэх. Тухайн жилдээ өөр өөр байна.

Р.Сэддорж: 4 номер. Ж.Ганбат дарга.

Ж.Ганбат: Байгалийн баялагтай холбоотой орон нутгийн харилцааг зохицуулахаар ер нь нэлээн олон жил энэ дээр аягүй олон зохицуулалт хийж байсан. Зарим нэг нь үр дүнтэй болж байсан, зарим нэг нь хэрэгжилтээрээ ингэсэн.

Тэгэхдээ үүнээс гадна яах вэ бид татварын бодлого дээр орон нутгийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, орон нутаг өөрсдөө бизнес, ажлын байраа нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг орон нутагт үлдээх гээд юм байгаа.

Гэхдээ энэ дээр яах вэ бид бололцоотой аймгуудад үлдээх, үлдээж өгөх, хуваарилах, орон нутгийн орлого олох байдлыг нь нэмэгдүүлэх гээд олон арга хэмжээ авсан. Гэхдээ энэ дээр нэг л асуудал байгаа юм. Бид орон нутаг дээр жишээ нь ийм практикууд байгаа. Яг өмнөх жилүүдэд гарч байсан юм. Орон нутаг жишээ нь Сүхбаатар аймаг дээр нэг томоохон “Цайрт минерал” цайр нь өндөр байхад Сүхбаатар аймаг чинь аягүй өндөр орлоготой болчихож байгаа шүү дээ. Бие даачхаж байгаа юм. Гэтэл яг оны дундуур биднээс хамаарахгүй гадаад хүчин зүйлээс хамаараад нөгөө цайрын үнэ нь буурна. Тэгэнгүүт Сүхбаатар аймаг өөрөө тэр орлогоороо өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахаа болиод хүнд байдалд орчихож байгаа байхгүй юу.

Гэтэл бид зөвхөн Сүхбаатар аймгаас болоод Монгол Улсын төсөв, нэгдсэн төсөвт тодотгол хийх нөхцөл рүү явчих гээд. Бид үүнийг зохицуулах үнэхээр боломжгүй учраас тэр харилцааг буцааж байсан юм. Жишээ нь.

Яах вэ өнөөдөр ингээд гадаад хүчин зүйл, янз бүрийн олон шалтгаанаас хамаараад уул уурхайн үнэ харилцан адилгүй байна л даа.

Тэгэхээр үүнийг яаж эрсдэлээс хамгаалж байж орон нутгийн төсвийг тогтвортой байлгах вэ гэдэг энэ л асуудал байгаа юм. Энэ хүрээнд л бид энэ дээр. Нэг дэх шалтгаан энэ.

Хоёр дахь нь дараагийн нэг асуудал байна л даа.

Монгол Улс нэгдсэн улс. Холбооны улс биш. Жишээ нь, Дорнод аймагт байгаа газрын тосны ордууд зөвхөн Дорнод аймгаас гадна Монгол Улсын өмч учраас орлогын тэгш хуваарилалт гэдэг ийм асуудлууд үүсээд байдаг учраас энэ бүгдийг үзэж байгаа.

Ер нь бидний барьж байгаа бодлого бол ер нь орон нутаг бие даах гэдэг ийм л зорилго тавьж байгаа юм. Болж өгвөл орон нутагт өгч байгаа санхүүгийн дэмжлэгийг бууруулах, орон нутаг өөрсдөө бие дааж орлогын бааз сууриа нэмэгдүүлэх, тэрийгээ бүрэн хураадаг, энэ хэмжээн дээр ажлын байраа нэмэгдүүлж тухайн орон нутаг хөгжих нь зүйтэй юм гэдэг ийм байдал дээр Сангийн яамных бодлого явж байгаа.

Р.Сэддорж: Нэмж хариулах уу? 3 номер.

Ж.Ганбат: Өвс тэжээлийн хувьд ийм байгаа. Засгийн газраас.

Р.Сэддорж: 4 номер.

Ж.Ганбат: Жишээ нь, өвс тэжээлийн хувьд ер нь Засгийн газраас оролцоод, шийдвэрлээд, нөөцөөс болон улсын нөөц болон Засгийн газар нөөц хөрөнгөөс дэмжлэг үзүүлээд явж байгаа олон юм байгаа юм.

Гэхдээ сүүлийн үед барьж байгаа бодлого орон нутаг өөрсдөө үүнийгээ хангаад ажилла гэдэг энэ бол хамгийн зөв шийдэл юм билээ шүү дээ. Үнэхээр орон нутаг бид өөрсдөө төсвийг нь хянаад Сангийн яамнаас төсөв хянахдаа яах вэ суурь зарлага дээр нь Засаг даргын нөөц хөрөнгийг дандаа нэмэгдүүлж байгаа. Орон нутаг өөрсдөө нөөцөө бүрдүүлэх. Мэдээж бүх аймаг харилцан адилгүй учраас тухайн орон нутгийн онцлогтой хамаараад л тэр өвс тэжээлийн нөөц байна уу, бусад нөөц, шаардлагатай нөөцөө бүрдүүлэх юмаа өөрсдөө аймаг тэндээ зохих зохион байгуулаад үүнийгээ бүрдүүлээд ингээд аваад явах л зүйтэй байдаг юм.

Түүнээс яг улсын хэмжээнд нэгдсэн журмаар гэдэг маань харилцан адилгүй. Сая өнгөрсөн жилийн зуд энэ тэр бол бас бид нарт асар өндөр сургамж болсон. Бид энэ хүрээнд даатгалыг яаралтай нэвтрүүлж энэ дээр даатгалыг боловсронгуй болгох нь зүйтэй юм гэдэг ийм.../минут дуусав/

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Би асуултаа жоохон л оновчгүй л асуучих шиг боллоо л доо.

Нэгдүгээрт, Газрын тосны орлого, газрын тосны баялаг бүх ард түмний өмч мөн. Нэгдмэл улс. Гэхдээ сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт нь тэр иргэдийн амьжиргааг дэмжих, байгаль орчныг хамгаалахад нь зориулж 30-аас доошгүй хувийг хуваарилдаг олон улсын жишгийг хэрэгжүүлэх талаар цаашид анхаараач ээ гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа юм.

Тэгэхээр Төрийн нарийн бичгийн даргын хувьд та энэ дээр анхаарч өгөөч ээ. Яах вэ, бусад сөрөг нөлөөлөлд өртөөгүй газрууд гайгүй л дээ. Энэ утгаар нь. Гуравны нэгийг нь гэсэн үг шүү дээ.

Хоёрдугаарт нь, өвс тэжээлийг үнэ хямдтай нийлүүлэлт ихсээд эрэлт багасчихсан үед нь үүнийг иргэдийн амьжиргааг, аж ахуйн нэгжийн амьжиргааг хамгаалах чиглэлээр экспортод гаргах. Нэг удаа энэ жилийн хувьд. Эсвэл төр үүнийг тодорхой хэмжээнд худалдаж авч нөөцөлж тэртээ тэргүй ирэх онд зарцуулах юм чинь. Энэ нь өөрөө маш олон тэрбум их наяд төгрөгийн алдагдлыг.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер хариулъя.

Г.Золбоо: Гишүүний асуултад хариулъя.

Бид Орон нутгийн хөгжлийн сан дээр жишээлбэл газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сандаа авч

байгаад тэндээс тодорхой хувийг нь яг энэ газар нутгийн олборлолт явуулж байгаа аймгуудад түлхүү хуваарилахаар анхны Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр 2022 онд орж ирсэн. Та өөрөө мэдэж байгаа байх. Энэ асуудал Улсын Их Хурлын чуулган дээр ажлын хэсгийн хүрээнд дахиж яригдаад, тэгээд яг энэ газрын тосны нөөц ашигласны төлбөрөөс тухайн нөлөөлөлд автаж байгаа 2 аймагт хуваарилах байсан асуудлыг өөрчлөгдөөд Улсын Их Хурлаар батлагдсан.

Тэгээд Сангийн яам бид үүнийг мэдээж хууль хэрэгжүүлэх ёстой байгууллагын хувьд Улсын Их Хурлаар батлагдсан хувилбараараа төсвийн төслүүдээ боловсруулаад оруулж ирээд явж байгаа.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн хариулт хангалтгүй байна гэж үзэж 1 минут.

М.Бадамсүрэн гишүүн 1 минут.

М.Бадамсүрэн: Яах вэ, би нөгөө нэг валютын интервенци хийнэ гэдэг шиг төр чинь иргэдийнхээ амьжиргааг хамгаалах ёстой учраас ийм илүүдэлтэй байгаа үед нь үүнийг экспортлох, эсвэл үүнийг төр зохицуулалт хийх гэдэг л энэ зүйл яриад байгаа. Бүх юмыг хувийн хэвшил гээд байхад төр хамгаалж зохицуулалт хийх үүргээ, бодлогын зохицуулалт хийх үүргээ биелүүлэхгүй болохгүй байна л даа.

Тийм учраас Сангийн яамны харьяанд Гаалийн ерөнхий газар байгаа. Экспорт, импортын асуудал, төсвийн орлого, иргэдийн амьжиргаатай холбоотой асуудал учраас энэ зүйл дээр ойрын хугацаанд арга хэмжээ авч Засгийн газарт танилцуулж, энэ дээр анхаараач ээ л гэж байгаа юм.

Тэгээд яах вэ, орон нутагт зовлон бэрхшээл үзсэн хүний хувьд би үүнийг ойлгоод байгаа юм.

Тэгээд удахгүй энэ чиглэлээр нэлээн асуудал тавигдаад л ирнэ л дээ.

Тэгээд тэрний өмнө би гишүүний үүргээ биелүүлж энэ зүйлийг Та бүхэндээ сануулж хэлж байгаа юм.

Р.Сэддорж: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт.

Д.Энхтүвшин: Та бүхний энэ оройн амгаланг айлтгая.

Танилцуулга маань ерөнхийдөө маш тодорхой байсан учраас танилцуулга 2024 оны гүйцэтгэлтэй холбоотой танилцуулгаас асуулт байхгүй байна.

Нэг тодруулах юм байна. Сая он солигдох мөчид Монгол Улсын Ерөнхий сайд татвар нийгмийн даатгалын шинэтгэлийг хийнэ. Үүнийг хаврын чуулганаар хэлэлцэнэ гэдэг ийм асуудал ярьсан. Тэрийгээ суурилахдаа аж ахуйн нэгжүүдийн санал дээр суурилна гэсэн ийм асуудал яригдсан.

Тэгэхээр энэ талаар тодруулах гэсэн юм. Өнгөрсөн чуулганууд дээр шинэ парламент бүрдсэнээс хойш татвар, нийгмийн даатгалтай холбоотой асуудлууд дээр нэлээн олон удаа ярьж байсан. Одоо үүнийг тодорхой хүү, хэмжээний хувьд ч гэсэн буулгах бололцооны талаар нэлээн асууж байсан.

Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч гэсэн яг энэ талаар тодорхой хувь, хэмжээний өөрчлөлт гэхээсээ илүү бусад арга, аргачлалын хувьд, төлөлтийн хувьд ч бусад өөрчлөлт шинэчлэлтүүдийг хийх боломжтой гэдэг байдлаар Сангийн яамнаас Сангийн сайд ч гэсэн, Сангийн яамнаас ч гэсэн тийм танилцуулгууд хийж байсан.

Гэтэл Ерөнхий сайд одоо аж ахуйн нэгжийн хувьд баяртай мэдээ. Тэгэхдээ Сангийн яамныхны хувьд ярьж байсан юмнаас ингээд аж ахуйн нэгжүүдийн санал дээр үндэслээд гэхээр мэдээж хувь хэмжээ буулгах асуудал яригдана.

Тэгэхээр энэ асуудал дээр Сангийн яам ямар байр суурь, бодолтой байгаа вэ? Энэ талаар асуулт байна.

Р.Сэддорж: 4 номер Ж.Ганбат дарга.

Ж.Ганбат: Сая он солигдогчид Ерөнхий сайд энэ талаар мэдээлэл өгсөн.

Сангийн яамны байр суурь ийм л юм ярьж байгаа. Бид судалгаа хийнэ. Эхний ээлжид. Жижиг бизнес, дундууд яах юм, том бизнес салбараараа уул уурхай, хүнс, хөнгөн энэ тэр гээд энэ дээр яг үнэхээр бизнес эрхлэгч нар яг юу хүсээд байгаа юм бэ гэдэг дээр нь эхлээд судалгаа хийе гэж байгаа юм.

Энэ хүсээд байгаа саналуудыг нь нэгтгэж байгаад нөгөө талдаа бид яг энэ хүсээд байгаа энэ хэрэгжүүлэх юмнуудыг бид яах ёстой вэ гэдэг бодлогоо тодорхой болгоё гэж байгаа юм. Гэхдээ ний нуугүй хэлэхэд бид төсвийнхөө орлогыг харна. Мэдээж бизнес эрхлэгчид татвар төлөхгүй. Тэгээд хамгийн багадаа татвар төлөхийг зорино шүү дээ.

Гэтэл бид нөгөө талдаа Монгол Улсын төрийн үйлчилгээг нийт иргэдэд хүргэхийн тулд мэдээж төсвийн орлогоо бодно. Энэ бүгдийг уялдуулж байгаад татварын шинэчлэлийг хийнэ гэдэг ийм төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа.

Тэгээд эхний ээлжид судалгаагаа нэлээн нарийвчилж гаргаад судалгаан дээрээ нэлээн дэлгэрэнгүй байдал талаар судалгаа хийгээд тэрний дүгнэлтийг нь гаргаж байгаад тэгээд салбар салбараар нь аж ахуйн нэгжүүдтэй нэлээн ярилцаад саналыг нь сонсож байгаад ер нь ойлголцсон яг ийм байдлаар шинэчлэлээ хий гэдэг ингэж үзэж байгаа.

Ялангуяа нийгмийн даатгалын хувь хэмжээний хувьд нийгмийн даатгалын шимтгэлийн шинэчлэлийн хувьд нэлээн олон жил тогтвортой энэ хувь хэмжээ нь явчихсан. Далд эдийн засаг их байгаа. Үүнийг нөгөө талдаа бид далд эдийн

засгийг ил болгосноороо орлого нэмэгдэх бааз суурь ямар байна гэдгийг тооцож үзнэ. Яах вэ, 2007, 2008 оны үед хийж байсан татварын хуулийн шинэчлэлийн үр дүнд шинэ төсвийн орлого буруу гээд нэмэгдэж байсан энэ тэр сайн талууд байдаг л даа.

Тэгэхээр гол бид судалгаа тооцооллуудыг илүү бодитой хийж байж энэ илүү үр дүнтэй. Хоёр талаасаа ялангуяа гол гол татварууд дээр ойлголцоод явах нь зүйтэй юм гэдгийг ийм байдлаар ажлаа төлөвлөөд эхнээсээ уулзалтууд юмнуудыг нь хийгээд явж байгаа.

Тэгээд яах вэ үр дүн гарах дээр аяндаа Засгийн газрын түвшиндээ яриад Улсын Их Хурал дээр нэлээн нээлттэйгээр ил тод ер нь ширээ тойрч сууж байгаад ингэж шийдэл гаргая гэдэг ийм төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Д.Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Өмнө нь татвартай холбоотой хуулиуд дээр ер нь Сангийн яам Засгийн газар л санаачилж голдуу гарч байдаг.

Тэгэхээр яах вэ, Ерөнхий сайдын хэлсэн үгэн дээр онцлогдож байгаа юм нь болохоор аж ахуйн нэгжүүдийн санал дээр үндэслэж гэж.

Тэгээд түүн дээр нь үндэслээд зарим гишүүд хүртэл НӨАТ-ыг 5 хувь болгоё гэсэн хуулийн төсөл санаачилж байна. Тэгэхээр яах вэ, төлөвлөж байсан төлөвлөлт төлөвлөгөөнүүд гэж өмнө нь ярьж байснаа гэнэт жишээлбэл улс төрийн шинжтэй ч юм уу иймэрхүү мэдэгдэл гаргачихаар Сангийн яам төсөв энэ юманд чинь одоо ингээд төвөгтэй байдаг юм биш биз дээ. Хэрвээ боломжтой байсан юм бол үүнийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ та хэд өмнө нь яагаад ярьж болоогүй юм бэ?

Тэгээд гэнэт бэлэг бэлдэж байгаад Ерөнхий сайд маань гаргаж ирэв үү? Эсвэл та хэд маань үүнийг бид хэдээс нуугаад хэлэхгүй ийм боломжгүй гэж чуулганд дээр. Жишээлбэл, би одоо яг санаж байна. Г.Лодойсамбуу гишүүн бүр асууж байсан шүү дээ. Тэгсэн чинь Б.Жавхлан сайд НӨАТ дээр, татвар дээр хувь.../минут дуусав/

Р.Сэддорж: 4 номер Ж.Ганбат дарга.

Ж.Ганбат: Ер нь энэ зүгээр улс төрийн үгээр, бас нэг сэтгэлийн хөөрлөөр мэдээллүүд хийгээгүй л гэж бид үзэж байгаа.

Ер нь татвар, нийгмийн даатгалаар олон улсын байгууллагууд, бизнес эрхлэгч гээд асар олон судалгаа, тооцоолол юмнууд байдаг. Жишээ нь, ялангуяа өнгөрсөн өмнөх парламентын түвшинд НӨАТ-ын хувь хэмжээтэй нэлээн өргөн дэлгэрэнгүй хэлэлцүүлгүүд хийсэн. Олон улсын байгууллагууд, жишээ нь Олон Улсын Валютын Сангийн зүгээс танай төсвийн тогтвортой орлогын эх үүсвэр бол жишээ нь НӨАТ юм гэдэг ийм байдлаар үздэг. Танай НӨАТ-ын хувь хэмжээ бусад

улс орнуудтай харьцуулахад тийм өндөр биш ээ гэдэг ийм байдлаар үздэг. Гаднын олон улсын байгууллагууд болон шинжээч нарын өгч байсан дүгнэлтүүд, бид нарын өөрсдөө бас дотооддоо ажлын шугамаар Сангийн яам, татварын албаны хийсэн судалгаа энэ тэр гээд байдаг л даа.

Тэгэхээр яах вэ, бид мэдээж яг түрүүн миний хэлсэн бизнес эрхлэгч нар хамгийн бага татвар төлөхийг хүснэ. Бид мэдээж төсвөө, орлогоо бодно, илүү тогтвортой байхаа бодно.

Тэгээд яах вэ, хоёр талаас үүнийгээ ярилцаад.../минут дуусав/

Р.Сэддорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Ингээд нэлээн дэлгэрэнгүй танилцуулга хийсэнд баярлалаа.

Би гурван асуулт тавья.

Нэгдүгээрт, үндсэн чиглэлийн хүрээнд эрчим хүчний салбарын хувьд дотоодын хэрэгцээг бүрэн хангана, эрчим хүчийг экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн ийм хоёр зорилтыг 2024 онд тавьсан юм байна л даа.

Тэгээд эх үүсвэрийн хүрээнд Эрдэнэбүрэн, 10 аймгийн дулааны станц, Чойр-Сайншандын шугам гээд ийм 3 ажил хийсэн гээд энэ тайлан дээр тусгагдсан байна.

Тэгэхээр миний асуулт яг энэ дотоодын хэрэгцээг бүрэн хангах хүрээнд яг ямар ажлуудыг 2024 онд хийсэн юм? Яг энэ зорилт чинь Та бүхэн хэдэн хувийн биелэлттэй байгаа гэж үзэж гаргасан юм бэ?

Хоёрдугаарт нь, эрчим хүч экспортлох тэр суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Та бүхэн 2024 онд ямар ажлуудыг хийсэн юм бэ? Энэ тайлан дээр ямар нэгэн юм тусгагдаагүй байна.

Мөн эрчим хүчний Салбарын 2025 онд саяын төсөв ингээд ярилцаж байхад эрчим хүчний салбараас тухайлбал нийтдээ 110 ширхэг шинэ төсөл 2.9 их наядын шинэ төслийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэж байж Та бүхний тэргүүн зорилтын хүрээнд тавиад байгаа зорилтуудад хүрнэ гэсэн саналыг Сангийн яаманд хүргэсэн байгаа.

Сангийн яам энэ 110 төслөөс ерөөсөө 10-хан ширхэг төслийг нь 200 тэрбумаар хэрэгжүүлнэ гээд тусгаад бусад бүх төслүүдийг хассан байна лээ л дээ.

Тэгэхээр миний асуулт бол Та бүхэн яг энэ хасалтыг хийхдээ ямар үзүүлэлт дээр үндэслэж ийм хасаж төсвийг тусгадаг юм бэ?

Тэгэхээр энэ эрчим хүчний салбар, ялангуяа улс орныг боомилоод байгаа энэ салбарын асуудал хөгжлийн гол юм нь Та бүхний яг гарт байдаг юм байна.

Тийм учраас Та бүхэн энэ хөрөнгө санхүүг төлөвлөж байгаа үйл ажиллагаан дээрээ нэлээн хариуцлагатай хандаж, яг ийм ийм шалгуур үзүүлэлт дээр Та бүхний 110 төслөөс 100-г нь хасаад бид 10-ыг тусгасан юм.

Тэгээд саяын төсөв дээр ямар ард түмний шүүмжлэлийг хүлээсэн өчнөөн үр ашиггүй төслүүд тусгагдсан байсныг бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр энэ дээрээ Та бүхэн нэг хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Р.Сэддорж: 6 номер хариулья.

Л.Ганзориг: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг. М.Энхцэцэг гишүүний асуултад хариулья.

Өнгөрсөн жил буюу 2024 онд эрчим хүчний салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 56 төсөл, арга хэмжээн дээр 226 тэрбум төгрөг батлагдсан байсан. Гүйцэтгэл 90 хувьтай жилийн эцсээр гарсан.

Эрдэнэбүрэний усан цахилгаан станцын төслийг Та бүхэн мэдэж байгаа. Хятадын ЭКСИМ банкны зээлээр хэрэгжихээр тусгайлсан зээлийн хэлэлцээр нь 2024 оны 11 дүгээр сард байгуулагдаад сая оны өмнө 12 сарын 30-ны өдөр Хятадын ЭКСИМ банкнаас зээлийн гэрээг хүчин төгөлдөр болголоо гэсэн мэдэгдэл ирсэн.

Энэ төслийн урьдчилгаа төлбөрт бид төсвийн тодотголоор нийтдээ 256 тэрбум төгрөг шийдүүлсэн байсан. Тэгээд энэ санхүүжилтийг ЭКСИМ банк руу хийж өгөөч ээ гэсэн хүсэлтийг манайхаас явуулсан байгаа.

Тэгээд Хятадын ЭКСИМ банкнаас Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг шийдвэрлээд явна.

Багануур, Чойрын төсөл Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны зээлээр хэрэгжиж байгаа. Эрчим хүчний яаман дээр тендерийн худалдан авалт хийгдээд одоо гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдээд явж байна.

Улсын төсвийн 2025 оны төсвийн санал дээр таны хэлснээр эрчим хүчний салбараас ирсэн төслүүдийг бид бүгдийг нь салбарынх нь төсвийн ерөнхийлөн захирагчийн буюу эрчим хүчний сайдаас ирсэн хүсэлтийн дагуу Төсвийн тухай хуулийн гол шаардлагууд болох зураг төсөвтэй юу, тухайн бэлтгэл ажил нь бүрэн хангагдсан уу гэдэг гол шалгуур үзүүлэлтийг авч үзнэ.

Дээрээс нь манай “PIMIS” гээд улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем байгаа. Энэ системээр хоёр үе шаттай бид бүх төслүүд дээр үнэлгээ хийж байгаа.

Тэгээд энэ үнэ үнэлгээний бас нэг гол үзүүлэлт нь сая дурдсан тэр зураг төсөвтэй байх эсэх гээд газар чөлөөлөлт гэх мэтчилэн бүх асуудлуудыг бид суурь болгож цахим системээрээ үнэлгээ хийгдээд төслүүдийг 2025 онд шинэ төсөлд тусгасан байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: М.Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

М.Энхцэцэг: Нэгдүгээр асуултын хувьд яг энэ дотоодын хэрэгцээг бүрэн хангах гэсэн энэ зорилтын хэдэн хувийн биелэлттэй байгаа гэж гаргасан. Тэрийгээ хэлээч ээ. Экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэхэд ямар ажил 2024 онд хийсэн юм бэ гэсэн. Үүнийг хэлээч ээ гэсэн.

Тэгэхээр танай бүхний хариултаас энэ 110 төслийн 100 төсөл нь Та бүхний ярьж байгаа зураг төсөвгүй юм байна, бэлтгэл нь хангагдаагүй юм байна гэсэн хариулт өгч байна гэж ойлгож байна. Энэ зөв үү?

Тэгээд дараа нь би нэг асуултыг асууя гэж бодсон. Энэ тээвэр, ложистикийг сайжруулна гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна л даа.

Тэгэхээр Дэлхийн банкнаас гаргасан судалгааны хүрээнд 139 орноос манайх 90-д жагсаж байгаа юм байна. Казахстан 79, Узбекистан 88. Тэгэхээр 2024 оны хувьд ложистикийн индекс манайх яг хэдэн хувиар өссөн юм бэ?

Тэгээд ер нь ойрын хугацаанд ядаж Төв Азийн орнуудынхаа түвшинд хүрэх тийм боломж бололцоо байгаа юу? Яагаад гэвэл нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол тулгуур бол тээвэр ложистикийн асуудал байгаа.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер.

Г.Золбоо: Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо гишүүний асуултад хариулъя.

Тээвэр, ложистикийн асуудлыг яг одоогийн байдлаар манай Сангийн яаман дээр энэ мэдээлэл байхгүй байна.

Яагаад гэвэл энэ мэдээлэлд бид өнөөдрийн энэ Эдийн засгийн байнгын хороон дээр танилцуулсан танилцуулгыг бэлтгэхдээ 2024 оны жилийн төлөвлөгөө буюу хамгийн богино хугацааны жилийн төлөвлөгөө дээр туссан зорилтуудыг хэрэгжүүлэхэд санхүү, төсөв, татвар даатгалын бодлогын хэрэгжилтийг танилцуулсан.

Тэгэхээр бид тэр хүрээнд ерөнхийдөө мэдээллээ бэлдсэн байгаа юм. Тэгэхээр таны асууж байгаа тээвэр, ложистикийн индексийн хэдээр яаж өссөн талаарх мэдээллийг бид Эдийн засгийн яамнаас аваад танд тусгайлан дараа нь энэ мэдээллийг өгөх боломжтой байх гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Нэг ийм богинохон асуулт байна.

Энэ хөрөнгө оруулалтуудын ер нь гацсан, царцсан, шүүхийн шийдвэр дээр байгаа нөгөө компани нь алга болчихсон тийм төслийн тоо, хөрөнгө оруулалтын хэмжээ байгаа юу?

Концесс дээр тийм юм байгаа юу? Хугацаа хэтэрсэн, алга болсон. Энэ чинь Сангийн яаман дээр байгаа юу? Ийм мэдээлэл байвал асуух гэсэн юм.

6 номер.

Б.Ганзориг: Улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр царцсан объектууд, үнийн өсөлтийг шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа хэд хэдэн объектууд байгаа.

Гэхдээ Улсын Их Хурлын тогтоол гараад энэ оны нэгдүгээр улиралд багтааж энэ үнийн өсөлт буюу төсөвт өртөг нь нэмэгдсэн объектуудыг Үндэсний аудитын газартай хамтраад. Өмнө нь нэг ийм тохиолдол явсан. Төсөв өртөг дээр нь Үндэсний аудитын газраас дахин нягталж үнийн өсөлтийг нь тогтоосны дараа улсын төсөв дээр бид тусгаж явсан. Яг үүнтэй адилаар Их Хурлаас сая төсөв батлагдахтай холбоотой гарсан 54 дүгээр тогтоол дээр энэ оны нэгдүгээр улиралд багтааж Улсын Их Хуралд танилцуулах чиглэл өгөгдсөн байгаа.

Тэгэхээр судалгааны ажлууд эхнээс нь хийгдээд эхэлсэн явж байгаа. Яагаад гэхээр бид 2025 оны төсөв дээр ямар нэгэн үнийн өсөлтийг шийдвэрлээгүй.

Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолын дагуу Засгийн газар дээр энэ бүх мэдээллүүдийг нэгтгээд Улсын Их Хуралд энэ оны нэгдүгээр улиралд танилцуулна.

Тэгэхээр бэлтгэл ажлууд хийгдээд явж байна.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Сангийн сайдын яамны мэдээлэлтэй холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Д.Энхтүвшин гишүүнээр тасалъя. М.Бадамсүрэн гишүүн нэмье. Г.Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе.

Ер нь яамдаас хамгийн сайн ажил хийж байгаа нь бараг Сангийн яам байх гэж боддог юм. Танилцуулж байгаа материал нь товчхон, тодорхой, слайдтайгаа. Тэрийгээ урьдчилаад явуулчихдаг. Энэ үлгэр жишээг бусад яамдад нэвтрүүлэх боломж байна уу гэдэг дээр нэг тийм санал байна.

Та хэд маань бид ингэж ажилладаг юм аа, бусад яамд ингээд ажиллаачаач ээ гээд нэг хэлээд өгчихмөөр байх юм. Тийм. Тэгэхгүй бол бусад нь А4 дээр, word

дээр нэг шивсэн юм оруулж ирээд л, тэгээд тэрийгээ ч харахгүй, уншихгүй тэгээд л нэг сонин сонин юм яриад сууж байдаг нэг тийм юм байгаад байгаа юм.

Энэ дээр яах вэ нэг төрлийн магтаал, нөгөө талын санал байгаа юм.

Хоёр дахь санал байна. Сая төсвийг хоёр, гурван удаа ч хэлэлцээд танай яам нэлээн ачаалалтай ажилласан байх. Баяр хүргэе.

1 дүгээр хавсралт дээр санал би маш их өгч байгаа юм. **KPI** [Key Performance Indicators] шүү дээ. Тийм ээ. Шалгуур үзүүлэлтээ зөв хийе ээ гээд. Танай дээр хамгийн эхлээд нэг базагдаад тэгээд Их Хурал руу өргөн барьж байгаа гэж бодож байна.

Яамдуудаас өргөн бариад ирж байгаа гэж ойлгож байгаа л даа. Харваас логикийн алдаатай юмнууд зөндөө байгаад байгаа шүү дээ. 40 гаруй хувь нь яагаад ч тэр төсөл, хөтөлбөрүүдийн үр нөлөө, үр дүнг хэмжих боломжгүй. Өндрийг нь хэмжинэ гэсэн килограммаар зорилтоо тодорхойлно гэсэн. Бараг иймэрхүү хэмжээний логикийн алдаатай юмнууд байгаа. Тэрийг бас бусад яамдууддаа та хэд маань энэ бодлогын яг ийм төв яамны хувьд сайн хэлж өгөөд.

Тэгэхгүй бол би сая төсөв дээр бараг арван хэдэн зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа байхгүй юу. Ийм нэг жижиг сажиг ийм ажлуудыг уг нь танай яам дээр нэг цэвэрлээд ороод ирчихдэг бас их баярламаар байгаа.

Тэгээд дараачийн бас нэг санал байна. Төсвөө дунд хугацаандаа төлөвлөдөг болмоор байгаа юм. Манай энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, төсөв энэ тэр бас л зуун задгай шүү дээ.

Дунд хугацааны зорилтот хөтөлбөр гээд 8 төрлийн салбарын хөтөлбөрүүд зохиох ёстой гэсэн. Одоо хүртэл эдийн засгаас бусдыг нь зохиогоогүй. Үлдсэн 7 салбар нь хаашаа явах гэж байгаагаа ч мэдэхгүй.

Тэгээд “Алсын хараа-2050” гэдэг ганцхан үгийг л сайд болгон яриад суугаад байдаг.

Уг нь жил болгоны хөгжлийн төлөвлөгөө гэж зохиохгүйгээр 5 жилийн хөтөлбөр ч юм уу, Засгийн газрын хөтөлбөртэйгөө уялдуулаад төсөв нь 3 жилээр ч юм уу. Тийм ээ. Зохиогоод явчихдаг.

Тэгээд жил болгондоо update хийгээд шинэчлээд явчихдаг тийм байдал руугаа орох юм том мега төслүүд хэрэгжих, тогтвортой хэрэгжих боломж нь бүрдэж байгаа гэсэн тийм бодлогын чанартай өөрчлөлтүүдийг Эдийн засаг, хөгжлийн яам ч байдаг юм уу. Тийм ээ. Тэдэнтэйгээ цуг хамтраад хийх боломж байгаа болов уу, үгүй юу гэсэн нэг тийм санал байгаа юм.

Тэгээд удахгүй манай Эдийн засгийн байнгын хороо очиж ажиллана гэж сонссон. Тэр үед нь миний энэ хэлсэн саналууд дээр боломжтой эсэх, эсвэл ямар нэгэн ажил төлөвлөж байгаа эсэх мэдээллийг өгвөл баярлахаар байна.

Баярлалаа. Орой хүртэл ингэж сууж байгаад.

Р.Сэддорж: Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Г.Лувсанжамц гишүүн бараг миний хэлэх гэж байгаа санаануудыг хэлчихлээ. Сангийн яамны хувьд сая өнгөрсөн жил нэлээн идэвхтэй, ачаалал өндөртэй ажилласан. Бараг 4 ч төсөв хэлэлцэж батлуулж ажилласан.

Тэгэхээр энэ явцдаа Улсын Их Хурлын гишүүддээ бас их ийм ойрхон хамтарч дэмжиж туслах, асуудлаа шийдлээ зөв гаргахын төлөө ингэж ажилласан хандлагууд харагдсан. Тэгэхээр энэ хандлагад талархсанаа илэрхийлье гэж бодож байсан. Тийм боломж олдоогүй.

Тэгээд танай яамны хамт олонд яг энэ хууль тогтоох үйл явцад, ялангуяа шинэ гишүүдийг мэдээллээр хангах, мэдлэг мэдээлэлжүүлэх тал дээр тийм сэтгэлээсээ хандаж ажилласанд танай хамт олонд талархсанаа илэрхийлмээр байна.

Тэгээд энэ жилийн төсвийн хувьд хэдүүлээ бид хэд өнгөрсөн жил тодорхой хэмжээний ойлголттой болчихсон. Тэгэхээр энэ жилийн хувьд төсвийн бэлтгэл гэх юм уу даа. Наана нь эртнээс гүйцэтгэлүүд дээрээ, тэгээд бусад төсвийн урьдчилсан асуудлууд дээрээ нэлээн нээлттэй хамтарч ажиллана байх гэж найдаж байна.

Тэгээд Г.Лувсанжамц гишүүн сая хэлсэн. Би тийм саналыг хэлье гэж бодож байсан юм. Уг нь яамдууд энэ хөгжил түвшнүүд нь, асуудал материал боловсруулж байгаа байдлууд нь ижил жигд байвал их амар байгаа юм.

Тэгэхээр яг танай юуг та хэд ажил ихтэй учраас бусад яамд тэрийг хэлж яриад яваад байна гэж хэцүү байж магадгүй байх. Тэгэхээр бусад яамдыг л туршлага судлуулдаг юм уу, тэр хүмүүсийг нь бэлдэх талаас нь хөндлөнгөөс нь яадаг юм уу нэг ийм боловсруулалтын чанар, тэр тоо, алдаагүй үг үсгийн хувьд ч гэсэн тооны хувьд ч гэсэн. Тэгээд энэ танилцуулж байгаа байдал, логик дарааллын хувьд ч гэсэн сайжруулах юмнууд бусад яамдууд яг танай яамнаас үлгэр авах юмнууд байна.

Тэгэхээр бусад та хэдийг бусдадаа гэхээсээ илүү бусад яамдууд та хэднээс сурч жигдрүүлээсэй гэж хэлмээр байна. Баярлалаа.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт, орлогоо нэмэгдүүлэх хүрээндээ, тэгээд зэрэгцээд иргэдийн жижиг дундаж ахуйн нэгжүүдийн хөгжлийг дэмжих асуудал их

чухал байгаа юм. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн бол ажил, хөдөлмөр хийнэ. Насанд хүрсэн хүн.

Тэгээд ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд гуравт л ямар ч улс орон хөгжлийн түвшнээс үл хамаараад дэмжлэг, туслалцаа үзүүлдэгтэй адилхан жижиг, дунд бизнес эрхлэгч, өрхийн аж ахуй эрхэлж байгаа хүмүүс рүү л чиглэсэн бодлогыг татварын бодлогоос гадна хөнгөлөлттэй зээлийн бодлого, бусад бодлогын зохицуулалтаар л их сайн дэмжих хэрэгтэй гэдэг нь л яг амьдрал дээр харагдаад байгаа юм л даа.

Тэгэхгүй болохоор яг бодит байдал дээр ямар зүйл үүсээд байна гэхээр яг ийм анхан шатад байгаа, орон нутагт байгаа, нийслэлийн дүүргүүдэд байгаа энэ жижиг, дунд бизнесийг дэмжих асуудал их хүнд байгаа. Одоо ямар зүйл үүсээд байна гэхээр нэгдүгээрт энэ орон сууцын үнэ өсөөд байгаа. Үүний нэг шалтгаан нь газраа худалдаж авахаасаа гадна асар өндөр хүүтэй зээл авч байгаа юм. Тэгээд нөгөө барилга нь ашиглалтад орох болдог. Барилгын улирлын хугацаа богино.

Тийм учраас эндээ сандраад нэг банк бусаас зээл авдаг. Тэгээд үүнээсээ болоод энэ хүү нь нэмэгдээд ингээд л орон сууцын үнэд нөлөөлөөд байгаа.

Нөгөө талдаа энэ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг жижиг, дунд бизнесийн салбарт, өрхийн аж ахуйн салбарт хангалттай хэмжээгээр гаргаж өгөх боломж Монгол Улсад би байгаа гэж бодож байгаа юм. Тэгэхгүй бол ингээд Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар гээд байна. Энэ нэг зээл өгдөг л газар болчихоод байгаа юм. Зүй нь яах ёстой вэ гэхээр Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар зөвхөн зөвлөгөө өгдөг, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг л газар байх ёстой. Одоогийн нөхцөлд. Бүр сайн нь барилгын ажил, замын ажил дээр зөвлөх үйлчилгээ гээд хяналтын ажлыг хийдэг ийм хувийн хэвшил хийдэгтэй адилхан энэ хөнгөлөлттэй зээл өгч байгаа “Шинэ хоршоо” хөдөлгөөн, жижиг дунд бизнесийн салбар дээр энэ хувийн хэвшил чинь үүнийг хийгээд явах ёстой болохоос төр хийгээд явахгүй.

Дээр нь Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар зээл олгодог газар биш байх ёстой. Энэ чинь туршигдсан шүү дээ. Сум хөгжүүлэх санд зээл олгоод тэр нь төр олгоод эргээд ингээд энэ нь дампуурангуут ер нь Сум хөгжүүлэх сан буруу юм байна гээд буруу оношилчихсон. Зүй нь Сум хөгжүүлэх санд зээл байх нь зөв. Ганцхан энд төр өөрөө зээл олгосон нь л буруу болчихоод байгаа юм.

Тэгээд үүнийгээ зөв оношлоод анхан, дунд шат руугаа буюу өөрөөр хэлбэл хүүхэд рүүгээ төр анхаардаг, аав ээж нь анхаардаг шиг ингэж анхаарал халамж тавихгүй бол энэ чинь өсөхгүйгүй байгаа.

Тэгээд энэ нь би нөгөө орлого нэмэгдэхтэй холбоотой. Өрх болгон, жижиг, дунд бизнес болгон бусад орнуудад чаддаг чаддаг юмаа хийдэг шиг ийм байдал руу оруулахгүй болохоор энэ татварын бааз суурь нэмэгдэхгүй байна. Яг үнэндээ жижиг, дунд бизнесийн зээл байгаа 50 тэрбумыг хүүгийн татааст өгөх юм энэ 400 тэрбумын зээлийн эх үүсвэр арилжааны банкны эх үүсвэрээр гарна. Энэ 400 тэрбум төгрөг эргэлтэд ороход 40 тэрбум төгрөгийн 10 хувиар бодоход л татвар

улсын төсөв, орон нутгийн төсөвт эргээд л орно. Өөрөөр хэлбэл эдийн засаг гэдэг бол мөнгө нь ингэж эргэлдэж байж үр дүн нь гардаг болохоос биш нэг газар байгаад байж болохгүй.

Тэгээд одоо жишээлбэл Банкны хуульд өөрчлөлт ороод автомашин худалдаж авахыг банк олгохоо болиод манай Л.Соронзонболд гишүүн надад энэ дээр тайлбарлаж өгч байсан. Олгохоо болиод хаачхангуут банк бус чинь олгоод байгаа.

Тэгээд банк бус дээр хаахгүй учраас хүмүүс автомашин авахдаа өндөр хүүтэй зээл аваад л байгаа. Эцсийн дүндээ капиталист гэж нэрлэж байсан, одоогоор ардчилсан, либерал гэж байгаа орнуудад нэг хэсэг мөнгө хүүлэгчид асар их мөнгө олдог байсан юм гэнэ лээ. Одоо Монголд чинь энэ салбарууд дээр ийм дорвитой томоохон шинэчлэл хийхгүй болохоор яг үнэндээ банк бусууд маш их хэмжээний орлого ороод иргэд өнөөдөр л болж байвал бүтэж байвал болоо гэдэг байдлаар хандсанаасаа болоод асар их мөнгийг иргэдийн нуруун дээр эргэж байр, барилгын метр квадратын орон сууцын үнэ болно.

Тэгээд банк бусуудад энэ хүү чинь очоод байгаа.../минут дуусав/

Р.Сэддорж: Баярлалаа.

Түрүүний нөгөө царцсан гэдэг юм уу, гацаад байгаа тэр юунуудын мэдээллээ нэгдүгээр улиралд Улсын Их Хуралд ирнэ гэж ойлголоо. Тийм ээ. Гишүүдэд ирэх юм байна. Тийм ээ. Нэгдсэн байдлаар уу? Тэгвэл манай Байнгын хорооны гишүүдэд ирнэ гэсэн үг. Тийм ээ. Энэ нь их чухал.

Тэгээд саяын гишүүдийн хэлж байгаа саналуудыг Та бүхэн маань сайн тусгаж ажил хэрэгтээ тусгана биз. Тэгээд хэд хэдэн аймгууд дээр бонд гаргаад явах ганц хоёр аймгууд боломжтой гээд байгаа. Тэрийг ард иргэд хүлээж байгаа.

Тэгээд Сангийн яам энэ дээр ажиллаж байгаа гэсэн ийм мэдээлэл авсан. Тэгээд Та бүгдийн ажилд амжилт хүсье.

Сангийн сайдын мэдээлэлтэй танилцаж дууслаа. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Хуралдаан 5 цаг 51 минут үргэлжилж, 20 цаг 43 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД